



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН
ТУШААЛ

2014 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А-117

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай


Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7.7, "Журам батлах тухай" Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал"-ыг 1 дүгээр, "Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал"-ыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Үнэлгээний аргачлалыг мөрдөж ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газар /Д.Энхбат/ -т даалгасугай.


3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын "Аргачилсан заавар батлах тухай" 2010 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А-2 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ОЮУН

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын
2014 оны 04 дүгээр сарын 1-ны өдрийн
A-117 дулааргууцалын 1 дүгээр хавсралт



БАЙГАЛЬ ОРЧНЫ СТРАТЕГИЙН БОЛОН ХУРИМТЛАГДАХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

1-Р ХЭСЭГ
БАЙГАЛЬ ОРЧНЫ СТРАТЕГИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

Гарчиг	
1.1 Товч танилцуулга.....	3
1.2. Байгаль орчны стратегийн үнэлгээний гол зорилт.....	4
1.3. Байгаль орчны стратегийн үнэлгээг гүйцэтгэхэд баримтлах зарчим, гүйцэтгэлийн шалгуур.....	4
1.4. Байгаль орчны стратегийн үнэлгээний үе шат.....	5
1.5 Байгаль орчны стратегийн үнэлгээний гол зорилт, шаардлага, үнэлгээний цар хүрээг тодорхойлох нь.....	7
1.5.1 Байгаль орчны стратегийн үнэлгээг хийхэд шаардлагатай мэдээллийн жагсаалт гаргах.....	8
1.5.2 Байгаль орчны стратегийн үнэлгээг голлон хэрэгжүүлэгч, оролцогч, сонирхогч, эрх ашиг хөндөгдөх талуудыг тодорхойлох.....	8
1.5.3 Байгаль орчны стратегийн үнэлгээний ажлын удирдамжийг боловсруулах.....	8
1.6. Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний төсөлд байгаль орчны стратегийн үнэлгээ хийх нь.....	9
1.6.1 Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний төсөлд байгаль орчны эрхзүй, стратегийн шинжилгээ хийх.....	9
1.6.2 Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд өртөх байгалийн нөөц, экосистемийн төлөв байдал, үнэ цэнэ, хэтийн хандлагыг тодорхойлох.....	10
1.6.3 Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтээс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар, болзошгүй хуримтлагдах сөрөг нөлөөллүүдийг тодорхойлж үнэлэх.....	12
1.6.4 Байгаль орчин, нийгмийн өөрчлөлтийг тодорхойлох.....	13
1.6.5 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх (зайлсхийх) хувилбаруудыг сонгох, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох.....	14
1.6.6 Байгаль орчны стратегийн үнэлгээний явц, үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг сонирхогч талууд, олон нийтэд танилцуулж саналыг тусгах.....	15
1.6.7 Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад байгаль орчны стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх.....	17
1.7 Байгаль орчны стратегийн үнэлгээний тайлангийн бүтэц, дүгнэлтийн агуулга.....	17

1.1 Товч танилцуулга

Монгол улсын Их Хурлаас 2012 оны 5 сард баталсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгад зааснаар хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг санаачлан боловсруулагч салбарын яам нь уг баримт бичгийг боловсруулах явцад байгаль орчны стратегийн үнэлгээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан мэргэжлийн байгууллага, тухайн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, бие даасан шинжээч, мэргэжилтнүүдийн багийн оролцоотойгоор хийлгэж, тайланг бодлогын баримт бичгийн төслийн хамт Засгийн газарт хэлэлцүүлэхээс өмнө байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлж дүгнэлт гаргуулахаар зохицуулсан.

Хуулийн үзэл санаа, журмын хэрэгжилтийг хангахад тухайн хөгжлийн бодлого (бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө)-ын баримт бичигт хийх байгаль орчны стратегийн үнэлгээг баталсан аргазүйн дагуу гүйцэтгэх, энэ чиглэлээр олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмж, шаардлага, аргачлал, ижил төстэй орнуудын туршлага, өөрийн орны онцлогийг харгалзан байгаль орчин, нийгэм, оршин суугчдын эрүүл мэндэд хамгийн сөрөг нөлөө багатай хувилбаруудыг сонгон оновчтой дүгнэлт, зөвлөмжийг боловсруулах нь онцгой чухал ач холбогдолтой. Байгаль орчны стратегийн үнэлгээг чанартай хийх нь төлөвлөгчид, шийдвэр гаргагчид болон тухайн шийдвэрийн нөлөөлөлд өртөгч олон нийтэд авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бодлого, шийдвэрийн талаар мэдээлж, байгаль орчин, нийгэм, оршин суугчдад хамгийн ээлтэй хувилбарыг эрэлхийлэх, сонгоход нь тус дөхөм үзүүлж, ардчилсан зарчмаар шийдвэр гаргах үйл явцыг баталгаажуулдаг. Энэ нь бодлого, шийдвэрийн үнэн зөвд итгэх олон нийтийн итгэл үнэмшлийг сайжруулж, өртөг зардлын болон цаг хугацааны хувьд үр ашигтай, байгаль орчны үнэлгээ хийх боломжийг төсөл боловсруулалтын түвшинд хангаж өгдөг.

Үнэлгээний аргачлалд үнэлгээний гол зорилт, хамрах хүрээ, баримтлах зарчим, гүйцэтгэх дараалал хандлага, үнэлгээнд ашиглах арга, аргачлал, үр дүнг тайлагнах хэлбэрийг тусган боловсруулсан болно.

БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН ЯАМ

1.2. Байгаль орчны стратегийн үнэлгээний гол зорилт

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.3.-д зааснаар “байгаль орчны стратегийн үнэлгээ” гэж улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад түүний хэрэгжилтээс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаврыг уур амьсгалын өөрчлөлтийн чиг хандлага, байгалийн гамшигт үзэгдэлтэй уялдуулан тодорхойлох үндсэн зорилготой үйл явц юм.

Мөн хуульд аливаа хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг санаачлан боловсруулагч салбарын яам нь байгаль орчны стратегийн үнэлгээ хийх багийг тухай бүр нээлттэй шалгаруулалтаар сонгож гүйцэтгүүлэх, үр дүнг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх үнэлгээний мэргэжлийн зөвлөлд хэлэлцүүлэн дүгнэлт, зөвлөмжийг уг асуудлыг хэлэлцэх Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар тус тус заасан билээ.

Байгаль орчны стратегийн үнэлгээг хийх баг нь хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах эхний үе шатнаас эхлэн түүний хамрах хүрээг тодорхойлж нөлөөлөлд өртөх байгалийн нөөц, экосистем, хүн амын эрүүл мэндийн өнөөгийн болон хэтийн төлөв байдлын үнэлгээг хийж, бодлогын арга хэмжээний хамгийн сөрөг нөлөө багатай хувилбарыг тодорхойлон байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийн зорилтыг хангах хувилбаруудыг тогтоож тайлан бичиж дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Байгаль орчны стратегийн үнэлгээний ерөнхий үйл явцыг Зураг 1.1-д харуулав.

1.3. Байгаль орчны стратегийн үнэлгээг гүйцэтгэхэд баримтлах зарчим, гүйцэтгэлийн шалгуур

Аливаа хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад байгаль орчны стратегийн үнэлгээг хийх, шийдвэр гаргахад дараах зарчмыг баримтлахаар эрхзүйн баримт бичгүүдэд журамласан. Үүнийг үнэлгээг гардан гүйцэтгэгчид, олон нийт, шийдвэр гаргагч, сонирхогч бүх талууд үйл ажиллагаандаа мөрдлөг болгох шаардлагатай.

Үүнд :


- Бодлогын баримт бичгийг боловсруулж эхлэх үе шатнаас байгаль орчныг хамгаалах, ногоон хөгжлийн зорилтыг тодорхойлж тусгах;
- Болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх хувилбарууд, түүний дотор хэрэгжүүлэхээс татгалзах хувилбаруудыг төлөвлөлтийн үед авч үзэх;
- Байгаль орчны стратегийн үнэлгээний үр дүн, дүгнэлт нь шинжлэх ухааны үндэслэл, баримт, нотолгоонд тулгуурласан байх;
- Стратегийн үнэлгээний үе шат бүрд мэдээллийг талуудад хүртээмжтэй (цахим) хэлбэрээр ил тод байлгаж, олон нийтийн оролцоог хангах;
- Оролцогч талууд үнэлгээний үйл явцад хариуцлагатай байх.

- Төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаа нь нээлттэй, ил тод байх зэрэг орно.

Мөн байгаль орчны стратегийн үнэлгээг гүйцэтгэх үйл явц болон түүний үр дүн, дүгнэлт, зөвлөмж нь юуны өмнө дараах шалгууруудыг хангасан байх ёстой. Үүнд:

Асуудлыг иж бүрнээр, олон талаас нь авч үзсэн, тогтвортой (ногоон) хөгжлийг хангахад чиглэсэн, гол асуудалдаа төвлөрсөн, хангалттай бөгөөд бодитой мэдээлэлд үндэслэсэн, гол болон хамтран хэрэгжүүлэгч талуудын хариуцлагыг тодорхой болгосон, мэдээллийн ил тод байдал, хүртээмж, олон нийтийн оролцоог хангасан байх зэрэг орно.


Зураг 1.1. Байгаль орчны стратегийн үнэлгээний үйл явцын ерөнхий бүдүүвч



1.4. Байгаль орчны стратегийн үнэлгээний үе шат

Аливаа хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь дараах нийтлэг үе шаттай байдаг. Үүнд: санаачлах, төлөвлөх, хувилбаруудыг гаргах, оновчтой хувилбарыг сонгох, шийдвэр гаргах, баталгаажуулах, барьж байгуулах, ашиглах, хаах зэрэг орно. Байгаль орчны стратегийн үнэлгээг эдгээрүйл ажиллагааны төлөвлөлтийн эхний шатанд буюу санаачлах, төлөвлөх, хувилбаруудыг гаргах, оновчтой хувилбарыг сонгох, шийдвэр гаргах, баталгаажуулах үе шатанд хийж гүйцэтгэнэ.

Байгаль орчны стратегийн үнэлгээний үйл ажиллагаа нь дараах үе шатуудыг дамжин хийгдэх ба Зураг 1.2-т үе шат бүрийн хамрах хүрээг хамтатган тусгав.



Зураг 1.2. Байгаль орчны стратегийн үнэлгээний гүйцэтгэлийн бүдүүвч

Үүнд:

1. **Байгаль орчны стратегийн үнэлгээний гол зорилт, шаардлага, үнэлгээний цар хүрээг тодорхойлох үе шат** - Энэ үе шатанд тухайн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний төслийн гол

шинжилгээ байгаль орчны стратегийн үнэлгээ хийх шаардлага байгаа эсэхийг, хэрэв байгаа бол ямар хүрээнд хийх, байгаль орчны стратегийн үнэлгээний гол зорилтуудыг тодорхойлно.

2. **Байгаль орчны стратегийн үнэлгээг гүйцэтгэх үе шат-** Энэ үе шатанд тухайн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний төсөл буюу түүний тодорхой хэсгийг хэрэгжүүлснээс тухайн нутаг дэвсгэр, бүс нутгийн байгаль орчин, нийгэм, оршин суугчдын эрүүл мэндэд үүсч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, болзошгүй сөрөг болон хуримлагдах нөлөөллийг үнэлж, сөрөг нөлөөлөл багатай хувилбаруудыг тодорхойлно. Мөн стратегийн үнэлгээний ажлын гол үр дүн, сонгосон хувилбарууд, сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, дүгнэлт, зөвлөмжийг боловсруулах зэрэг орно.
3. **Байгаль орчны стратегийн үнэлгээний явц үр дүнг мэдээлэх, хэлэлцүүлэх үе шат-** Энэ үе шатанд Байгаль орчны стратегийн үнэлгээний гол үр дүнгүүд, сонгон авч үзэж буй хувилбаруудын талаар сонирхогч талууд болон эрх ашиг нь хөндөгдөж болзошгүй иргэд, оршин суугчдад тодорхой мэдээлэл өгч стратегийн үнэлгээний үйл ажиллагаанд татан оролцуулах, тэдний санал бодлыг судалж тусгана.
4. **Хяналт, үнэлгээний үе шат-** Энэ үе шатанд Байгаль орчны стратегийн үнэлгээний гол үр дүн, зөвлөмжийн хэрэгжилт, сонгон авсан хувилбаруудын хуримтлагдсан нөлөөллийн үнэлгээг гаргаж, бодлогын баримт бичиг, байгаль орчны стратегийн үнэлгээний үнэн зөв байдал, чанарын талаар үнэлэлт өгнө.

1.5 Байгаль орчны стратегийн үнэлгээний гол зорилт, шаардлага, үнэлгээний цар хүрээг тодорхойлох нь

Байгаль орчны стратегийн үнэлгээний зорилго, зорилт, хамрах хүрээг бодитой тодорхойлж, үнэлгээний ажлын удирдамжийг боловсруулахад энэ үе шатны ажлууд чиглэгдэх ба уг ажлыг гүйцэтгэхэд доорхшаардлагуудыг хангасан байвал зохино:

- Байгаль орчны стратегийн үнэлгээний зорилгыг тухайн салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлсэнээр байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, гарах үр дагаврыг тодорхойлон үнэлж, хөгжлийн зорилтууд, түүнийг хэрэгжүүлэх хувилбаруудын учруулж болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагавраар харьцуулж шинжлэх, хамгийн оновчтой хувилбарыг тодорхойлоход чиглүүлсэн байх;
- Байгаль орчны стратегийн үнэлгээний зорилт нь хууль, эрхзүйн шаардлага болон зохих аргачлалын дагуу чанартай хийх, гол асуудлуудыг тодорхойлж, тэдгээрийг олон талаас авч үзсэн, оновчтой хувилбарыг сонгох нөхцөлийг бүрдүүлсэн, олон нийтийн оролцоо, мэдээллийн ил тод байдлыг хангахад чиглэгдсэн байх;

- Байгаль орчны стратегийн үнэлгээний хамрах хүрээ нь байгаль орчны болон тухайн салбарын хууль тогтоомжийн шаардлага, байгаль орчны талаар баримталж буй бодлого, уур амьсгалын өөрчлөлтийн хэтийн чиг хандлага, байгалийн гамшигт үзэгдлийн давтамж, учирч болзошгүй эрсдэл, хөгжлийн бодлого, арга хэмжээний цар хүрээ, нөлөөллийн бүсээр тодорхойлогдох зэрэг болно.

Үүнээс гадна доорх ажлуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай.

1.5.1 Байгаль орчны стратегийн үнэлгээг хийхэд шаардлагатай мэдээллийн жагсаалт гаргах

- Тухайн бодлогын баримт бичигт байгаль орчны стратегийн үнэлгээг хийх явцад мэдээлэл хангалттай эсэхийг тодорхойлохдоо санаачлагчаас боловсруулсан, бодлогын баримт бичгийн төсөлтэй танилцаж, хөгжлийн бодлого, зорилт, стратегийн чиглэлийг тодорхойлсон судалгааны мэдээлэл, мөн бодлого хэрэгжих бүс нутгийн байгаль орчин, эдийн засаг, хүн амын эрүүл мэндийн талаарх суурь мэдээлэл, материалууд, түүний эх сурвалжийг тодорхойлон жагсаалт гаргана.
- Нэмэлт мэдээлэл шаардлагатай бол тэдгээрийн агуулга, нарийвчлал, мэдээллийн эх сурвалжийг урьдчилан тогтоох зэрэг ажлуудыг хийнэ.

1.5.2 Байгаль орчны стратегийн үнэлгээг голлон хэрэгжүүлэгч, оролцогч, сонирхогч, эрх ашиг хөндөгдөх талуудыг тодорхойлох

- Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэгч төрийн захиргааны төв байгууллага, түүнтэй хамтран хэрэгжүүлэгчид, оролцогч, эрх ашиг хөндөгдөх болон сонирхогч талуудыг, нутаг дэвсгэр, орон зайн хамаарал, нөлөөллийн бүс, хуулиар олгогдсон эрх мэдэл, өмч хөрөнгийн баталгаа, хууль ёсны ашиг сонирхол, бизнесийн болон ёс суртахуун, түүх соёл уламжлалыг харгалзан тодорхойлно.

1.5.3 Байгаль орчны стратегийн үнэлгээний ажлын удирдамжийг боловсруулах

Дээрх алхмуудын үр дүнг нэгтгэж, тухайн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөнд хийх байгаль орчны стратегийн үнэлгээний ажлын удирдамжийн төслийг боловсруулан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлж санал авна.

Удирдамжийн төсөлд стратегийн үнэлгээний хүрээнд хийгдэх гол ажлууд, зорилго зорилтуудыг тодорхойлж, бодлогыг хариуцан хэрэгжүүлэх субъект, түүнтэй хамтран хэрэгжүүлэгч, оролцогч талууд, тэдгээрийн хамтын ажиллагааны арга хэлбэр, уг үнэлгээг хийх хуваарь, мөрдөх, ашиглах баримт бичиг, санхүүжилтийн эх үүсвэр, үнэлгээний ажлын гүйцэтгэх хуваарь, оролцогч талуудад мэдээлэл хүргэх, гол чухал хэлэлцүүлгүүдийг хийх тов, ажлын чанарын хяналтын шалгууруудыг тодорхойлж оруулна.

Мөн энэ шатанд хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг санаачлан боловсруулагч, голлон хэрэгжүүлэгч, оролцогч, хэрэгжилтийн нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд оршин суугчид, эрх ашиг нь хөндөгдөх

хамтран ажиллах, мэдээлэл хүргэх, хэлэлцүүлэг хийх, саналыг нь авах графикайг тусгах шаардлагатай.

1.6. Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний төсөлд байгаль орчны стратегийн үнэлгээ хийх нь

Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний төсөлд байгаль орчны стратегийн үнэлгээг хийхдээ доорх дэс дараалал, аргазүйн хандлагыг баримтална.

Үүнд:

1.6.1 Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний төсөлд байгаль орчны эрхзүй, стратегийн шинжилгээ хийх

Байгаль орчны стратегийн үнэлгээг гүйцэтгэх баг хамгийн түрүүнд тухайн салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний анхны төсөлд байгаль орчны стратеги, эрхзүйн шинжилгээ хийж зохих дүгнэлтийг гаргана. Үүнд

1. Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний үндсэн зорилт, стратеги түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа байгаль орчны хууль, эрх зүйн орчинтой хэрхэн нийцэж байгааг эрх зүйн харьцуулалт, эрхзүйн орчны шинжилгээ хийх замаар судалж тогтоох;
2. Байгаль орчныг хамгаалах болон бүс нутаг, хил дамнасан нөлөөллийн асуудлаар Монгол Улс нэгдэн орсон олон улсын конвенци, гэрээ хэлэлцээрүүдэд хүлээсэн үүрэгтэй хэрхэн нийцэж байгааг судалж, зөрчилтэй асуудлуудыг тодорхойлох;
3. Байгаль хамгаалал, ногоон хөгжил, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратегитай тухайн салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний гол стратеги, арга хэмжээ хэрхэн нийцэж байгааг тодорхойлох;
4. Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг батлах төрийн удирдах дээд байгууллагыг (УИХ, Засгийн Газар) тодорхойлох зэрэг орно.

Эдгээр шинжилгээний дүнг нэгтгэн тухайн салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний зорилт арга хэмжээ нь байгаль орчны хууль, эрх зүйн орчин болон нэгдэн орсон олон улсын конвенци, гэрээ хэлэлцээрүүдэд хүлээсэн үүрэгтэй хэрхэн нийцэж байгааг тодорхойлж дүгнэлт өгөх, хэрэв хууль болон олон улсын өмнө хүлээсэн үүрэг зөрчигдөхөөр бол хуульд хэрхэн нийцүүлэх талаар болон бодлогын баримт бичгийн төслийг дахин боловсруулах, эрхзүйн зөрчлийг арилгах зөвлөмжийг боловсруулан Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Мөн байгаль орчин, ногоон хөгжил, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох зорилго, зорилтуудтай хэрхэн нийцэж байгааг матриц, давхцуулах, харьцуулалтын аргуудыг ашиглан судалж, дүгнэлт өгч эсрэг болон нийцэхгүй зорилт, стратегиудыг ялган тодруулж, хэрхэн нийцүүлэх талаар зөвлөмж өгнө.

Хэрвээ дээрх шалгуур үзүүлэлтүүдийг тухайн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний төсөл бүрэн хангасан тохиолдолд сонгогдсон баг нь байгаль орчны стратегийн үнэлгээг доорх шат дарааллаар хийж гүй

1.6.2 Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд өртөх байгалийн нөөц, экосистемийн төлөв байдал, үнэ цэн, хэтийн хандлагыг тодорхойлох

Хөгжлийн бодлого хөтөлбөр төлөвлөгөөний төсөл боловсруулах явцад хийгдэх байгаль орчны стратегийн үнэлгээний явцад түүнийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн төлөв байдал түүний онцлогийг нь сайтар судалсан байх шаардлагатай. Энэ шаардлагаар тухайн бүс нутгийн байгаль орчны гол бүрэлдэхүүн хэсгүүдийн, тухайлбал, газрын гадарга, ландшафт, ус, хөрс, ургамал, амьтан болон хүн амын суурьшил, нутагшлын өнөөгийн төлөв байдлыг байгаль орчны төлөв байдлын үнэлгээний аргачлалын дагуу тодорхойлно. Энэ судалгааны явцад тухайн нутагт оршин суугчид, экосистемд нь онцгой чухал ач холбогдол бүхий газар нутаг, экологийн төлөв байдал, түүний хамгаалал, эмзэг байдлыг тодруулахад онцгойлон анхаарна. Мөн тухайн бүс нутагт явуулж байгаа байгаль хамгааллын үйл ажиллагаа, арга хэмжээнүүдийг авч үзэх шаардлагатай.

Байгалийн нөөц, экосистемийн төлөв байдлын үзүүлэлтүүд нь өмнөх үе шатанд тодорхойлсон стратеги үнэлгээний гол зорилт, төлөвлөлтийн авч үзэх хувилбаруудад шаардагдах мэдээллүүдийг хамарсан байх ба онцгой мэдрэмтгий бүсүүд, анхаарал хандуулах шаардлагатай биологийн олон янз байдал, экосистемийн бүрэлдэхүүнүүдийг тодорхойлж гаргасан байх ёстой. Тодорхой салбарын хөгжлийн төлөвлөлтийн хувьд түүний нөлөөлөл хамгийн их тусах орчны (хөрс, ус агаар) анхдагч буюу суурь үзүүлэлтүүдийг зохих түвшинд тодорхойлох шаардлага энд тавигдана.

Өөрөөр хэлбэл, тухайн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үед өртөх байгалийн нөөц, экосистемийн төлөв байдлын өөрчлөлтэй уялдаатайгаар нийгмийн тодорхой өөрчлөлт гарах учир хүний хөгжил болон байгаль орчны тогтвортой байдлын тэнцвэрийг хангаж байх шаардлага гарна. Үүнийг хангахын тулд доорх зурагт үзүүлсэн байдлаар асуудлыг иж бүрнээр хамруулан авч үзэж экосистемийн өнөөгийн төлөв байдал, хэтийн хандлага, үнэ цэн болон нийгмийн шууд болон шууд бус нөлөөлөл, эргэх холбоо уялдааг тодорхойлж үзсэн байх шаардлагатай.

Тухайн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, өртөх байгалийн нөөц, экосистемийн төлөв байдал, үнэ цэнэ, хэтийн хандлагыг тодорхойлох болон дээрх харилцан хамаарлыг судлахдаа байгаль орчны нөлөөллийн үнэлгээний уламжлалт аргууд, тухайлбал, экспертийн үнэлгээ, экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсгийн үнэ цэнийг тодорхойлох аргууд, байгалийн гамшгийн эрсдэлийн үнэлгээний арга, зайнаас тандах арга дээр үндэслэсэн оронзай, цаг хугацааны өөрчлөлтийн зураглалын аргууд, олон нийтийн санал асуулгын арга, мэдрэмтгий байдлын дүн шинжилгээний арга, системийн анализын аргуудаас гадна байгалийн нөөцийн эдийн засгийн үнэлгээний болон экосистемийн үйлчилгээний төлбөрийг тооцох арга, системийн тогтвортой байдлын үнэлгээний арга, ахисан түвшиний байгаль орчны загварчлал /экологийн, гадаргын болон газрын доорх усны, уур амьсгалын өөрчлөлтийн загвар гэх мэт/-

ын аргууд, сүлжээ-шинжилгээний аргуудыг ашиглана. Тухайлбал, газарзүйн мэдээллийн системийн загварын ашиглах зөвлөмжийг Шигтгээ1-д оруулав.


Шигтгээ 1

Газар зүйн мэдээллийн системийн зөвлөмж

Тодорхойлолт: Газарзүйн мэдээллийн системийг ашиглан өргөн уудам нутаг дэвсгэр дээрх хүний үйл ажиллагаа болон бусад нөлөөллөөр бий болсон өөрчлөлтүүдэд чанарын үнэлгээ өгөх боломжтой.

Үндсэн тэгшитгэл: Судалгааны зорилгоос хамаарч газар зүйн мэдээллийн системд байгаа арга зүйнүүдээс сонгон авч хэрэглэнэ (*Жишээлбэл, газар ашиглалтын өөрчлөлтийг судлахаар болон supervised/unsupervised ангилалын арга, орон зайн дүн шинжилгээнд Spatial analysis арга г.м*).

Оролтын мэдээ: Ямар дүн шинжилгээ хийх гэж байгаагаас хамаарна. Жишээлбэл, нөлөөллүүдийн орон зайн давхцалыг тодруулахад дараах мэдээллийн бааз хэрэглэгдэж болно.



Үр дүн: Энэ загвараар тухай бүс нутаг, сав газар, нутаг дэвсгэрийн орон зайн зураглалыг хийхэд хэрэглэж болно.

Боловсруулалт: Тус загвар нь Window болон UNIX-ийн орчинд ажиллана

Загварын эх сурвалж:

Тухайлбал, нийгэм, байгаль орчны түүхэн мэдээллийн параметруудийн өөрчлөлтийг, нөлөөлөлд өртөх газар нутгийн хэмжээг тодорхойлоход газар зүйн мэдээллийн системийн цаг хугацаа болон орон зайн давхцуулан зураглах аргыг ашиглах, экосистемийн төлөв байдалд үзүүлэх сөрөг болон болзошгүй хуримтлагдах нөлөөллийн цар хүрээ, хил хязгаар, эрчимшил, давтамж, үргэлжлэх хугацаа, тэдгээрийн хоорондын хамаарлыг (уур амьсгалын өөрчлөлт, агаар, хөрс, усны бохирдлын тооцоолол, байгаль орчны тэтгэх чадвар, бэлчээрийн даацын өнөөгийн болон ирээдүйн өөрчлөлтийн чиг хандлага гэх мэт) тодорхойлоход байгаль орчны загварчлал (экологийн VELMA болон Century загвар, урсацын RIBASIM, HBV, TOPLAST загвар, газрын доорх усны MODFLOW загвар, бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлтийн WRF, Hadley загварууд буюу эдгээр загвартай төстэй, дүйцэхүйц хэмжээний нарийвчлалтай)-ыг ашиглах, экосистемийн өнөөгийн болон хэтийн үнэ цэнэ, экосистемийн үйлчилгээний төлбөрийг тооцох арга зэргийг ашиглан тодорхойлж тусгана. Тухайлбал, Century загварын ашиглах зөвлөмжийг Шигтгээ 2-д оруулав.

Century экосистемийн загварын зөвлөмж

Тодорхойлолт: Тус загвар нь бэлчээрийн менежмент, нүүрстөрөгчийн чадамжийг тодорхойлоход хамгийн нийтэд өргөн ашиглагдаж байгаа загвар бөгөөд уг загвар нь ургамлын өсөлт, усны эргэлт болон хөрсний органик бодисыг загварчилдаг.

Үндсэн тэгшитгэл: $AB_c = AB_{max} * f_t(T) * f_m(M) * S_{sh}$

Үүнд: AB_{max} - газрын дээрх биомассын хамгийн их утга, $f_t(T)$ - агаарын температураас хамаарсан функц, $f_m(M)$ - усны чадамжаас хамаарсан функц, S_{sh} - ургамлын сүүдэр, ургамлын өсөлтийн нөлөөг харуулсан параметр.

Оролтын мэдээ: Тус загварыг ажиллуулахад дараах мэдээллийг ашиглана.

- Сарын болон өдрийн агаарын хамгийн их ба бага температур
- Сарын болон өдрийн хур тунадас
- Судлах газрын хөрсний механик бүтэц

Үр дүн: Энэ загвараар тухайн бүс нутаг, сав газар, нутаг дэвсгэрийн бэлчээрийн өнөөгийн болон ирээдүй төлөв байдлыг судалж, бэлчээрийн менежментийг зөв зохистой хийхэд хэрэглэж болно.

Боловсруулалт: Тус загвар нь Window болон UNIX-ийн орчинд ажиллана

Загварын эх сурвалж:

1. <http://www.nrel.colostate.edu/projects/century/>
2. <http://www.geoenv.tsukuba.ac.jp/~sugita/archive/Byambakhuu-PhD.pdf>

1.6.3 Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтээс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар, болзошгүй хуримтлагдах сөрөг нөлөөллүүдийг тодорхойлж үнэлэх

Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах явцад болон түүний төсөлд хийгдэх байгаль орчны стратегийн үнэлгээний хамгийн гол хэсэг буюу түүний байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, учруулж болзошгүй эрсдэлийг тодорхойлж үнэлэх, сөрөг нөлөөлөл, эрсдэл багатай хувилбаруудыг тодорхойлох, бодлогын хэрэгжилтийг хангах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ, тодорхой төслүүдийн шууд болон шууд бус нөлөөллийг тодорхойлж үнэлэх ажлыг энэ үе шатанд хийнэ.

Бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээ нь маш олон талтай, комплекс шинжтэй олон асуудлыг хамарсан байвал тэдгээрийн эрсдэл, сөрөг нөлөөллийг урьдчилан тодорхойлоход хүндрэлтэй болох учраас тэдгээрийг ангилж, хамгийн эрсдэлтэй хувилбаруудыг тодорхойлон тэдгээрээс үүсгэж болзошгүй хуримтлагдах нөлөөллийг авч үзнэ.

Үүнд:

- Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтээс байгаль орчин, тухайн нутаг дэвсгэр, нийгэм, хүний эрүүл мэндэд цаг хугацаа, орон зайн хувьд гарч болох эрсдэлүүдийг тодорхойлон эрэмбэлэх;
- Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтээс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд цаг хугацаа, орон зайн хувьд гарч болох бүхий л сөрөг болон хуримтлагдах нөлөөллүүдийг тодорхойлон гаргах;
- Байгаль орчин-нийгмийн тогтолцоонд гарах сөрөг нөлөөллүүд, хуримтлагдах нөлөөллүүдийн хамрах хүрээ, эрчимшлийг үнэлсний үндсэн дээр тогтвортой, ногоон хөгжлийн зорилт, шалгууруудыг хэрхэн хангаж байгааг тогтоох;

- Дээрх болзошгүй эрсдэл, сөрөг болон хуримтлагдах нөлөөллүүдийг тогтоосны үндсэн дээр хамгийн бага эрсдэл, сөрөг болон хуримтлагдах нөлөөлөл багатай хөгжлийн хувилбаруудыг тодорхойлох зэрэг орно.

Дээрх нөлөөллүүдийг тодорхойлох, үнэлэхдээ нөлөөллийн үнэлгээний уламжлалт аргуудаас тухайн асуудлын онцлогтой холбогдуулан хамгийн оновчтой нэг аргыг сонгож ашиглах шаардлагатай. Тухайлбал, эдийн засаг, нийгмийн бодлогын уялдаа, түүний байгаль орчны нөлөөллийг эрсдэлийн харьцуулсан үнэлгээ, байгаль орчны доройтлын эдийн засгийн үнэлгээ, судалгаанд суурилсан оролцооны үнэлгээ зэрэг аргуудын аль тохирохыг авч үзнэ.

Тухайлбал, экспертийн үнэлгээ, ВАТ-ВЕР, газарзүйн мэдээллийн системийн цаг хугацаа болон орон зайн давхцуулан зураглах арга, эрсдэлийн үнэлгээний аргууд, олон үйл ажиллагааны харилцан үйлчлэлийн матрицын арга, хүний эрүүл мэндийн тандалт үнэлгээний арга, зардал үр ашгийн шинжилгээ, хөгжлийн ирээдүйн хувилбарыг харьцуулах арга, нийгэм-байгаль орчны тогтолцооны эзмэг байдлын загварчлал, тогтвортой байдлын үнэлгээ, олон шалгуурт анализ, сүлжээ-шинжилгээний арга, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний аргууд зэрэг орно.

Үүнээс гадна байгаль орчин, хүний эрүүл мэнд, байгалийн гамшигт үзэгдлийн учруулж болзошгүй бүхий л эрсдэлүүдийг тогтооход эрсдэлийн үнэлгээний аргуудыг хэрэглэх, хөгжлийн олон талт хувилбаруудыг тодорхойлон гаргаж, хоорондын харьцуулалт хийхэд хөгжлийн ирээдүйн хувилбарыг харьцуулах аргыг ашиглах, хөгжлийн хувилбаруудын голлох параметруудийн хоорондын ялгаа, шинж чанарыг тодорхойлоход матрицын аргыг сонгон ашиглаж үр дүнг хамгийн бага эрсдэлтэй хувилбарыг тодорхойлоход ашиглана.

1.6.4 Байгаль орчин, нийгмийн өөрчлөлтийг тодорхойлох

Байгаль орчны стратегийн үнэлгээний зорилго, зорилт, хамрах хүрээ болон бусад бүхий л үе шатуудын хоорондын уялдаа холбоог оновчтой тодорхойлсоны үндсэн дээр тухайн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжих явцад байгаль орчин болон нийгмийн тогтолцоонд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлж, үнэлнэ. Өөрөөр хэлбэл, тухайн боловсруулж авч үзэж буй хөгжлийн бодлого болон бусад хөгжлийн бодлогын хэрэгжилтээс үүдэн тухайн бүс нутгийн байгаль орчин, нийгмийн тогтолцоонд үзүүлэх хам болон давхардмал нөлөөллүүдийн эерэг болон сөрөг талууд, нөлөөллийн эрчим, болзошгүй хуримтлагдах нөлөөллийг энэ үе шатанд тодруулна.

Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж үнэлэхэд байгаль орчин, нийгэм, эдийн засгийн төлөв байдлын үнэлгээнд тулгуурлан системийн эмзэг байдлын загварчлал, экосистемийн эмзэг байдал, дасан зохицох үнэлгээ, тогтвортой хөгжлийн загварчлалын аргуудаар байгаль орчин-нийгмийн тогтолцооны өөрчлөлтийг тодорхойлж гаргана.

Тухайлбал, улсын тогтвортой хөгжлийн болон ногоон хөгжил, ногоон эдийн засгийн макро түвшний ирээдүйн чиг хандлагыг тодорхойлоход тогтвортой хөгжлийн Т21 загварчлалыг хэрэглэх, хөгжлийн бодлого хэрэгжих үед нийгэм болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эмзэг байдлын босго утгууд болон сэргэх чадварыг тодорхойлоход байгаль орчин, нийгмийн тогтолцооны эмзэг байдлыг тооцох загварчлалыг ашиглах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хөгжлийн хувилбаруудыг тодорхойлоход экосистемийн эмзэг байдал, дасан зохицох үнэлгээний аргыг хэрэглэн тэдгээрийн үр дүнг тусгана.Тухайлбал, тогтвортой хөгжлийн Т21 загварчлалыг ашиглах зөвлөмжийг Шигтгээ 3-т оруулав.


Шигтгээ 3

Т21 загварын зөвлөмж

Тодорхойлолт: Улс орны тогтвортой хөгжлийн богино, дунд, урт хугацааны төлөвлөлтийг хийх боломжтой.

Үндсэн тэгшитгэл: Судалгааны зорилгоос хамаарч Т21 загварт байгаа модулиудаас сонгож авч хэрэглэнэ.

Оролтын мэдээ: Нийгэм, эдийн засаг, байгаль орчны статистикийн түүхэн мэдээллүүд.



Үр дүн: Хөгжлийн бодлогыг төлөвлөхөд хэрэглэж болно.

Боловсруулалт: Тус загвар нь Window -ийн орчинд ажиллана

Загварын эх сурвалж:

1. www.millennium-institute.org
2. Towards a GREEN ECONOMY. UNEP, 2012

1.6.5 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх (зайлсхийх) хувилбаруудыг сонгох, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох

Өмнөх үе шатанд хийгдсэн байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлүүдийг үнэлж хамгийн бага сөрөг нөлөөлөл бүхий сонгогдсон хувилбар, түүнийг хэрэгжүүлэх явцад үүсч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох, учирч болзошгүй эрсдлийг бууруулах оновчтой арга хэмжээг тодорхойлох нь энэ үе шатны гол зорилт болно.

Өөрөөр хэлбэл хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд талууд аль аль нь хожих (win-win) загварын нөхцөлийг бүрдүүлэх буюу эдийн

засгийн хөгжлийг байгаль хамгаалал, нийгмийн үр өгөөжтэй уялдуулан хамгийн сайн хувилбараар хөгжүүлэх нөхцөлийг энд бүрдүүлэх юм.

Болзошгүй сөрөг нөлөөлөл, болзошгүй эрсдлүүд, түүний үр дагаварт анализ хийгдсэн байх ба харьцангуй бага эрчимтэй сөрөг нөлөөллүүд, эрсдэлүүдийг тодорхойлж, тэдгээрийг бууруулах стандарт арга хэмжээнүүдийг тогтоох, боломжтой түвшинд барих арга хэмжээг энд тодорхойлсон байх шаардлагатай.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг тодорхойлоход хамгийн түрүүнд түүнээс зайлсхийх буюу урьдчилан сэргийлэх, дараа нь түүнийг бууруулах, эцэст нь нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгааллын тодорхой арга хэмжээ авах дарааллаар тодорхойлно.

Үүнд:

- Байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэлээс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, бууруулах шийдэлтэй хувилбаруудыг тодорхойлох;
- Хувилбаруудын байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөллөөр харьцуулж эрэмбэлэх;
- Сөрөг нөлөөлөл, эрсдэл хамгийн багатай хувилбарыг сонгох;
- Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээг тодорхойлох зэрэг орно.

Бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх хувилбаруудыг сонгох, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлоход хөгжлийн хувилбаруудын харьцуулалтын арга, олон хэмжээст критерийн аргууд, ВАТ-ВЕР, тогтвортой хөгжлийн болон олон талт үнэлгээний аргуудыг хэрэглэж болно.

Тухайлбал, хөгжлийн бодлого хэрэгжих бүхий цаг хугацаанд тухайн бүс нутгийн байгалийн нөөц, экосистемийн төлөв байдал, хүний эрүүл мэндэд үзүүлж болох сөрөг нөлөөллүүдийн эрчимшил, давтамжийн чиг хандлагыг тодорхойлоход системийн тренд анализын арга, түүнтэй ижил төстэй аргуудыг сонгон ашиглаж үр дүнг тусгаж болно.

1.6.6 Байгаль орчны стратегийн үнэлгээний явц, үр дүн, дүгнэлт, зөвлөмжийг сонирхогч талууд, олон нийтэд танилцуулж саналыг тусгах

Байгаль орчны стратегийн үнэлгээг гүйцэтгэх үе шатуудад гаргасан явцын тайлан, үр дүнгүүд нь олон нийт болон сонирхогч талуудад ил тод байж, тэдний санал бодлыг авч судалж тусгах нь сөрөг нөлөөлөл, эрсдэл багатай хувилбарыг тодорхойлох, стратегийн үнэлгээний үр дүн, зөвлөмжийг хэрэгжүүлэхэд онцгой чухал ач холбогдолтой учраас энэ үе шатанд оролцоог хэрхэн бий болгох, мэдээллээр хангах оролцооны арга хэлбэрүүдийг тодорхойлох, тухайн нөхцөл байдалд хамгийн тохиромжтой аргыг нь сонгоход энэ үе шатны ажлын гол зорилго оршино.

Байгаль орчны стратеги үнэлгээ хийх явцад мэдээллээр хангах, талуудын оролцоог нэмэгдүүлэхдээ бодлогын арга хэмжээнд хам

дэвсгэр, хүн амыг эхлэн хамруулж тэдэнд бодит мэдээллийг хүргэж, тэднийг оролцуулсан нийгмийн нөлөөллийн судалгаа, ярилцлага, уулзалтуудыг зохион байгуулна. Энэ үед тухайн хөгжлийн бодлогын улс төрийн болон эдийн засгийн зорилт, агуулгыг тайлбарлаж, шийдвэр гаргах тогтолцоо болон олон нийтийн саналыг шийдвэр гаргах процессод хэрхэн авч үзэх, түүний үр нөлөөг дээшлүүлэхэд голчлон анхаарах ёстой.

Стратегийн үнэлгээний эхний үе шатанд тодорхойлсон хамтран хэрэгжүүлэгч, оролцогч, бодлого, арга хэмжээний нөлөөлөлд өртөгсөд, эрх ашиг нь хөндөгдөх сонирхогч талуудад үнэлгээний явцын үр дүн болон эцсийн тайлантай танилцах боломжийг хангах шаардлагатай. Үүнээс гадна стратегийн үнэлгээний тайлангийн товч агуулгыг бэлтгэж гол асуудлууд, түүнийг шийдвэрлэх арга замын талаарх зөвлөмжийг шийдвэр гаргагчдад хүргүүлэх нь стратеги үнэлгээний үр дүн аливаа шийдвэр гаргахад тусгалаа олох, тодорхой шийдвэрт нь олон нийтийн болон оролцогч талуудын санал илүү тусах юм. Ийм учраас энэ үе шатны ажлын гол зорилго нь холбогдох хууль, журамд зааснаар байгаль орчны стратегийн үнэлгээг хийх явцад болон түүний эцсийн үр дүнг оролцогч, сонирхогч талуудад танилцуулах, тэдний санал бодлыг тусгах, шийдвэр гаргагчдад хамгийн эрсдэл багатай хувилбарыг сонгоход туслах зорилгоор олон нийтийн оролцоог хангах явдал юм.

Олон нийтийн оролцоог хангах үйл явц нь дарааллын хувьд бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, түүнд стратегийн үнэлгээ хийх явцад зэрэгцэн хийгдэж болох бөгөөд энэ тохиолдолд шийдвэр гаргагч нь тухайн үед ямар хувилбаруудыг авч үзэж байсан түүнээс байгаль орчин, нийгэм, эрүүл мэндийн ямар эрсдэлүүдийг тооцон сонголтыг хийсэн, хэрэв буруу шийдвэр гарвал ямар үр дагавартай байх талаар тодорхой мэдээллийг стратегийн үнэлгээний зөвлөмжөөс авах боломжийг хангаж өгөх ёстой.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн салбарын бодлогын баримт бичигт хийсэн байгаль орчны стратегийн үнэлгээний тайлан, дүгнэлтийн төсөл болон түүний үр дүнг тусгасан бодлогын баримт бичгийн төслийн хамт цахим хуудсандаа 14 хоногийн дотор байршуулж олон нийтийн болон оролцогч, сонирхогч талуудын саналыг авах ажлыг зохион байгуулна. Үүнээс өмнө буюу бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах шатанд хийгдсэн байгаль орчны стратегийн үнэлгээний явцын үр дүн, авч үзсэн хувилбарууд, түүний харьцуулалт болон сонгон авсан хувилбар зэргийн талаарх мэдээллийг уг бодлогын баримт бичгийг санаачлан боловсруулагч салбарын яамны цахим хуудаст, стратегийн үнэлгээг гүйцэтгэж байгаа багийн гишүүдийн олон нийтийн сүлжээний хаягуудад байршуулан саналыг нь авч тусгана.

Олон нийтийн хэлэлцүүлгийн явцад оролцогч, сонирхогч талууд, нөлөөлөлд өртөгсдөөс ирүүлсэн саналуудыг хэрхэн тусгасан талаарх тайлбар бүхий хавсралтыг байгаль орчны стратегийн үнэлгээний тайлан дүгнэлтэд хавсаргаж болно.

1.6.7 Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад байгаль орчны стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлэх

Байгаль орчны стратегийн үнэлгээний үр дүн, авч үзсэн болон сонгосон хувилбаруудын талаарх мэдээлэл, түүнийг хэрэгжүүлэх явцад хийх хяналт, шинжилгээ нь тухайн хөгжлийн бодлогын хэрэгжилтэд байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд эрсдэл үүсэхээс хэрхэн зайлсхийж, тогтвортой, ногоон хөгжлийн шалгууруудыг хэрхэн хангаж байгааг илтгэх гол үзүүлэлт болох юм. Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад хяналт шинжилгээ байнга хийгдэж байх ёстой бөгөөд түүний хэрэгжилтийн хяналт нь болзошгүй хуримтлагдах нөлөөллийг урьдчилан тодорхойлох, тодорхой бүс нутгийг хамарсан байгаль орчны доройтлоос урьдчилан сэргийлэх чухал хэрэглүүр болно. Ийм учраас стратегийн үнэлгээний дүгнэлт зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих үзүүлэлтийг хянах арга замтай хамтатган тодорхойлох явдал энэ үе шатны гол зорилт болно.

Байгаль орчны стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хянах үзүүлэлтүүдийг тухайн хөгжлийн бодлогын зорилт арга хэмжээнээс хамааруулан тодорхойлох бөгөөд доорх шаардлагуудыг илтгэх үзүүлэлтүүд зайлшгүй багтсан байх шаардлагатай. Үүнд:

- Байгаль орчны стратегийн үнэлгээгээр сонгосон хөгжлийн хувилбаруудын хэрэгжилтийн хувь;
- Стратегийн үнэлгээнд авч үзэн татгалзсан хувилбаруудаас дахин санал болгосон тоо;
- Тухайн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн төслүүдийн тоо, түүнд тавигдсан байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах арга хэмжээ;
- Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээнд туссан стратегийн үнэлгээний зөвлөмжийн чиглэл, тоо;
- Байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний шийдвэрт стратегийн үнэлгээний зөвлөмж, дүгнэлт тусгалаа олсон байдал;
- Стратегийн үнэлгээний урьдчилан сэргийлэх болон шууд хэрэгжүүлэхээс татгалзах, болзошгүй сөрөг болон хуримтлагдах нөлөөлөл бүхий хувилбаруудтай адилтган татгалзсан төсөл, арга хэмжээний нэр, чиглэл, хүчин чадал, бусад үзүүлэлт;
- Ногоон хөгжлийн болон байгальд ээлтэй технологинэвтрүүлэх зорилго бүхий төсөл, арга хэмжээний нэр, чиглэл, тоо;
- Байгалийн нөөц ашиглалт, эрчим хүч, усны хэмнэлтийн дэвшилтэт технологийг ашиглах төсөл, арга хэмжээний нэр, чиглэл, хүчин чадал, бусад үзүүлэлт;
- Бодлогын хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч, сонирхогч талуудаас өгч буй санал, тэдгээрийн гол агуулга зэрэг орно.

1.7 Байгаль орчны стратегийн үнэлгээний тайлангийн бүтэц, дүгнэлтийн агуулга

Тухайн салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний баримт бичигт байгаль орчны стратегийн үнэлгээг хийсэн баг тайлан, дүгнэлт гаргах ба тайлан нь дараах бүтэцтэй байна.

Үүнд:

Товч танилцуулга

1. Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний зорилго зорилт, хэрэгжүүлэх гол арга хэмжээ;
2. Бодлогын зорилт, арга хэмжээний байгаль хамгаалал, ногоон (тогтвортой) хөгжлийг хангах зорилт болон төрийн бусад бодлого, хөтөлбөртэй нийцсэн байдал;
3. Бодлогын хэрэгжилтийн нөлөөлөлд өртөх байгалийн нөөц, экосистемийн өнөөгийн төлөв байдал, хэтийн хандлага;
4. Бодлогын хэрэгжилтээс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар, хуримтлагдах сөрөг нөлөөллүүд;
5. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, татгалзах хувилбарууд, тэдгээрийн харьцуулалт ба сонголт;
6. Байгаль орчны стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмж;
7. Хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад байгаль орчны стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг хянах арга зам, үнэлэх шалгуур үзүүлэлтүүд;
8. Ашигласан мэдээллийн эх сурвалж;
9. Мэдээллийн хавсралт.

Стратегийн үнэлгээний ажлын гол үр дүн нь дүгнэлт бөгөөд түүнд доорх зүйлс агуулагдсан байх шаардлагатай.

Үүнд:

- Тухайн салбарын бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний гол зорилго, стратегийн зорилтууд, хэрэгжүүлэх арга хэмжээ нь одоо мөрдөж байгаа байгаль орчны хууль тогтоомжид хэрхэн нийцсэн талаарх дүгнэлт;
- Болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлээр хамгийн бага бөгөөд байгаль хамгаалал, тогтвортой, ногоон хөгжлийг хангахаар сонгогдсон бодлого, стратеги, гол арга хэмжээний хувилбарууд, мөн авч үзэж татгалзсан хувилбаруудын талаарх товч дүгнэлт;
- Бүс нутагт бий болж болзошгүй хуримтлагдах сөрөг нөлөөллүүд, түүнээс урьдчилан сэргийлэх зөвлөмж;
- Бодлогыг хэрэгжүүлэх явцад байгаль орчны стратегийн үнэлгээний дүгнэлтийн хэрэгжилтэд тавих хяналтын арга, тайлагнах хэлбэр, хугацааны урьдчилсан товч зэрэг орно.

ТӨГСӨВ

2-Р ХЭСЭГ
ХУРИМТЛАГДАХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭХИЙХ АРГАЧЛАЛ

ГАРЧИГ

2.1Товч танилцуулга	21
2.3 Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийхэд баримтлах үндсэн зарчим.....	23
2.4Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний үе шат	24
2.5 Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний гол зорилт, шаардлага, хамрах хүрээг тодорхойлох нь	26
2.5.1 Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний зорилт, хамрах хүрээг тодорхойлох	26
2.6 Хуримтлагдах нөлөөлөл, эх үүсвэр, замналыг тодорхойлох нь.....	27
2.6.1Бүс нутгийн байгаль орчны анхдагч төлөв байдлыг тодорхойлох.....	27
2.6.2Хуримтлагдах нөлөөллийг тодорхойлох	27
2.6.3Олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлэг явуулах	28
2.6.4 Байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үүссэн өөрчлөлт, үр дагаврыг тодорхойлох	28
2.7 Хуримтлагдах нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох нь.....	35
2.8 Уршигт үр дагаврын үнэлгээг хийх нь.....	36
2.9 Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг бэлтгэх, тайлагнах нь	37
2.10 Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажлын биелэлтийг хянах.....	38
2.11 Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний гол шалгуур үзүүлэлтүүд.....	38
2.12 Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайлангийн бүтэц, дүгнэлт, агуулга	38

2.1 Товч танилцуулга

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ нь хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, аливаа төслийн өнгөрсөн, одоо болон ирээдүйн үйл ажиллагааны үр дүнд тодорхой бүс нутаг, усны сав газар, нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирсан болон цаашид учруулж болзошгүй шууд болон шууд бус хам сөрөг нөлөөллүүдийн эх үүсвэрүүдийг тодорхойлох, тэдгээрийн тархалт замналуудыг үнэлэх, үр дагавруудыг бууруулах, арилгах арга хэмжээг тогтоох үндсэн зорилготой үйл явц юм.

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнд нөлөөллийн үнэлгээний уламжлалт арга зүй, аргачлалыг өргөнөөр хэрэглэдэг боловч орон зай, цаг хугацааны хамрах хүрээг тогтоох, үйл ажиллагааны харилцан үйлчлэл, хам нөлөөллийг үнэлэх, сөрөг нөлөөлөл бохирдлын эх үүсвэрүүд, тэдгээрийн замналуудыг нарийвчлан тодорхойлох, уршигт үр дагаврын үнэлгээ зэрэг олон хүндрэлтэй асуудлуудтай тулгардаг нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээний ажилд тэр бүр хэрэглэдэггүй зарим арга зүй, аргачлалыг шаарддаг. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг хийхээр сонгогдсон бүс нутаг, усны сав газар, нутаг дэвсгэрийн шинж чанар, хэрэгжиж байгаа төслүүдээс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлсэн, үзүүлж байгаа, үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийн үр дагавар, эрсдэлээс хамаарч үнэлгээ хийх арга аргачлалыг сонгон авч хэрэглэх боловч цаашид дараах онцлогийг харгалзан авч үзэх шаардлагатай болдог.

Тухайлбал:

- Төслүүдийн хам сөрөг нөлөөлөл нь засаг захиргааны хэд хэдэн нэгж, томоохон газар нутгийг хамрах бөгөөд янз бүрийн үр дагавруудыг учруулсан байдаг (жишээлбэл, тодорхой бүс нутаг, усны сав газрыг хамарсан бохирдол тархсан байх гэх мэт);
- Төслүүдийн хам сөрөг нөлөөлөл нь өнгөрсөн болон ирээдүйд урт хугацааны туршид үргэлжлэх боломжтой байдаг;
- Төслүүдийн үйл ажиллагааны явцад тэдгээрийн нэг бүрийн сөрөг нөлөөллүүд хоорондоо нэгдэж хам сөрөг нөлөөллийг үүсгэж шууд болон шууд бус байдлаар тухайн бүс нутаг, усны сав газар, нутаг дэвсгэрийн байгаль орчны бүрэлдэхүүн хэсгээр дамжин экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдэд болон нийгэм, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг;
- Бүс нутгийн шинжтэй байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлэх шууд болон шууд бус нөлөөллөөс гадна бусад нөлөөллийг эх сурвалжууд түүнийг замналыг тогтоож уршигт үр дагаварыг үнэлэх шаардлага гардаг зэрэг орно.

Иймээс хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг хийхэд онцгойлон анхаарах дараах асуудлуудыг энэхүү аргачлалд авч үзэж, тодорхой тайлбартайгаар тусгав.

Үүнд: нөлөөллийг нэг бүрчлэн үнэлэхээс хэрхэн зайлсхийх, илүү сөрөг нөлөөтэйг хэрхэн тогтоох, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг хийх үйл ажиллагааны хүрээг ямар орон зайнд авч үзэх, бусад ямар үйл ажиллагааны нөлөөллийг хамтатган авч үзэх, нөлөөллийн хугацааны масштабыг хэрхэн тогтоох, хуримтлагдсан болон цаашид хуримтлагдах нөлөөллийг хэрхэн илрүүлэх, түүнийг үнэлэхийн тулд юу хийх шаардлагатай зэрэг орно.

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний гол зорилтыг хангахад дээр дурдсан онцлог, анхаарвал зохих асуудлуудыг хэрхэн а...

аргачилсан зааврыг энэхүү баримт бичигт тусган, түүнийг гардан хийх мэргэжилтнүүд, хянаж хүлээн авах шинжээчид, шийдвэр гаргагчдад зориулан боловсруулав.

2.2Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний гол зорилт

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.5.-д “Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ”-г тодорхой бүс нутаг, усны сав газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслүүдээс хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа хам болон давхардмал сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээг тогтоох зорилгоор хийнэ гэж заасан байдаг.

Мөн тус хуульдБайгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь тодорхой бүс нутаг, усны сав газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөлд хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хийж, үнэлгээний тайланг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх үнэлгээний асуудал эрхэлсэн мэргэжлийн зөвлөлд хүргүүлж хянуулахаар тус тус заасан билээ.

Иймд, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгБайгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар томилогдсон холбогдох эрх бүхий мэргэжлийн байгууллага, баг хийх ба тухайнбүс нутагусны сав газрын байгаль орчны төлөв байдлыг тодорхойлж, байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлсэн болон үзүүлж байгаа гол сөрөг нөлөөллүүд, тэдгээрийн үр дагаврын эрчим, цар хүрээ, тархалтыг тогтоож сөрөг нөлөөллийн эх үүсвэрүүд, нөлөөллийн замнал, тэдгээрийн нөлөөлөлд эзлэх хувь хэмжээг тодорхойлсоны үндсэн дээр байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, зардлын тойм, хувилбаруудыг тогтоож тайлагнан, дүгнэлт, зөвлөмж боловсруулна.

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажлын хүрээнд дараах асуудлуудыг тодорхойлох шаардлагатай байдаг.

Үүнд:

- Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнд шаардлагатай бүс нутгийн суурь мэдээлийг цуглуулна;
- Байгаль орчны төлөв байдлыг тодорхойлно;
- Бүс нутгийн шинжтэй нөлөөлөл ба тулгамдаж байгаа асуудлыг тодорхойлно;
- Сөрөг нөлөөллүүдийн эх үүсвэр, эзлэх хувь хэмжээ, тэдгээрийн замналыг тодорхойлно;
- Нөлөөллийн хил хязгаар /орон зай, цаг хугацаа/-ын хүрээг тогтоох;
- Бүс нутгийн шинжтэй хам болон давхардмал сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоно;
- Хам болон давхардмал сөрөг нөлөөллүүдийн үр дагавар, эрчимшил, эрсдэлийг үнэлж эрэмбэлнэ;
- Тухайн болон бүх үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн байгаль орчны бүрэлдхүүн хэсгийг тодорхойлно;
- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгийг тогтс

ажиллагаанаас болж үүссэн сөрөг нөлөөлөлд өртсөн экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсгийг сонгон авч нарийвчлан тогтооно;

- Бүс нутагт төслийн үйл ажиллагаанаас хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн үнэлгээ хийнэ;
- Бүс нутагт төслийн үйл ажиллагаанаас болж байгаль орчин-нийгмийн тогтолцоонд гарсан өөрчлөлтийг байгаль орчин, нийгмийн эзмэг байдлын үнэлгээ хийж тодорхойлно;
- Бүс нутагт үүссэн хам болон давхардмал сөрөг нөлөөлөл, үр дагаврыг бууруулах арга хэмжээний зөвлөмж, төлөвлөгөө болон хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулна;
- Уршигт үр дагаврын үнэлгээ өгнө.

2.3 Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийхэд баримтлах үндсэн зарчим

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийж шийдвэр гаргахад дараах зарчмыг баримтлана.

Үүнд:

- Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг байгаль орчны холбогдох хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн хийсэн байх;
- Бүс нутагт хуримтлагдсан нөлөөллийг тухайн нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн асуудалтай уялдуулан судалж, шинжилсэн байх;
- Төслүүдийн хэрэгжилтээс үзүүлж буй сөрөг нөлөөллүүдийг зөв, бодитой тодорхойлоход нөлөөллийн эх үүсвэр, тэдгээрийн замналыг оновчтой тогтоосон байх;
- Хам болон давхардмал сөрөг нөлөөллүүд нь байгалийн хувьсал өөрчлөлттэй холбоотой эсэхийг тодорхойлсон байх;
- Хам сөрөг нөлөөлөл, түүний үр дагавар, эхүүсвэрүүдийн хувь хэмжээг оновчтойгоор зөв тодорхойлсон байх;
- Нөлөөлөл, түүнийг үнэлж байгаа арга зүй болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний үр дүн, дүгнэлт нь шинжлэх ухааны зохих арга зүйгээр хийсэн судалгааны үр дүн нь баримт нотолгоонд үндэслэсэн байх;
- Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн менежментийн арга хэмжээ нь хэрэгжих боломжтой байх зэрэг болно.

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажлыг гүйцэтгэхэд дараах үе шатуудыг дамжин хийгдэх ба Зураг 2.1-д үе шат бүрийн үйл явцыг хамтатган тусгав.



Зураг 2.1. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний үе шат, гүйцэтгэх дараалал, уялдаа холбоо

2.4 Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний үе шат

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний гол зорилт нь тодорхой бүс нутаг, усны сав газар, нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирсан, цаашид учирч болзошгүй шууд болон шууд бус хам сөрөг нөлөөллүүдийг үнэлэх, тэдгээрийг бууруулах арга хэмжээнүүдийг тодорхойлоход орших бөгөөд хам сөрөг нөлөөллүүдийн :

замнал, эх үүсвэрүүдийн нийт нөлөөлөл, үр дагаварт эзлэх хувь хэмжээг тодорхойлох ажлуудыг хийж гүйцэтгэсэн байх шаардлагатай.

Дээрх зорилт, шаардлагуудыг хангах хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажлыг дараах үе шатнуудын дагуу нарийвчлан судалж, үр дүнг гаргана.

Үүнд:

1. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний гол зорилт, шаардлага, хамрах хүрээг тодорхойлох үе шат - Энэ үе шатанд үнэлгээний ажлыг зөв чиглүүлэхэд голчлон анхаарна. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ бодитой хийгдэхэд шаардлагатай гол зорилт, хамрах хүрээн, хил хязгаар тогтоох, бүс нутаг, усны сав газар, нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлсэн хам сөрөг нөлөөллийн үр дагавраас улбаалсан тулгамдсан асуудлуудыг тодорхойлоход хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажлын удирдамжийг энэ үе шатанд гаргах бөгөөд түүнд бодлогын хэрэгжилт төслүүдийн үйл ажиллагаанаас үүдсэн хам сөрөг нөлөөллүүдийг тодорхойлох, нөлөөллийн шинж чанараар нь эрэмблэх, хээрийн судалгаа шинжилгээгээр нөлөөлөлд өртсөн экосистемийн чухал бүрэлдхүүн хэсгийг тодорхойлох, хам нөлөөллийн үр дагаврыг тогтоох, түүийг бууруулах арга хэмжээг төлөвлөх, хяналт шинжилгээний гол зорилтыг тодорхойлох зэрэг ажлуудыг багтаана.
2. Хуримтлагдах нөлөөллийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх үе шат - Энэ үе шатанд бүс нутгийн хуримтлагдах нөлөөллийг үнэлэхэд шаардлагатай бүхий л мэдээ материалуудыг бүрдүүлж тухайн бүс нутаг, усны сав газрын байгаль орчны анхдагч төлөв байдлыг тодорхойлох, хэрэгжиж байгаа төслүүдийн үйл ажиллагаанаас гарах сөрөг нөлөөллүүдийн эх үүсвэр, тархах замналууд, нийт нөлөөлөлд эзлэх хувь хэмжээг нарийвчилан тогтоох, тэдгээрээс үүдсэн хам сөрөг нөлөөллүүдийг үнэлэх, байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлсэн сөрөг үр дагавар, учирсан эрсдэл, нөлөөлөлд өртсөн экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсгийг нарийвчилан тодорхойлох, байгаль орчинд учруулсан нийт экологи-эдийн засгийн хохирол, нөхөн сэргээлтийн зардлыг тодорхойлно.
3. Хуримтлагдах нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох үе шат - Энэ үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлогдсон байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөн, цаашид үргэлжлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд, үүссэн сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээг тодорхойлох, нөхөн сэргээх болон дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний зөвлөмжийг боловсруулна.
4. Уршигт үр дагаврын үнэлгээний үе шат - Энэ үе шатанд тодорхойлогдсон тухайн бүс нутаг, усны сав газар, нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх хам сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх, хагас дутуу хэрэгжүүлсэн тохиолдолд цаашид бий болох уршигт үр дагавуудыг тодорхойлж дүгнэлт хийнэ.
5. Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажлын биел:

Энэ үе шатанд хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний гүйцэтгэлийг гаргасан ажлын удирдамжийн дагуу хянаж үнэлгээний үнэн зөв байдал, чанарын талаар үнэлэлт өгнө. Мөн хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тодорхойлогдсон сөрөг нөлөөллийг бууруулах, үр дагаврыг арилгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилт, түүний гүйцэтгэлийн чанарыг хуримтлагдсан нөлөөлөлд өртсөн бүс нутгийн байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндийн байдалд гарсан эерэг өөрчлөлтүүдийг уялдуулан дүгнэх ажил хийгдэж болно.

2.5 Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний гол зорилт, шаардлага, хамрах хүрээг тодорхойлох нь

2.5.1 Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний зорилт, хамрах хүрээг тодорхойлох

- Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний гол зорилт нь хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, аливаа төслийн өнгөрсөн, одоо, ирээдүйн үйл ажиллагааны үр дүнд тухайн бүс нутгийн байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирсан болон цаашид учруулж болзошгүй шууд ба шууд бус сөрөг нөлөөллүүдийг үнэлэх, эх үүсвэрүүд, тэдгээрийн замналыг тодорхойлох, түүнийг бууруулах арга хэмжээг тогтооход чиглэсэн байна.
- Хуримтлагдах үнэлгээний хамрах хүрээ нь тухайн бүс нутагт байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд хам сөрөг нөлөө, үр дагавар, түүнд өртсөн иргэд, орон нутагт тулгамдсан асуудлууд, бүс нутаг, усны сав газарт хэрэгжүүлж буй төслүүдийн үйл ажиллагаанаас үүссэн шууд ба шууд бус нөлөөллүүд, тэдгээрийн экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсэгт үзүүлсэн хам болон давхардмал сөрөг нөлөөллийн орон зай, цаг хугацааны хил хязгаар, цар хүрээний нөлөөллийн бүсийг тодорхойлно.
- Бүс нутгийн байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд тулгамдаж байгаа асуудлуудыг тодорхойлохдоо төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд эрх ашиг нь хөндөгдөх иргэд, сонирхогч талууд болон засаг захиргааны байгууллагуудын саналыг авч үзсэн байна.
- Хамрах хүрээний орон зай болон цаг хугацааны хил хязгаарыг тогтооход сөрөг нөлөөллийн орон зай, цаг хугацааны хувьд хуримтлагдах нөлөөлөлд өртсөн газар нутгийн хэмжээг тодорхойлохоос гадна нөлөөлөлд цаашид өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлсон байх, хуримтлагдах сөрөг нөлөөллүүдийн шууд, шууд бус, хам болон давхардмал нөлөөллийн орон зай, цаг хугацаанд үзүүлж байгаа нөлөөллийг тогтоох, хам сөрөг нөлөөллийн өнгөрсөн, одоо, ирээдүйд үргэлжлэх цар хэмжээ, эрсдэл зэргийг тодорхойлоход чиглэсэн байна.
- Мөн төслийн үйл ажиллагааны хамрах хүрээг тогтооход хэрвээ улсын хил дамнан (зэрлэг амьтдын нүүдэл гэх мэт) явса...

хэмжээний (уур амьсгалийн өөрчлөлт болон дэлхийн дулаарлын гэх мэт) нөлөөлөл байвал тэдгээрийг тодруулсан байх шаардлагатай.

Дээрх алхмуудын үр дүнг нэгтгэж тухайн бүс нутаг, усны сав газарт хийгдэх хуримтлагдах үнэлгээний ажлын удирдамжийн төслийг төрийн захиргааны төв байгууллага боловсруулан байгаль орчны асуудал эрхэлсэн сайдад танилцуулж зохих шийдвэрийг гаргана.

Удирдамжийн төсөлд хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний хүрээнд хийгдэх гол ажлууд, зорилго, зорилтуудыг тодорхойлж, энэ ажлыг хариуцан гүйцэтгэх байгууллага, түүнтэй хамтран хэрэгжүүлэгч, оролцогч талууд тэдгээрийн хамтын ажиллагааны арга хэлбэр, уг үнэлгээг хийх хуваарь, мөрдөх, ашиглах баримт бичиг, санхүүжилтийн эх үүсвэр, оролцогч талуудад мэдээлэл хүргэх, гол чухал хэлэлцүүлгүүдийг хийх тов, ажлын чанарын хяналтын шалгууруудыг тодорхойлж оруулна.

2.6Хуримтлагдах нөлөөлөл, эх үүсвэр, замналыг тодорхойлох нь

2.6.1Бүс нутгийн байгаль орчны анхдагч төлөв байдлыг тодорхойлох

Бүс нутгийн байгаль орчны анхдагч төлөв байдлыг тодорхойлохдоо доорх зүйлүүдийг хамруулна.

Үүнд:

- Физик газарзүй нөхцөл, газрын гадарга, ландшафт;
- Уур амьсгалын үндсэн үзүүлэлтүүд, агаарын чанарын анхдагч түвшин;
- Гадаргын болон газар доорх усны нөөц, онцлог, усны нөөцийн хомсдол, барагдалт, бохирдол, чанар;
- Хөрсөн бүрхэвч, хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдлын түвшин;
- Ургамлын аймаг, төрөл зүйлс, доройтлын түвшин;
- Амьтны аймгийн зүйлийн бүрдэл, тоо толгой,тархалт;
- Түүх, соёлын дурсгалт зүйлс, түүний хадгалалт, хамгаалалт;
- Газар ашиглалт, ашигт малтмал, байгалийн нөөцийн ашиглалтын байдал;
- Орон нутгийн эдийн засгийн хөгжлийн түвшин;
- Нутгийн иргэдийн хүн ам, эрүүл мэнд, амьжиргаанытүвшин зэрэг орно.

2.6.2Хуримтлагдах нөлөөллийг тодорхойлох

Хуримтлагдах нөлөөллийг тодорхойлоход дараах зүйлсүүдийг хамруулан авч үзсэн байна.

Үүнд:

- Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийхээр сонгодсон бүс нутаг, усны сав газар, нутаг дэвсгэрт хэрэгжүүлж байгаа төслүүдийн үйл ажиллагааны явцад хуримтлагдсан сөрөг нөлөөллүүдийг эх үүсвэр, шинж чанар, эрчимшлийг тогтоох;
- Төслүүдийн үйл ажиллагааны хэрэгжилтэнд үүссэн сөрөг нөлөөллүүдийн тухайн бүс нутаг, усны сав газар, нутаг дэвсгэрт тархалтын замналуудыг тодруулах;
- Төслүүдийн үйл ажиллагааны хэрэгжилтээс үүссэн сөрөг нөлөөллүүдийн орон зайн давхцалыг тодорхойлон үүссэн хам сөрөг нөлөөллүүд, тэдгээрийн шинж чанарыг цаг хугацааны тодорхой үеийг хамарч хэрхэн үргэлжилсэн байдлыг тодорхойлох,
- Төслүүдийн үйл ажиллагааны хэрэгжилтээс үүссэн шууд болон шууд бус хам сөрөг нөлөөллөөс тухайн бүс нутгийн байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлсэн үр дагаврууд, учруулсан эрсдлүүдийг тодорхойлох;
- Төслүүдийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн бүс нутгийн нийгмийн бүлэг, нутгийн иргэдийг тодорхойлох;
- Хуримтлагдсан нөлөөлөлд өртсөн байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлон, үзүүлсэн нөлөөллөөр экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдээр нарийвчлан авч үзэх
- Сөрөг нөлөөллүүд болон тэдгээрийн нийт эзлэх хувь хэмжээ, хамрах нутаг дэвсгэрийг тодорхойлсны үндсэн дээр экологи-эдийн засгийн хохирол, нөхөн сэргээлтийн зардлуудыг тооцох зэрэг ажлууд орно.

2.6.3 Олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлэг явуулах

- Төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж байгаа олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлэг нь тухайн бүс нутагт тулгамдаж байгаа асуудлууд, нөлөөлөлд өртсөн экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсгийг тогтооход, байгаль орчин-нийгмийн тогтолцоонд гарч байгаа өөрчлөлтүүдийг тодорхойлоход чиглэсэн байна.

2.6.4 Байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үүссэн өөрчлөлт, үр дагаврыг тодорхойлох

- Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний зорилт, шаардлага, хамрах хүрээ, хил хязгаар, сөрөг нөлөөлөл, түүний эх үүсвэр, тархалт замнал, үр дагавар, нөлөөлөлд өртсөн нийгмийн бүлэг, нутгийн иргэд болон тухайн бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн төлөв байдлыг бодитойгоор үнэлсэний үндсэн дээр тухайн бүс нутгийн байгаль орчин-нийгмийн тогтолцоонд нөлөөлөх хүчин зүйлсийг нарийвчлан тогтоох, хам сөрөг нөлөөллүүдийн эерэг болон сөрөг талуудыг үнэлэх, эмзэг байдлыг тогтоосон байна (Шигтгээ 1).

Байгаль орчин нийгмийн эмзэг байдлын үнэлгээний зөвлөмж

Тодорхойлолт: Аливаа төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, экосистемд үзүүлж буй нөлөөлөл, эмзэг байдлыг индексжүүлэн үнэлэх аргаар гүйцэтгэнэ.


Үндсэн тэгшитгэл: Харьцуулалтын арга, статистик дүн шинжилгээ, газарзүйн мэдээллийн системд байгаа арга зүйнүүдээс сонгож авч хэрэглэнэ. Нийгэм, эдийн засгийн эмзэг байдлын нэгдсэн индексийг дараах байдлаар тодорхойлж болно.

$$ЭНИ = \frac{(X + B + A + Г + И + Я)}{6}$$

Үүнд: X – ДНБ-д ХАА-н эзлэх хувь, B – 1 хүнд ногдох ДНБ, мян төг, A – Зах зээлээс алслагдмал байдал, нийслэлээс алслагдсан зай, Г – Гамшигт эмзэг байдал, зудад хорогдсон малын нийт малд эзлэх хувь, И – Хүний хөгжлийн индекс, Я – Ядуурлын хамрах хүрээ, хувиар.

Оролтын мэдээ: Нийгэм, эдийн засаг, байгаль орчны статистикийн түүхэн мэдээллүүд.

Үр дүн: Энэ загвараар тухайн бүс нутаг, сав газар, нутаг дэвсгэрийн байгаль орчин болон нийгмийн эмзэг байдлын орон зайн зураглалыг хийхэд хэрэглэж болно.



Боловсруулалт: Тус загвар нь статистикийн дүн шинжилгээний аргуудыг хэрэглэж, газар зүйн мэдээллийн системд орон зайн давхацуулалт хийгдэнэ.

Загварын эх сурвалж:

1. <http://www.esri.com>
2. М.Алтанбагана, Т.Чулуун нарын “Уур амьсгалын өөрчлөлтөд бэлчээрийн нийгэм-экологийн тогтолцооны эмзэг байдлын үнэлгээний аргачлал, аргазүй”, 2012

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийхэд хуримтлагдах нөлөөллийг тодорхойлох үе шат нь чухал байр суурь эзлэх боловч төслүүдийн үйл ажиллагааны төрөл, онцлогоос хамааран хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний нэгдсэн нэг арга зүйг хэрэглэх боломжгүй юм. Иймд хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний зорилго, зорилт, сөрөг нөлөөллийн онцлог шинж чанараас хамаарч тухайн үнэлгээнд хэрэглэх хамгийн боломжит, тохиромжтой аргуудыг сонгох шаардлагатай.

Бүс нутаг, усны сав газар, нутаг дэвсгэрт хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг хийхэд төслийн үйл ажиллагааны хоорондын харилцан хамаарал, учир шалтгааныг тайлбарлахад зураг 2-т үзүүлсэн байдлаар асуудлыг иж бүрнээр хамруулан авч үзэж анхдагч төлөв байдал, үйл ажиллагааны төрөл, эх үүсвэр, хам болон давхардмал сөрөг нөлөөлөл, хуримтлагдах нөлөөллийн үр дагавар, түүний эргэх холбоо уялдааг тодорхойлж үзсэн байх шаардлагатай.

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнд үйл ажиллагааны хоорондын харилцан үйлчлэлийг авч үзэж үйл ажиллагааны нөлөөллийн эерэг болон сөрөг талуудыг тогтооход сүлжээний анализ аргыг ашиглах, байгаль орчны тодорхой бүрэлдэхүүн хэсэгт нөлөөлөх эсэх, экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх нөлөөллийн эрчимийг (жишээлбэл, үргэлжлэл, эрчимшил) эрэмбэлэхэд харилцан үйлчлэлийн матрицыг хэрэглэх, харилцан үйлчлэлүүдийн мөн чанарыг таньж мэдэхэд хуримтлагдах нөлөөллийг бүрдүүлж байгаа нөлөөллүүдийн харилцан давхцалын хэр хэмжээ, зэрэгцээ орчны бүсийг

тодорхойлоход газар зүйн мэдээллийн системийн орон зайн болон цаг хугацааны давхцуулан зураглах арга зүйг ашиглах, экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөг илэрхийлж чадахуйц индикатор үзүүлэлтүүдийг ашиглах (усны бохирдлыг авч үзэхэд биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийг тодорхойлох, хүний үйл ажиллагаанаас шалтгаалах тухайлбал, зам харилцааны нягтрал, доройтсон газрын хэмжээ, хаг өвсний ургах байдал гэх мэт) байгаль орчны бүрэлдхүүн хэсэг болон экосистемийн шинж чанарыг урьдчилан тооцоолоход, экосистемийн төлөв байдалд үзүүлэх сөрөг болон хуримтлагдах нөлөөллийн цар хүрээ, хил хязгаар, эрчимшил, давтамж, үргэлжлэх хугацаа, тэдгээрийн хоорондын хамаарлыг тодорхойлоход байгаль орчны математик загварчлалуудаас сонгон хэрэглэж болно.

Зураг 2.2. Хөгжлийн бодлого дахь байгаль орчин, нийгмийн харилцаа холбооны бүдүүвч

Тухайлбал, хүний аливаа үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн газрын элэгдэл эвдрэлийн хэмжээг тогтоох бол LANDSAT, SPOT, MODIS зэрэг хиймэл дагуулын мэдээг ашиглан орон зай болон цаг хугацааны хувьд гарсан өөрчлөлтийг тогтоох, гадаргын болон газрын доорх усны нөлөөллийг судлахадорчин үеийн загварчлалын аргууд, ус ба хөрсний бохирдлын түвшингтогтооход лабораторын анализын аргууд /устөрөгчийн илтгэгч, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, ууссан хүчилтөрөгчийн хэмжээ, хүнд металын бохирдол гэх мэт/, агаарын чанарыг тодорхойлоход ISC3 загварыг, тухайн экосистемийг шүтэж амьдрах биологийн төрөл зүйлийн амьдрах орчны загварчлалын /Potential Habitat Model/арга, тэдгээрт үзүүлэх нөлөөллийг тодорхойлоход Threats, Disturbance/Condition Index орон зайн анализын аргуудыг хэрэглэх, эдэлбэр газрын бэлчээрийн даацийг өөрчлөлтийг нөлөөллийг тогтооход VELMA, Century экологийн загваруудыг, урсацын одоогийн болон ирээдүйн өөрчлөлтийн нөлөөг тооцооход HBV, TOPLAST загваруудыг, газрын доорх усны нөлөөллийг тооцооход MODFLOW загварыг, бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлтийн загваруудыг ашиглах, ус ашиглалтын улмаас голын урсацад үзүүлэх нөлөөллийг тооцоох Sobek, RIBASII

экосистемийн өнөөгийн болон хэтийн үнэ цэнийг тодорхойлоход Экосистемийн үйлчилгээний төлбөрийн аргыг ашиглах, бүс нутагт явагдаж, тухайн үйл ажиллагаа болон бусад үйл ажиллагааны экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсэгт үзүүлэх сөрөг нөлөөллийн улмаас бий болсон экологи, эдийн засгийн болон хохирлын үнэлгээг байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлалын дагуу тооцож цаашид авах арга хэмжээг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгана. Дээр дурьдсан зарим загваруудын ашиглах зөвлөмжийг дараах Шигтгээнүүдэд үзүүлэв.


Шигтгээ 2

Газар зүйн мэдээллийн системийн зөвлөмж

Тодорхойлолт: Газар зүйн мэдээллийн системийг ашиглан өргөн уудам нутаг дэвсгэр дээрх хүний үйл ажиллагаа болон бусад нөлөөллөөр бий болсон өөрчлөлтүүдэд чанарын үнэлгээ өгөх боломжтой.

Үндсэн тэгшитгэл: Судалгааны зорилгоос хамаарч газар зүйн мэдээллийн системд байгаа арга зүйнүүдээс сонгон авч хэрэглэнэ (*Жишээлбэл, газар ашиглалтын өөрчлөлтийг судлахаар болон supervised/unsupervised ангиллын арга, орон зайн дүн шинжилгээнд Spatial analysis арга г.м*).

Оролтын мэдээ: Ямар дүн шинжилгээ хийх гэж байгаагаас хамаарна. Жишээлбэл, нөлөөллүүдийн орон зайн давхцалыг тодруулахад дараах мэдээллийн бааз хэрэглэгдэж болно.



Үр дүн: Энэ загвараар тухай бүс нутаг, сав газар, нутаг дэвсгэрийн орон зайн зураглалыг хийхэд хэрэглэж болно.

Боловсруулалт: Тус загвар нь Window болон UNIX-ийн орчинд ажиллана

Загварын эх сурвалж:

1. <http://www.esri.com>

VELMA эко-гидрологийн загварын зөвлөмж

Тодорхойлолт: Тус загвар нь усны эргэлт болон ургамал-хөрсөн дэх нүүрс хүчлийн эргэлтэд уур амьсгалын өөрчлөлт болон газар ашиглалтын нөлөөг судалдаг.

Үндсэн тэгшитгэл:

Хөрсний босоо зүсэлтийн дагуу усны балансыг тооцоно.

$$\frac{ds_1}{dt} = P - D_1 - ET_1 - Q_1 - Q_{1, in} + Q_{1, in} \quad (1)$$

$$\frac{ds_2}{dt} = D_1 - D_2 - ET_2 - Q_2 + Q_{2, in} \quad (2)$$

$$\frac{ds_3}{dt} = D_2 - D_3 - ET_3 - Q_3 + Q_{3, in} \quad (3)$$

$$\frac{ds_4}{dt} = D_3 - Q_4 + Q_{4, in} \quad (4)$$

Үүнд: P - хур тунадас, ET - ууршилт, D - дренаж, Q - урсац.

Биомассыг дараах тэгшитгэлээр бодно.

$$\frac{dB}{dt} = \left[\sum_{i=1}^n \frac{r_i \times \mu_i \times \delta_{NH_4} \times NH_{4i}}{NH_{4i} + k_N} \right] + \left[\sum_{i=1}^n \frac{r_i \times \mu_i \times \delta_{NO_3} \times NO_{3i}}{NO_{3i} - k_N} \right] \times WS(z_i, z_m) \times B - m(B) \times B$$

Үүнд: B - биомасс, $m(B)$ - ургамлын хагдрах хувь, WS - ургамлын биомассд усны үзүүлэх нөлөө.

Оролтын мэдээ: Тус загварыг ажиллуулахад дараах мэдээллийг ашиглана.

- Өдрийн агаарын температур
- Өдрийнхур тунадас
- Судлах газрын хөрсний механик бүтэц
- Судлах газрын хөрсний зузаан
- Өндөршлийн тоон мэдээлэл

Үр дүн: Энэ загвараар тухай бүс нутаг, сав газар, нутаг дэвсгэрийн бэлчээрийн өнөөгийн болон ирээдүй төлөв байдлыг судалж, бэлчээрийн менежментийг зөв зохистой хийхэд хэрэглэж болно.

Боловсруулалт: Тус загвар нь Window болон UNIX-ийн орчинд ажиллана

Загварын эх сурвалж:

1. <http://latest-codes.tumblr.com/post/246358173/velma-eco-hydrology-model>
2. <http://www.processing.org>
3. <http://qdem.ersdac.jspacesystems.or.jp/>
4. <http://www.geos.ed.ac.uk/homes/mattal/ASTER12.pdf>

Century экосистемийн загварын зөвлөмж

Тодорхойлолт: Тус загвар нь бэлчээрийн менежмент, нүүрстөрөгчийн чадамжийг тодорхойлоходдэлхий нийтэд өргөн ашигладаг загвар бөгөөд ерөнхийдөө тус загвар нь ургамлын өсөлт, усны эргэлт болон хөрсний органик бодисыг загварчладаг.

Үндсэн тэгшитгэл: $AB_c = AB_{max} * f_t(T) * f_m(M) * S_{sh}$

Үүнд: AB_{max} - газрын дээрх биомассын хамгийн их утга, $f_t(T)$ - агаарын температураас хамаарсан функц, $f_m(M)$ - усны чадамжаас хамаарсан функц, S_{sh} - ургамлын сүүдэр, ургамлын өсөлтийн нөлөөг харуулсан параметр.

Оролтын мэдээ: Тус загварыг ажиллуулахад дараах мэдээллийг ашиглана.

- Сарын болон өдрийн агаарын хамгийн их ба бага температур
- Сарын болон өдрийн хур тунадас
- Судлах газрын хөрсний механик бүтэц

Үр дүн: Энэ загвараар тухайн бүс нутаг, сав газар, нутаг дэвсгэрийн бэлчээрийн өнөөгийн болон ирээдүйн төлөв байдлыг судалж бэлчээрийн менежментийг зөв зохистой хийхэд хэрэглэж болно.

Боловсруулалт: Тус загвар нь Window болон UNIX-ийн орчинд ажиллана

Загварын эх сурвалж:

1. <http://www.nrel.colostate.edu/projects/century/>
2. <http://www.geoenv.tsukuba.ac.jp/~sugita/archive/Byambakhuu-PhD.pdf>

HBV ус зүйн загварын зөвлөмж

Тодорхойлолт: Тус загвар нь усны баланс болон урсацыг тооцдог.

Үндсэн тэгшитгэл:

Усны баланс:

$$P - E - Q = \frac{d}{dt} [SP + SM + UZ + LZ + lakes]$$

: P-Хур тунадас, E-ууршилт, Q-урсац, SP-цасны ус, SM- х

Голын урсац:

$$Q_f = k_f UZ^{(1+ALFA)}$$

Үүнд: Q_f – гадаргын шууд урсац, мм, k_f - шууд урсацын буурцын итгэлцүүр, UZ – ус хурах талбай дахь усны эзэлхүүн, мм, $ALFA$ - шууд урсацын шугаман бус итгэлцүүр
Ул хөрсний усны урсац дараах тэгшитгэлээр илэрхийлэгдэнэ.

$$Q_s = k_s \cdot LZ$$

Үүнд: Q_s – ул хөрсний ус голыг тэжээх урсацын хэмжээ, мм, LZ – Ул хөрсний усны нөөц, түвшин, м, k_s - шууд хамаарлын итгэлцүүр

Оролтын мэдээ: Тус загварыг ажиллуулахад дараах мэдээллийг ашиглана.

- Өдрийн агаарын температур
- Өдрийн хур тунадас
- Өдрийн ууршиц
- Судлах газрын хөрс-усны параметр

Үр дүн: Энэ загвараар тухайн бүс нутаг, сав газар, нутаг дэвсгэрийн усны баланс болон голын урсацыг тооцоолж, усны нэгдсэн менежментийг зөв зохистой хийхэд хэрэглэж болно.

Боловсруулалт: Тус загвар нь Window орчинд ажиллана

Загварын эх сурвалж:

1. <http://www.smhi.se/sgn0106/ff/hydrologi/hbv.htm>
2. <http://www.geo.uzh.ch/en/units/h2k/services/hbv-model>
3. Урсацын HBV загвар ба ус хуваарилалтын Sobek загварыг ажиллуулах гарын авлага, Дэлхийн байгаль хаамгаалах сан, 2012, 30 хуудас

ISC3 Агаарын чанарын загварын зөвлөмж

Тодорхойлолт:ISC3 (Industrial Source Complex) загвараар цэгэн, талбайн, шугаман эх үүсвэрүүдээс ялгарах хийн (SO₂, NO₂, CO, тоос г.м) тархалтыг орон зайд цаг уурын **нөхцөлөөс** хамааруулан тооцоолох боломжтой юм.Энэ загвар нь богино хугацааны-ISCST; урт хугацааны-ISCLT гэсэн 2 хувилбартай бөгөөд тус тусдаа бодогддог.

Үндсэн тэгшитгэл: Гауссын тархалтын томъёонд суурилсан хагас эмперик байдлаар бичигддэг:

$$\chi = \frac{Q K V D}{2 \pi u_s \sigma_y \sigma_z} \exp \left[-0.5 \left(\frac{y}{\sigma_y} \right)^2 \right]$$

Энд:

χ - Агаарын бохирдлын агууламж

Q - Цэгэн үүсвэрээс нэгж хугацаанд гарах хаягдлын хэмжээ (г/сек)

K- Нэгжийн шилжүүлгийн коэффициент

V-Босоо хэмжээс

D-Сулралын хэмжээс

U_s – Эх үүсвэрийн өндөр дэх салхины хурд

σ_z - Босоо тэнхлэгийн дагуух бохирдуулах бодисын стандарт хазайлт

Оролтын мэдээ: Тус загварыг ажиллуулахад дараах мэдээллийг ашиглана.

- Цаг тутмын агаарын температур
- Салхины хурд, чиглэл

Цэгэн үүсвэрээс гарч буй бохирдуулах бодисын тархалтыг загварчлахад дараах мэдээ шаадагдана. Үүнд: Бохирдуулах бодисын гаралт,г/ сек, яндангийн өндөр, м, утааны температур K⁰, гарч буй хурд, м/сек, яндангийн диаметр, м.

Тоосны уналтыг тооцоолох тохиолдолд: тоосны нягт, хувийн жин, тоосны эгэл хэсгийн диаметр зэрэг нэмэлт мэдээлэл шаарддаг.

Үр дүн: Энэ загвараар агаарын бохирдлын нутаг дэвсгэрийн тархалтыг 1 цаг, 24 цагийн дундаж байдлаар тооцоолохын зэрэгцээ хамгийн их 10 утгыг гарган харж болно. Урт хугацааны загвар нь сар, улирал бүрийн дундаж утгын тархалт болон хамгийн их утгыг тооцоолно.

Боловсруулалт:Загвар нь DOS болон Windows-ийн орчинд ажиллана. Тархалтын зургийг GIS болон SURFER программ хангамжийг ашиглан зурж болно.

Загварын эх сурвалж:

1. User's guide for the industrial source complex (ISC3) dispersion models, Volume I – User instructions, U.S. ENVIRONMENTAL PROTECTION AGENCY, Office of Air Quality Planning and Standards, Emissions, Monitoring, and Analysis Division, Research Triangle Park, North Carolina 27711, September 1995
2. User's guide for the industrial source complex (ISC3) dispersion models, Volume II - description of model algorithms, U.S. ENVIRONMENTAL PROTECTION AGENCY, Office of Air Quality Planning and Standards, Emissions, Monitoring, and Analysis Division, Research Triangle Park, North Carolina 27711, September 1995
3. [http://www. Atmospheric Dispersion Modeling](http://www.AtmosphericDispersionModeling)

TOPLATS ус зүйн загварын зөвлөмж

Тодорхойлолт: Тус загвар нь усны болон энергийн балансыг тооцдог.

Үндсэн тэгшитгэл:

$$z = \bar{z} - \frac{1}{f}(\bar{\lambda} - \lambda)$$

Үүнд, z бол сав газрыг хуваасан бүх грид дэхь гүний усны түвшин, \bar{z} бол сав газрын дундаж гүний усны түвшин; $\bar{\lambda}$ бол сав газрын дундаж топо-индекс.

Шууд урсац нь (Saturated excess runoff (R_{sat})) хөрс усаар бүрэн ханасан үед тохиолддог бөгөөд энэ үзэгдэл нь тус загварт хөрсөн дээр ирж байгаа нийт хур тунадасны (P_{net}) хэмжээгээр тодорхойлогдоно.

$$R_{sat} = P_{net}$$

Удаан урсац (Baseflow (Q_b)) нь дараах тэгшитгэлээр тооцно.

$$Q_b = Q_0 \exp(-f\bar{z})$$

$$Q_0 = AT_e \exp(\bar{\lambda})$$

Үүнд, A бол сав газрын хэмжээ, T_e бол сав газрын дундаж гүний усны тэжээл хэмжээ бөгөөд энэ нь дараах тэгшитгэлээр илэрхийлэгдэнэ ($T_e = \frac{K_s}{f}$), K_s нь Ханасан усыг дамжуулах чадвар (saturated hydraulic conductivity), f бол K_s -ийн хөрсний боцоо зүсэлтийн дагуу буурах бууралтийн хэмжээ (exponential decay of K_s)

Мөн тухайн бүс нутаг, сав газар, нутаг дэвсгэрийн энергийн балансийг бодох үндсэн тэгшитгэл нь

$$R_n = \rho_w LE + H + G$$

Үүнд, R_n нийлбэр цацраг, $\rho_w LE$ нууц дулаан, H дулааны цацруулалт, G хөрсний дулаан

Оролтын мэдээ: Тус загварыг ажиллуулахад дараах мэдээллийг ашиглана.

- Хур тунадас
- Агаарын температур
- Салхины хурд
- Агаарын даралт
- Харьцангуй чийг
- Хөрс-усны параметрууд
- Судлах газрын хөрс-усны параметр
- Өндөршлийн тоон мэдээлэл

Үр дүн: Энэ загвараар тухайн бүс нутаг, сав газар, нутаг дэвсгэрийн усны эргэлт болон энергийн балансыг тооцоолж, ус нэгдсэн болон бэлчээрийн менежментийг зөв зохистой хийхэд хэрэглэж болно.

Боловсруулалт: Тус загвар нь UNIX орчинд ажиллана

Загварын эх сурвалж:

1. <http://hydrology.princeton.edu/models.php>
2. <http://www.geoenvironment.tsukuba.ac.jp/~sugita/archive/Byambakhuu-PhD.pdf>
3. <http://gdem.ersdac.jspacesystems.or.jp/>
4. <http://www.geos.ed.ac.uk/homes/mattal/ASTER12.pdf>

2.7 Хуримтлагдах нөлөөллийг бууруулах арга хэмжээг тодорхойлох нь

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнд хуримтлагдах нөлөөллийг бууруулах, орчны хяналт хийх арга хэмжээг байгаль орчны нөлөөллийн үнэлгээний адил зарчмаар гүйцэтгэнэ.

Үүнд:

- Хуримтлагдах нөлөөллийг тодорхойлох үе шатанд тодорхойлогдсон байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлсэн нөлөөллүүдийн шууд болон шууд бус хам сөрөг нөлөөллүүдийн эх үүсвэрүүдийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж, хөтөлбөрийг боловсруулах;
- Сөрөг нөлөөллөөс үүссэн үр дагавруудыг арилгах арга хэмжээний зөвлөмж, хөтөлбөрийг боловсруулах;
- Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлалын дагуу тооцоолсон экологи-эдийн засгийн хохирол, нөхөн сэргээлт болон дүйцүүлэн хамгаалах зардлын тооцох
- Нэгдсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд байгаль хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналтшинжилгээний хөтөлбөрийг боловсруулах зэрэг ажлууд хийгдэнэ.

2.8 Уршигт үр дагаврын үнэлгээг хийх нь

Бүс нутаг, усны сав газар, нутаг дэвсгэрт үүссэн хам сөрөг нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхгүй байх эсвэл хагас дутуу хэрэгжүүлсэн тохиолдолд цаашид тухайн бүс нутагт бий болох болзошгүй сөрөг нөлөөллүүдийн болзошгүй үр дагавруудыг тодорхойлж сөрөг нөлөөллүүд, тэдгээрийн үр дагавруудыг бууруулах арга хэмжээ авсан тохиолдолд гарах үр дүнтэй харьцуулсан дүгнэлтхийнэ.

Хуримтлагдах нөлөөллийн уршигт үр дагаврын үнэлгээнд дараах асуудлуудыг тодорхойлсон байх шаардлагатай.

Үүнд:

- Сөрөг нөлөөллүүд, хамрах хүрээ, хил хязгаар, эрчимшил, давтамж, болзошгүй үр дагавруудын ирээдүйн хандлагыг тогтоох;
- Тухайн үйл ажиллагаа болон бусад үйл ажиллагааны шууд, шууд бус, хам болон давхардмал сөрөг нөлөөллүүд цаашид нэмэгдэх магадлал, хандлагыг тогтоох;
- Байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд ирээдүйд үүсэх хохирол нь хүлээн зөвшөөрөхүйц хэмжээнд байх эсэхийг тогтоох;
- Байгаль орчны бүрэлдхүүн хэсэгт үзүүлэх сөрөг нөлөөллийн цар хүрээ нь байгаль орчны тэтгэх чадамжаас давах эсэхийг тогтоох.

Дээрх хүчин зүйлсийг хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнд тухайн үйл ажиллагааны хуримтлагдах нөлөөллийн хамрах хүрээ, сөрөг нөлөөлөл, болзошгүй эрсдлүүдийн онцлог шинж чанараас хамаарч тодорхойлсон байна.

2.9 Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгбэлтгэх, тайлагнах нь

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний аргачлал, нөлөөллийг бууруулах болон нөхөн төлбөрийн арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөрүүд, үнэлгээний гол үр дүн нь ойлгомжтой байдлаар бичигдсэн ёстой.

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний үр дүн нь менежментийн олон хувилбар, сонголтын хураангуй болон тэдгээрийн үр дагаврыг маш тодорхой тогтоосон, мөн нийгэм, эдийн засгийн үр ашиг ба өртөгтэй нь харьцуулан үнэлж, дүгнэсний үндсэн дээр бодит, итгэл үнэмшилтэй шийдвэр гаргах боломжийг бүрэн дүүрэн тодорхойлж, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээнд тавигдах хууль ёсны шаардлагуудыг хангасан байх хэрэгтэй

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээг гүйцэтгэх үйл явц болон түүний үр дүн, дүгнэлт, зөвлөмжид дараах асуудлуудыг тусгасан байна.

Үүнд:

1. Бүс нутгийн өнөөгийн болон ирээдүйн үйл ажиллагаанд өртөж болох байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийг илрүүлж тогтоохын тулд тухайн бүс нутгийн өнөөгийн болон ирээдүйн хөгжлийн бодлого, байгаль орчны талаар баримтлах бодлого, байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндийн талаар хангалттай мэдээ, мэдээллийг бүрдүүлсэн байх;
2. Байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт үзүүлж буй нөлөөлөл нь харилцан адилгүй орон зайг хамрах тул үйл ажиллагааны нөлөөллийн хамрах хүрээг төсөл хэрэгжүүлэх газар нутгийн хэмжээгээр үл хязгаарлан нь нөлөөллийн үнэн бодит байдлыг үнэлж болохуйц хэмжээний талбайг хамарсан байх;
3. Төсөл хэрэгжих бүс нутагт тухайн нэг үйл ажиллагаа болон бусад үйл ажиллагаанаас үүдэлтэй бүхий л хавсармал нөлөөлөл нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх, нөлөөлөл нь ирээдүйд хэрхэн өсөн нэмэгдэх боломжийг тогтоох, уг нөлөөллийг судлах шаардлагатай эсэхэд дүгнэлт гаргахад чиглэсэн байх;
4. Мэргэжлийн шинжээчдийн оролцоотойгоор чанартай, үнэн зөв мэдээ, мэдээлэлд тулгуулан боломжит сөрөг нөлөөллүүдийн эх үүсгэвэрүүдийг тодорхойлон, тэдгээрийн тоон үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийж, холбогдох дүрэм, журам, стандартад заасан үзүүлэлтүүдтэй харьцуулан гол сөрөг нөлөөллийг тогтоож, тэдгээрийн үр дагаваруудыг нарийвчлан тогтоосон үр дүн, дүгнэлт, зөвлөмж гаргасан байх;
5. Хуримтлагдах нөлөөллийн үр дүн, дүгнэлт, зөвлөмжинд эрх ашиг нь хөндөгдөх олон нийтийн оролцоог ханган, тэдгээрийн санал бодлыг тусгасан байх;
6. Байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, тэдгээрийн хувилбарууд, зардлын тойм, мониторинг хийх асуудлыг тодорхойлон дүгнэлт, зөвлөмжийг боловсруулан байгаль орчны менежментийн 1

тайлагнасан байх.

2.10 Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний ажлын биелэлтийг хянах

Батлагдсан удирдамжийн дагуу боловсруулсан хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх үнэлгээний асуудал эрхэлсэн мэргэжлийн зөвлөлд хүргүүлж хянуулна.

Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын холбогдох мэргэжлийн хүмүүс хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тодорхойлогдсон сөрөг нөлөөллийг бууруулах, уршигт үр дагавар, сөрөг үр дагаврыг арилгах талаарх авах арга хэмжээний, хэрэгжилт, биелэлтийн талаар үнэлэлт, дүгнэлт гаргаж өгнө.

2.11 Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний гол шалгуур үзүүлэлтүүд

- Судалгаанд хамрагдах газар нутаг нь хэмжээний хувьд үнэлгээ хийж буй тухайн төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй экосистемийн чухал бүрэлдхүүн хэсгийн үнэлгээ хийх боломж олгохуйц том байх;
- Судалгаанд хамрагдах газар нутгийн хүрээнд, судалгаанд тусгагдсантай ижил экосистемийн чухал бүрэлдэхүүн хэсгүүдэд нөлөөлж болзошгүй, тухайн үед хэрэгжиж эхэлсэн, хэрэгжиж байгаа, эсвэл хараахан хэрэгжиж эхлээгүй байгаа бусад төслийн нөлөөллийг тодорхойлох;
- Төлөвлөж буй үйл ажиллагаанаас экосистемийн чухал бүрэлдхүүн хэсэгт цаашид үзүүлэх нөлөөллийг үнэлэх;
- Нөлөөллийн задлан шинжилгээнд шинжлэх ухааны үндэслэл бүхий үнэлгээний аргыг ашиглах;
- Нөлөөллийг бууруулах арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, зөвлөмжийг боловсруулах.

2.12 Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайлангийн бүтэц, дүгнэлт, агуулга

Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайлан нь дараах үлгэрчилсэн агуулгын дагуу боловсруулагдсан байх шаардлагатай бөгөөд бүс нутгийн болон гол сөрөг нөлөөлөл, түүний үр дагаврын онцлогоос эсвэл авч үзэж буй асуудлын цар хүрээнээс хамааран зарим бүлэг, хэсгийг нэмж, шаардлагатай мэдээллийг эх хувиар нь хавсаргана.

Үүнд:

- Товч танилцуулга
- Тухайн бүс нутгийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт;

- Тухайн бүс нутаг, сав газрын байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлсэн болон үзүүлж байгаа гол сөрөг нөлөөллүүд, тэдгээрийн үр дагаврын тодорхойлолт;
- Хуримтлагдах нөлөөллийн эрчим, цар хүрээ (цаг хугацаа, орон зай), тархалт;
- Хуримтлагдах нөлөөллийн эх үүсвэрүүд, түүнийг хариуцах этгээд, тэдгээрийн нөлөөлөлд эзлэх хувь хэмжээ;
- Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, зардлын тойм, тэдгээрийн хувилбарууд;
- Хуримтлагдсан сөрөг нөлөөллөөс үүдэн бий болсон байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндийн хохирлын үнэлгээ;
- Цаашид авах арга хэмжээний төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд хяналт тавих шалгуур үзүүлэлтүүд;
- Нөлөөлөлд өртөгдсөн бүс нутаг дахь олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүн, дүгнэлт зөвлөмж
- Ашигласан мэдээлэл, эх сурвалжийн жагсаалт зэрэг орно.

ТӨГСӨВ

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын
2013 оны 12 дугаар сарын.....-ны өдрийн
.....дугаар тушаалын 2 дугаар хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

1-Р ХЭСЭГ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭХИЙХ АРГАЧЛАЛ

ГАРЧИГ

1.1 Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний гол зорилт	3
1.2. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээнд тавигдах шаардлагууд	3
1.3. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний үе шат	4
1.3.1 Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний гол зорилт, шаардлага, хүрээг тодорхойлох.....	5
1.3.1 Өмнөх судалгааны мэдээ, мэдээллийг цуглуулах, боловруулах, байгаль орчны төлөв байдлыг тодорхойлоход шаардлагатай нэмэлт судалгаа хийх	5
1.3.3 Судалгааны мэдээллийг эмхэтгэн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан боловсруулах	10

1.1 Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний гол зорилт

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний гол зорилт нь аливаа төсөл, хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөг боловруулах эхний шатанд тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдал тухайлбал, газарзүйн нөхцөл, геологийн тогтоц, уур амьсгал, агаарын чанар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, мөн түүнчлэн нутгийн иргэд, оршин суугчид, тэдний нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, эрүүл мэнд, түүх соёлын өвийн өнөөгийн төлөв байдлыг тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн, судлаачид, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор, шинжлэх ухааны судалгааны аргазүйг ашиглан тодорхойлоход бүрэн чиглэгдэх юм.

Ингэж байгаль орчин, нийгэм, оршин суугчдын эрүүл мэндийн төлөв байдлыг төсөл, арга хэмжээ эхлүүлэхээс өмнө тогтоосноор төслийн болон бодлогын арга хэмжээний төлөвлөлтийг байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө багатайгаар төлөвлөх, хэрэгжүүлэх явцад гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн улмаас орчны хувьсал өөрчлөлт, бохирдол доройтлыг бодитойгоор тогтоох, шаардлагатай арга хэмжээг цаг алдалгүй авах, төслийн нөлөөлөлд өртөгсөд, сонирхогч талуудыг бодитой мэдээллээр хангахад чухал ач холбогдолтой. Иймээс байгаль орчны төлөв байдлын үнэлгээ нь үнэлгээний ажлын эхний үе шат байх бөгөөд энэхүү аргачлал нь дээрх зорилтуудыг хангахуйц байхад оршино.

1.2. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээнд тавигдах шаардлагууд

Хуулийн шаардлагуудыг мөрдүүлэх, хэрэгжилтийг хангахад байгаль орчны төлөв байдлын үнэлгээг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааны дүнд түшиглэн хийх нь онцгой чухал ач холбогдолтой. Иймээс төсөл хэрэгжүүлэгч болон бодлогын баримт бичгийг боловсруулагчид нь эрх бүхий мэргэжлийн байгууллага болон судалгаа, шинжилгээний байгууллагын оролцоотойгоор хийлгэж, шаардлагатай тохиолдолд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хандан чиглэл гаргуулахаар зохицуулагдсан. Энэ нь төлөв байдлын үнэлгээг мэргэжлийн түвшинд хийх, нөгөө талаас түүнийг хэрхэн хийснийг эртнээс хянаж бодлогын баримт бичиг, төслийг боловсруулахдаа анхаарах асуудлуудыг төрийн захиргааны төв байгууллагаас тусгах, байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийхдээ төлөв байдлын үнэлгээний дүнг харгалзан үзэх, стратегийн болон хуримтлагдах нөлөөллий үнэлгээ, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг хэлэлцэх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлахад уг үнэлгээний үр дүнг харгалзан үзэхээр зохицуулсан байна. Иймээс төлөв байдлын үнэлгээг гүйцэтгэх, түүний үр дүнг тайлагнахдаа доорх шаардлагуудыг хангасан байх ёстой.

Үүнд:

- Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг хууль, журамд заасан бодлогын баримт бичиг, төслийн анхан шатны баримт бичгийг боловсруулах үе шатанд төлөвлөж буй төслийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлогтой уялдуулан нөлөөлөлд өртөж болзошгүй нутаг дэвсгэрийг бүрэн хамруулах;
- Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг тухайн салбарын шинжлэх ухааны судалгааны хамгийн сүүлийн үеийн аргазүйг баримтлан, үнэн зөв мэдээлэлд тулгуурлан гүйцэтгэх;
- Үнэлгээний явцад хэмжилт дээжлэлтийг зохих аргачлал, стандартын дагуу хийх, түүнийгээ баталгаажуулсан байх;
- Холбогдох мэдээллийг боловсруулсан аргазүй, мэдээлийн эх сурвалжийг тайлан мэдээндээ тодорхой тусгасан байх;
- Олон улсын банк, санхүүгийн байгууллагаас (дэлхийн банк, олон улсын санхүүгийн корпорац, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг) тавьдаг нийтлэг шаардлагуудыг хангасан байх зэрэг болно.

Үүнээс гадна байгаль орчны төлөв байдлын үнэлгээг гүйцэтгэсэн байгууллага нь боловсруулсан үнэлгээний тайлангаа байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх үнэлгээний асуудал эрхэлсэн мэргэжлийн зөвлөлд хүргүүлж хянуулах, төсөл хэрэгжүүлэгч нь хуулийн хавсралтад заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албанд хандан ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлт гаргахдаа төлөв байдлын үнэлгээний тайланг хавсаргасан байх шаардлагатай.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний хээрийн болон суурин судалгааг холбогдох хууль тогтоомж, стандарт, аргачлал, шаардлагын дагуу, мэргэжлийн түвшинд гүйцэтгэх бөгөөд тайланд тусгасан мэдээ, мэдээллийн үнэн зөв, нотолгоог гүйцэтгэсэн байгууллага хариуцна. Үнэлгээний ажлын чанар, гүйцэтгэл түүнтэй холбогдох асуудлыг гэрээний хариуцлагаар зохицуулна.

1.3. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний үе шат

Байгаль орчны төлөв байдлын судалгааг эдгээр төслийн эхний шатанд буюу төслийн үндэслэлийг боловсруулах техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хийх, зураг төсөл боловсруулах тухайлбал, ордын хайгуул, уурхай, үйлдвэр, зам, гүүр, дэд бүтцийн барилга байгууламжийн зураг төслийг боловсруулах үе шатанд хийж төсөл хэрэгжих орчны суурь мэдээллийг төслийн баримт бичиг, зураг төсөлд тусгана.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний үйл ажиллагаа нь дараах үе шатуудыг дамжин хийгдэнэ.

Үүнд:

- Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний гол зорилт, шаардлага, үнэлгээний цар хүрээг тодорхойлох;
- Өмнөх судалгааны мэдээ, мэдээллийг цуглуулах, боловсруулах, байгаль орчны төлөв байдлыг тодорхойлоход шаардлагатай нэмэлт судалгаа хийх;
- Судалгааны мэдээллийг эмхэтгэн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан боловсруулах зэрэг болно.

1.3.1 Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний гол зорилт, шаардлага, хүрээг тодорхойлох

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний гол зорилт, шаардлага, хүрээг тодорхойлохдоо дараах асуудлуудыг анхаарах шаардлагатай:

Үүнд:

- Тухайн бодлогын арга хэмжээ, төслийн үйл ажиллагаа явагдах, түүний нөлөөлөлд өртөж болзошгүй нутаг дэвсгэрийн хил хязгаар (өндөр нарийвчлалтай GPS, дифференциал GPS, электрон тахеометр г.м сүүлийн үеийн хэмжих багаж, GIS, MapInfo, Erdas, Surfer зэрэг програм хангамж ашиглан)-ыг нарийвчлан тогтоох, зохих хураангуйлалтай газрын зурагт буулгах;
- Боловсруулж буй хөгжлийн бодлого, хөтөлбөр, төслийн үйл ажиллагааны онцлогийг харгалзан түүнийг төлөвлөх, зураг төсөл боловсруулахад шаардлагатай байгаль орчин, нийгмийн суурь мэдээллийг тодорхойлох;
- Байгаль орчны төлөв байдлын үнэлгээгээр тодруулах шаардлагатай нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, нийгмийн өнөөгийн төлөв байдлыг илтгэх гол үзүүлэлтүүдийг гаргах;
- Үнэлгээний ажлыг гүйцэтгэх хугацаа, баримтлах аргачлал, онцгойлон анхаарах асуудлууд зэрэг орно.

1.3.1 Өмнөх судалгааны мэдээ, мэдээллийг цуглуулах, боловсруулах, байгаль орчны төлөв байдлыг тодорхойлоход шаардлагатай нэмэлт судалгаа хийх

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний цар хүрээ, нөлөөлөлд өртөж болзошгүй нутаг дэвсгэрийн хил хязгаар, байгаль орчин, нийгмийн үзүүлэлтүүд тодорхой болсон тохиолдолд дараах аргачлалаар мэдээллийг илгүүлж боловсруулна.

Үүнд:

- Өмнө энэ тухайн бүс нутаг, нутаг дэвсгэрт хийгдсэн газарзүйн нөхцөл, геологийн тогтоц, уур амьсгал, агаарын чанар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, нийгэм, эдийн засаг, нутгийн иргэд, оршин суугчид, тэдний эрүүл мэнд, байгаль, түүх соёлын өвийн талаар хийгдсэн судалгааны мэдээллийг холбогдох байгууллага, нутгийн иргэд, судлаачид болон бусад мэдээллийн эх сурвалжуудаас цуглуулж мэдээллийн орхигдлыг тогтоох;
- Цаашид төсөл хэрэгжих нутаг дэвсгэр түүний орчимд байгаль орчны төлөв байдлын суурь мэдээллийн орхигдлыг гүйцээх судалгааны ажлын нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж, түүний дагуу нэмэлт мэдээллийг цуглуулах;

Байрзүйн зураг нь төслийн байршил, төсөл хэрэгжихээс өмнөх үеийн газрын гадаргын хэлбэр дүрс, геоморфологийн элементүүд зэргийг тогтооход гол мэдээллийн эх сурвалж болдог бөгөөд байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийж буй газар нутаг дэвсгэрт уг зураг аль болох том хураангуйлалтай байх нь чухал.

Нөгөөтэйгүүр орчны төлөв байдал, хувьсал өөрчлөлтийг тогтооход тодорхой хугацаанд авсан агаар, сансрын зураг чухал ач холбогдолтой бөгөөд эндээс судалгааны гол объектууд болох карьер, суваг шуудуу, далан, хиймэл нуур зэргийн хэмжээ, геоморфологийн элементүүдийн өөрчлөлт зэргийг тогтооход чухал ач холбогдолтой. Монгол орны ихэнх нутаг дэвсгэр 1:32000, 1:45000, 1:63000 масштабтай агаарын хар цагаан өнгийн зургаар бүрхэгдсэн бөгөөд интернетийн сүлжээн дэх янз бүрийн хиймэл дагуулуудын зурагт боловсруулалт, тайлал хийх замаар төсөл хэрэгжүүлэхээс өмнөх төлөв байдлыг тодорхойлж баталгаажуулах боломжтой.

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байршил, газарзүйн нөхцөл, геологийн тогтоц, уур амьсгал, агаарын чанар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, мөн түүнчлэн нутгийн иргэд, оршин суугчид, тэдний нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, эрүүл мэнд, байгаль, түүх соёлын өвийг тодорхойлохдоо тухайн чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн, судлаачид, мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор, тухайн шинжлэх ухааны салбарын олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судалгааны аргазүйг ашиглан гүйцэтгэнэ. Байгаль орчны төлөв байдлыг дээр дурдсан бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр тодорхойлж тусгайлан бэлтгэсэн загварын дагуу (үнэлгээний мэргэжлийн байгууллагууд өөрсдийн судалгааны арга барил, онцлогоо тусган тусгайлан боловсруулсан байх ёстой) бичиглэл хийж баримтжуулна. Судалгааны явцад тухайн орчны төлөв байдлыг бүрэн тодорхойлохуйц агаар, хөрс, ус, ургамалан нөмрөгийн хэмжилт, шаардлагатай дээжлэлтийг зохих стандарт, шаардлагуудыг баримтлан хийнэ. Авсан дээж, сорьцод хаяг шошго нааж, судалгаа, хэмжилт, дээжлэлтийн үйл явцыг фото болон дүрс бичлэгээр баталгаажуулан холбогдох лабораториудад хүргүүлнэ.

Байгаль орчны төлөв байдлыг тодорхойлохдоо байгаль орчны бүрдэл хэсэг тус бүрээр тухайн салбарт мөрддөг нийтлэг стандарт, шаардлага, шинжлэх ухааны судалгааны аргуудыг ашиглах бөгөөд тэдгээрээс зайлшгүй авч үзэж өнөөгийн төлөв байдлыг тогтоох асуудлуудын талаар дор дурдвал:

Физик газарзүй, ландшафт: Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийхэд хамгийн түрүүнд төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байршил, физик газарзүйн нөхцөлийг тодорхойлж, дэвсгэр нутгийн ландшафтын төрлүүдийг тогтоож, зураг зохиож, тайлбар хийнэ.

Геологийн тогтоц: Төслийн үйл ажиллагаанд хамрагдах талбай, түүний орчмын геологийн тогтоц, стратиграфи, чулуулгийн бүтэц, түүхэн хөгжил, нас, тектоник структур, ашигт малтмалыг тодорхойлж, геологийн зураг, зүсэлт, схемүүд гаргана.

Геоморфологи: Төсөл хэрэгжих орчны хотгор, гүдгэрийн үндсэн шинж, хөгжил, төрөл зүйл, үйл явц, хөгжил хувьсал, эерэг, сөрөг хэлбэр, морфологи бүтцийг тодорхойлж зураглана. Ингэхдээ геоморфологийн ажиглалт, харьцангуй өндрийн хэмжилт, топозураг, агаар сансрын зургийг ашиглан газрын гадаргын хэлбэр дүрс, геоморфологийн элементүүдийг ангилан татам, дэнж, хажуу, оройн хэсгүүдийг ялган зураглах нь зүйтэй. Рельефийн ажиглалт, шинжилгээг байгаль орчны төлөв байдлын үнэлгээний хээрийн судалгааны явцад маршрутын аргаар явуулж, гарал үүсэл, бүтэц, тогтолцоо, динамикийг тогтооно.

Гидрогеологийн нөхцөл, газар доорх усны нөөц, чанар, горим: Тухайн төсөл хэрэгжих байршил нь гидрогеологийн региональ зүй тогтлын хувьд аль дүүрэгчлэлд хамаарах, тухайн сав газар, бүс, массивын онцлог, төслийн байршил нь газрын доорх усны тэжээгдлийн муж, усан хагалбар буюу усны урсац бүрэлдэх эх хэсэгт, усны хуримтлалын бүсэд, хөлийн бүсийн аль хэсэгт хамаарах, тухайн орчинд тархсан ус агуулагч үе давхаргуудын геологийн насны дараалал, байршлын зүй тогтол, тэдгээрийн коллектор шинж чанар, агуулагдаж байгаа усны гидравлик шинж чанар, газрын доорх усны хөдөлгөөний болон нөөцийн тоон үзүүлэлтүүд, химийн найрлага, чанар, нөөц горимыг судалж, тодорхойлон төсөл хэрэгжих орчны гидрогеологийн зураг, зүсэлт, схемүүдийг боловсруулна. Шаардлагатай тохиолдолд гидроизогипсийн зураг, бохирдлын тархалтын зургуудыг үйлдэнэ. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт олон жилийн цэвдэг тархсан бол түүний зузаан, бүтцийг судалж физик шинж, дулааны горимыг тодорхойлон тухайн нутаг дэвсгэрийн цэвдгийн зургийг оруулж болно.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний гидрогеологийн хээрийн ажиглалт, судалгааг маршрутын шугам, ажиглалтын цэгийн бичлэг хийх хэлбэрээр бүхий л талбайг хамруулан явуулна. Гидрогеологийн маршрутын чиглэлийн талбайг хөндлөн огтолсон болон судалгааны объектуудыг дагасан чиглэлээр, ажиглалтын цэгүүдийн зайг газар доорх усны илэрц, булаг, худаг, цооногийн байршлаас хамааруулан тогтооно. Судалгааны үед газар доорх усны тэжээл, хуримтлал, хөлийн бүсийг ялган тогтоох, төслийн байрлал аль бүсэд хамаарч байгааг тогтоох, төслийн үйл ажиллагаанд өртөгдөх байдлыг тогтооход голлон анхаарвал зохино.

Гидрогеологийн маршрутын судалгааны тэмдэглэлийг нягт нямбай хөтлөн ажиглалтыг тасралтгүй байдлаар явуулах шаардлагатай. Хээрийн судалгааны явцад булгийн ундаргыг шавхалтын, хөвүүрийн, эргэлдүүлэгч, халиах аргын аль тохиромжтойгоор тодорхойлж, дүнг тэмдэглэх, шаардлагатай бол дээжлэлтийг хийнэ. Гидрогеологийн хээрийн судалгааны үед хийгдэх уст цэгийн бичиглэл, усны сорьц авах, уст цэгийн туршилт, усзүйн хэмжилт хийхдээ Н.Батсүхийн “Хээрийн гидрогеологи” номонд тусгасан аргачлал, СХЗГ-аас батлан мөрдүүлж буй стандартуудыг мөрдөн ажиллах шаардлагатай.

Гадаргын усны нөөц, горим, чанар: Тухайн төсөл хэрэгжих нутаг дэвсгэр дэх гол горхи, нуур цөөрөм, булаг шанд, хур тунадасны усны нөөц, тоо хэмжээ, урсацын горимын үндсэн үзүүлэлтүүдийг зохих аргачлалын дагуу хэмжин тогтоож, түүний тархалт найрлага, чанар, хомсдол, бохирдлын төлөв байдал, цаашдын хандлагыг тодорхойлон бичиглэл хийнэ. Усны объектуудаас сорьц авч, хаягжуулан дараах үзүүлэлтүүдийг тодорхойлуулахаар стандартчиллын тохирлын гэрчилгээ бүхий дотоод, гадаадын шинжилгээний лабораториудад явуулна.

Үүнд :

- Эрдсийн бүрэлдэхүүний үзүүлэлтүүд (Ca^{2+} , Mg^{2+} , $\text{Na}^+ + \text{K}^+$, HCO_3^- , SO_4^{2-} , Cl^-);
- Шим бохирдлын үзүүлэлтүүд (NH_4 , NO_2 , NO_3 , PO_4);
- Хүчилтөрөгчийн горимын үзүүлэлтүүд (ууссан хүчилтөрөгч, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч-БХХ₅, перманганатын исэлдэх чанар-ПИЧ, бихроматын исэлдэх чанар г.м);
- Хүнд металлууд: зэс (Cu^{2+}), марганец (Mn^{2+}), 3 валентттай хром (Cr^{3+}), 6 валентттай хром (Cr^{6+}), мышьяк (As^{3+}), кадми (Cd^{2+}), хар тугалга (Pb^{2+}), никель (Ni^{2+}), мөнгөн ус (Hg^{2+}) г.м;
- Тусгай үзүүлэлтүүд: нефть, нефтийн бүтээгдэхүүн, өөх тос, гадаргын идэвхт бодисууд зэрэг орно.

Үүнээс гадна газрын доорх устай харилцан нөлөөлөл байгаа эсэхийг тодорхойлж, гадаргын усны зургийг боловсруулна.

Уур амьсгал: Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн уур амьсгалын үндсэн онцлог, агаарын температурын сар, улирал, жилийн дундаж, хамгийн их, бага температурын дундаж утга, нарны цацраг, үнэмлэхүй ба харьцангуй чийг, хур тунадас, цасан бүрхүүл, түүний жил, улирлын хуваарилалт, салхины эрчим, зонхилох чиглэл, хурд зэрэг үндсэн үзүүлэлтийг олон жилийн ажиглалтын материал(сүүлийн 10-аас доошгүй жилийн мэдээ)-д тулгуурлан тодорхойлохын зэрэгцээ цаг агаар, уур амьсгалын нөхцөл нь хүний аж байдал, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаар тодорхойлно.

Агаарын чанар: Тухайн нутаг дэвсгэрийн агаарын чанарыг тодорхойлох зорилгоор агаарын сорьц авч, лабораторийн задлан шинжилгээ хийнэ. Дараах үзүүлэлтүүдээс шаардлагатайг сонгож тодорхойлно. Үүнд: азотын ислүүд (NO_x); хүхэрлэг хий (SO_2); угаарын хий буюу нүүрстөрөгчийн ду

ширхэглэгт тоосонцор ($PM_{2.5}$, PM_{10}); хар тугалга (Pb); бусад хүнд металлууд; шаардлагатай тохиолдолд хүлэмжийн хий орно.

Хөрсөн бүрхэвч: Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний орчмын судалгаанд хамрагдсан талбайнхөрсний төрлийг тодорхойлж, түүний тархалт, морфологи хэв шинж, ус-физик-химийн чанар, үржил шим, ялзмагийн агууламжийг судалж, хөрсөн бүрхэвчийн зураглал үйлдэнэ. Хээрийн судалгааны үед тухайн талбайд тархсан хөрсний морфологи шинж чанарыг тодорхойлох болон хөрсний сорьц авах зорилгоор үндсэн (1.0-1.5 м хүртэл гүнтэй) болон хагас зүсэлт (50-80 см)-ийг тухайн хөрсний нийтлэг хэв шинжийг бүрэн төлөөлж чадах газрыг сонгон хийнэ. Хөрсний морфологи шинжийн бичиглэлийг хийж дууссаны дараа давхарга тус бүрээс дээж авч, фото зураг, бичлэг хийж баталгаажуулна. Дээжний хэмжээ ойролцоогоор 0.5 кг орчим байх бөгөөд газрын нэр, байршил, зүсэлтийн дугаар, дээж авсан гүн гэх мэт тэмдэглэл бүхий хаяг дээжинд хийж холбогдох лабораторид хүргэнэ.

Мөн хээрийн судалгааны явцад тухайн газар нутгийн онцлог, хөрсний үржил шимт чанар, хөрсжих процессыг судлах, газар ашиглалтын хэлбэр, эдэлбэрийн төрлийг харгалзан мониторингийн цэгүүдийг сонгон анхдагч төлөв байдлын бичиглэл, хэмжилт, дээжлэлтийг хийсэн байна. Хөрсний үржил шим, бохирдлыг тодорхойлохын тулд дараах үзүүлэлтүүдийг лабораторид шинжлүүлэхээр хүргүүлнэ.

Үүнд: рН, ялзмаг; Аммони (NH_4); Нитрит (NO_2); Нитрат (NO_3); Фосфатууд (PO_4^{3-}); Кали (K^+); Нефть, нефтийн бүтээгдэхүүн; As, Hg, Cd, Pb, Ni, Cr, Se зэрэг хүнд металлууд; г.м орно.

Ургамлан нөмрөг: Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн ургамлын төрөл зүйлүүдийг тодорхойлж жагсаалт гаргах, үндсэн бүлгэмдэл, тэдгээрийн хэвшинж, биомассыг тодорхойлж тайлбарын хамт боловсруулна. Ховор, ховордсон болон нутагшмал ургамлын төрөл зүйл, тэдгээрийн тархалт, хамгааллын статус зэргийг тодорхойлно. Мөн судалгааны талбайг хамарсан ургамалжилтын зураглал үйлдэнэ.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний хээрийн судалгааны үед төсөл хэрэгжих талбайн хэмжээнд зүйлийн бүрэлдэхүүнийг бүрэн хамарч тэдгээрийн арвийн хэмжээ, ургацын гарцыг тогтоох боломтой газрыг сонгон ургамалжилтын бичиглэлийг хийж, ургамлан нөмрөгийн хучилтын хэмжээг нүдэн баримжааны, хучилтын проектын болон тоо-жингийн аргуудаас аль тохиромжтойг сонгон тодорхойлсон байвал зохино.

Амьтны аймаг: Тухайн нутаг дэвсгэр дэх амьтны аймгийн төрөл зүйлийн бүрэлдэхүүн, тархалтын хүрээ, байршилт, шилжилт хөдөлгөөнийг тодорхойлж, аж ахуйн үйл ажиллагааны нөлөөгөөр устсан буюу дайжсан амьтан, тэдгээрийн тоо толгойн үзүүлэлт, цаашдын төлөв байдлыг тодорхойлно. Амьтны аймгийн хээрийн судалгааны явцад тухайн нутаг дэвсгэрийн амьтны аймагт суурь үнэлгээ өгөх үүднээс сээр нуруугүй ба сээр нуруутан амьтдын зүйлийн бүрдлийг тогтоож, тэдгээрийн нягтшил, тоо толгойн хэмжээг тусгай арга зүйн дагуу тодорхойлох, ховор, ховордож буй, устах аюулд орж болохуйц амьтан...

жагсаалтыг гаргаж, тоо толгой, амьдрах орчны нөхцөлийн өнөөгийн төлөв байдалд үнэлгээ өгнө. Амьтны хээрийн судалгааны үед жижиг хөхтөн амьтдыг сонгосон талбайд амьд баригч ашиглан барих, шугаман трансектын аргаар амьд баригч байршуулан барих-тэмдэглэх-давтан барих аргаар, мөн амьтны амьдралын хэлбэр, үйл ажиллагааны ул мөрөөр, шөнийн идэвхтэй амьтдыг гэрэлтүүлэх, цасан бүрхүүл тогтсон үед мөрөөр, дулааны улиралд баас, хэвтэр, идэш тэжээлийн үлдвэр, эзэмшил нутгийн хаяг зэргээр, ороо хөөцөө, үржлийн үед, усны эх үүсвэрийн орчимд тооллого, ажиглалт хийж тоо толгойг үнэлэх, загасыг голдрилын тодорхой хэсэгт дээжлэгч тавьж тоолох, шавжийг тодорхой талбайг сонгож, тэдгээрийг барих зэрэг аргуудаас аль тохиромжтойг сонгон ашиглана.

Монгол орны нугаламт амьтны зүйлийн тархац, идээшил, амьдрах орчин, дэлхийн болон бүс нутгийн ховордлын үнэлгээг Олон улсын байгаль хамгаалах холбооноос эрхлэн гаргасан шалгуураар үнэлж, Монгол улсын шувуу, хөхтөн амьтны улаан данс болон амьтны хамгааллын төлөвлөгөө зэрэг эх сурвалжийн мэдээллийг ашиглан хамгааллын статусыг тогтоох боломжтой.

Байгаль, түүх, соёлын дурсгалт газар: Байгаль, түүх, соёлын дурсгалт газарт онцгой сонин тогтоцтой хад чулуу, уул нуруу, гол горхи, нуур цөөрөм, хөшөө дурсгал, тусгай хамгаалалттай газар нутаг, байгалийн үзэсгэлэнт газар зэрэг хамаарагдах бөгөөд тэдгээрийн онцлог шинж, ач холбогдол, хамгааллын статус, өнөөгийн төлөв байдлыг тодорхойлж, түүнийг хамгаалах талаар авч байгаа арга хэмжээг авч үзэж, дэлгэрэнгүй мэдээллийг оруулах шаардлагатай.

1.3.3 Судалгааны мэдээллийг эмхэтгэн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан боловсруулах

Байгаль орчны төлөв байдлын суурь мэдээллийн дүнг нэгтгэн боловсруулж, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндийн өнөөгийн төлөв байдал, хэтийн төлөвийн талаар цогц мэдээллийг багтаасан тайлан бичих нь зөвхөн түүнийг захиалагчаас гадна нутгийн иргэд, судлаачид, шийдвэр гаргагчид, орон нутгийн удирдлага, сонирхогч талуудад чухал ач холбогдолтой. Иймээс байгаль орчны төлөв байдлын үнэлгээний үр дүнг нэгтгэсэн тайланг боловсруулахдаа доорхшаардлагуудыг хангасан байвал зохино.

Үүнд:

- Тайланг суурин болон хээрийн судалгаа, шинжилгээний явцад цуглуулсан мэдээлэл, түүнд хийсэн боловсруулалтын үр дүнг багтаан энэ аргачлалд тусгасан агуулгын дагуу боловсруулсан байх;
- Тайлангийн эхийг монгол хэл дээр, ойлгомжтой найруулгатай, дүрмийн болон утгын алдаагүй боловсруулах, шаардлагатай бол захиалагчаас тавьсан хүсэлтийн дагуу англи болон бусад хэл рүү орчуулах;

- Тайланд судалгааны аргазүй аргачлал, мэдээллийн эх сурвалжийг дурдаж, судалгаа шинжилгээ, боловсруулалтын үр дүнг тодорхой зураг, схем, график, фото болон бусад зүйлсээр баталгаажуулж, тодорхой тайлбартайгаар тусгах;
- Судалгаанд хамрагдсан бүс нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн өнөөгийн төлөв байдлыг тусгасан тодорхой хураангуйлалтай хавсралт зургуудыг боловсруулсан байх;
- Хавсралт болон тайланд оруулсан зургийн мэдээллүүд нь зургийн түгээмэл ашиглагддаг програм хангамжууд дээр ашиглагдах боломжтой байх;
- Тайлангийн товч танилцуулгыг тайланд тусгасан чухал асуудлууд, судалгааны онцлог үр дүн, дүгнэлтүүдийг багтаан хураангуй (executive summary) хэлбэрээр бэлтгэж оруулсан байх зэрэг болно.

Хэрэв судалгааны үр дүнг боловсруулахдаа шинээр тодорхой програм хангамж, шинэ арга хэрэглэсэн бол энэ талаар түүний гол онцлог, ач холбогдол, техникийн үзүүлэлт, тохиргооны талаар, сонгосон үндэслэл, баталгаа, гарсан үр дүнг хэрхэн тайлбарлах талаар дэлгэрэнгүй тайлбарыг хавсаргаж болно.

Байгаль орчны төлөв байдлын хээрийн болон суурин судалгааны ажлын үр дүнг нэгтгэн төсөл хэрэгжих орчны байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын үнэлгээний тайланг боловсруулах бөгөөд тэр нь доорх бүтэц, агуулгатай байвал зохино.

Үүнд:

1.Товч танилцуулга:Төлөв байдлын үнэлгээний гол зорилго, үнэлгээний хүрээнд хийсэн ажлууд, судалгааны ажлуудын гол үр дүн, цаашид төсөл хэрэгжүүлэгч, орон нутаг болон шийдвэр гаргах түвшинд анхаарах асуудлуудыг товч тодорхой тусгасан байна.

2.Төсөл хэрэгжих талбайн байршил, физик газарзүйн нөхцөл: Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, талбайн байршлыг байгалийн бүс бүслүүр болон засаг захиргааны хуваариар тодруулж, алслалт, зам харилцааны онцлогийг тодорхойлно. Тухайн орчны физик газарзүйн үндсэн тодорхойлолтыг гаргаж, газарзүйн болон байгалийн бүс бүслүүрийн онцлог, ландшафт, газрын бүрхэвч, гадаргын тогтоц онцлогийг тодруулна. Төслийн талбайн газрын гадаргын эвдрэл, өөрчлөлтийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлж, үнэлсэн байна. Байршлын болон талбайн зургуудыг зохих масштабаар гаргаж хавсаргана.

3.Уур амьсгал: Бүс нутгийн болон төсөл хэрэгжих орчны уур амьсгалын үндсэн нөхцөл, нарны гийгүүлэлт, цацраг, агаарын болон хөрсний гадаргын температур, агаарын чийг, хур тунадас, салхи, агаарын даралт зэрэг үзүүлэлтүүдийг түүний хэмжсэн станц тус бүрээр аль болох урт хугацааг хамруулсан мэдээллийг оруулна. Төслийн төлөвлөлтөд зайлшгүй авч үзэх, гамшиг үүсгэж болзошгүй цаг уурын үзүүлэлтүүдийг тодорхойлж, тусгах шаардлагатай.

4. Агаарын чанар: Агаарын бохирдуулагч эх үүсвэрүүд, Агаарын чанарын ерөнхий төлөв байдал, агаар бохирдуулах хийн төлөвт бохирдуулах бодисууд, тоосонцорын агууламжийг түүнийг тодорхойлсон судалгааны арга зүйн хамт, мөн тухайн орчин дахь бохирдлын хяналт шинжилгээний станцууд, түүний хэмжилтийн талаарх мэдээллийг оруулна. Төслийн талбай, түүний орчим дахь агаар бохирдлын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлж, үнэлсэн байна. Хээрийн хэмжилт, дээжлэлт, лабораторийн шинжилгээний дүнг эх хувиар, холбогдох фото болон бичлэгийг хавсаргана.

5. Физик бохирдол: Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, талбайн орчим дахь дуу чимээ, доргио чичиргээ, цацраг идэвхит бодисын эх үүсвэрүүд зэрэг физик бохирдлын эх үүсвэрүүд, тэдгээрийн өнөөгийн түвшин, түүнийг тодорхойлсон арга зүй, хэмжсэн багаж, тухайн орчин дахь хяналт шинжилгээний станцууд, түүний хэмжилтийн талаарх мэдээллийг оруулна. Дуу чимээ, доргио чичиргээ, цацраг идэвхт эх үүсвэрүүд зэрэг физик бохирдлын эх үүсвэрүүдийн өнөөгийн түвшинд үнэлгээ өгнө. Хээрийн хэмжилт, шинжилгээний дүнг эх хувиар, холбогдох фото болон бичлэгийг хавсаргана.

6. Геологийн тогтоц ба геоморфологи: Бүс нутгийн болон төсөл хэрэгжих орчны геологийн тогтоц, геотектоникийн нөхцөл, газар хөдлөл, геоморфологийн нөхцөлийг тодруулан холбогдох зураг, схемийг хавсаргана. Төслийн талбай, түүний орчим дахь газрын хэвлийн эвдрэл, доройтол, бохирдлын өнөөгийн түвшинг тодорхойлж, үнэлгээ өгсөн байна.

7. Гадаргын ус: Гадаргын усны сүлжээ, гадаргын усны урсац, нөөц, горим, чанар, төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний орчмын томоохон гол мөрний талаарх нарийвчилсан мэдээлэл, гадаргын усны харуул станц, тэдгээрийн байршил, олон жилийн хэмжилтийн мэдээллийн хангамж, гидрологийн хээрийн судалгааны арга зүйг тодорхойлон бичиж оруулна. Төслийн талбай, түүний орчим дахь гадаргын усны ашиглалт, бохирдол, хомсдолын өнөөгийн түвшнийг тодорхойлж, үнэлгээ өгсөн байна. Хээрийн хэмжилт, шинжилгээний дүнг эх хувиар, холбогдох фото болон бичлэгийг хавсаргана.

8. Газрын доорх ус: Төсөл хэрэгжих орчны болон төслийн талбайн гидрогеологийн нөхцөл, газрын доорх усны нөөц, горим, чанар, төслийн талбай дахь цооног, худаг, булгуудын мэдээлэл, газрын доорх усны хяналт, мониторингийн цэгүүдийн байршил, олон жилийн хэмжилтийн мэдээлэл, гидрогеологийн хээрийн судалгааны арга зүй зэргийг тодорхойлон бичиж оруулна. Төслийн талбай, түүний орчим дахь газрын доорх усны ашиглалт, бохирдол, хомсдолын өнөөгийн түвшнийг тодорхойлж, үнэлгээ өгсөн байна. Хээрийн хэмжилт, дээжлэлт, шинжилгээний дүнг эх хувиар, холбогдох фото болон бичлэгийг хавсаргана.

9. Хөрсөн бүрхэвч: Төсөл хэрэгжих орчны болон төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн хэвшинж, зузаан, тархалт, морфологи шинж, ширхэглэгийн бүтэц, ялзмаг, ус-физик болон хими шинжийн үндсэн үзүүлэлтүүд, тэдгээрийг хээрийн болон суурин судалгааны явцад тодорхойлсон мэдээллүүдийг оруулна. Төслийн талбай дахь хөрсний эвдрэл, бохирдол, цөлжилтийн

тодорхойлж, үнэлгээ өгсөн байна. Хээрийн хэмжилт, дээжлэлт, шинжилгээний дүнг эх хувиар, холбогдох фото болон бичлэгийг хавсаргана.

10. Ургамлан нөмрөг: Төсөл хэрэгжих орчны болон төслийн талбайн ургамлан нөмрөгийн хэвшинж, зүйлийн бүрдэл, ангилал, нэн ховор болон ховор ургамлын төрөл, зүйлүүд, түүний тархалт, хамгааллын статус, төслийн талбай түүний орчмын ургамлан нөмрөгийн доройтол, бэлчээрийн талхлагдал, ургамлын биомасс, бүрхэцийн үндсэн үзүүлэлтүүд, тэдгээрийг хээрийн болон суурин судалгааны явцад тодорхойлсон мэдээллүүдийг оруулна. Төслийн талбай дахь ургамлан нөмрөгийн доройтол, талхлагдалын өнөөгийн түвшнийг тодорхойлж, үнэлгээ өгсөн байна. Хээрийн хэмжилт, дээжлэлт, шинжилгээний дүнг эх хувиар, холбогдох хавсралт зураг, фото болон бичлэгийг хавсаргана.

11. Амьтны аймаг: Төсөл хэрэгжих орчны болон төслийн талбайд оршин амьдардаг, нутагладаг мөн дайран өнгөрдөг хөхтөн амьтад, шувуу, хоёр нутагтан, мөлхөгчид, загас шавжийн зүйлийн бүрдэл, амьдрах орчин, идэш тэжээлийн холбоо, ангилал, хамгааллын статус, тэдгээрийн амьдрах орчны талаар хээрийн болон суурин судалгааг хийж, үр дүнг оруулна. Зүйлийн бүрдлийн дэлгэрэнгүй жагсаалт, түүний тохиолдох магадлал, хоргодох дайжих, устах нөхцөлийн талаар тодорхойлон оруулна. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, төслийн талбай орчим дахь амьтдын хорогдол, үхэл, хууль бус агнуур, шилжилт хөдөлгөөний өнөөгийн түвшнийг тодорхойлж, үнэлгээ өгсөн байна. Холбогдох фото болон бичлэгүүдийг хавсаргана.

12. Тусгай хамгаалалттай газар нутаг: Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний орчим дахь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгуудын талаарх мэдээллүүд, түүний хамгааллын горим, ач холбогдол, хил зааг, байршил болон эзлэх талбай, орчны бүсийн эзлэх нутаг дэвсгэр, хил хязгаар зэргийг тодруулан тайлбарлаж оруулна. Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгааллын өнөөгийн байдал, гол зөрчлийг тодорхойлж, үнэлгээ өгсөн байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн зургийг зохих масштабаар гарган хавсаргана.

13. Түүх, соёлын өв: Төслийн талбай, түүний орчим дахь түүх, соёлын өв дурсгалууд, тэдгээрийн тодорхойлолт, байршил, шинжлэх ухааны болон соёл, түүхийн ач холбогдлын талаарх мэдээлэл, судлагдсан байдал, хамгааллын статус, улсын болон орон нутгийн соёлын өвд бүртгэгдсэн эсэх, бусад археологийн олдворуудын талаарх мэдээллийг оруулна. Төслийн талбай, түүний орчим дахь түүх, соёлын өв дурсгалуудын хамгаалал, арчилгаа, олон нийтэд өгч буй өгөөжийг тодорхойлж, үнэлгээ өгсөн байна.

14. Нийгэм, эдийн засаг: Төслийн талбай, түүний орчимд амьдардаг төслийн шууд болон шууд бус нөлөөлөлд өртөх магадлалтай өрхүүд, түүний гишүүдийн бүртгэл, тэдний өнөөгийн амьжиргаа, хөдөлмөр эрхлэлт, орлогын түвшин, эзэмшил газар, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, ус хангамж, бэлчээр, тариалангийн талбай, мэдээлэл, нийтлэг үйлчилгээ (боловсрол, эмнэлэг, ахуйн үйлчилгээ, цахилгаан хангамж г.м)-ний хангамжийн түвшин зэргийг судалж, дүнг тусгана. Үүнээс гадна хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслийн талаар мэдээлэл өгч, тэдний саналыг авч тусгана.

Мөн дээрх иргэдийн эрүүл мэндийн өнөөгийн түвшин, өвчлөл, дундаж наслалт, нутагшмал ба халдварт өвчний нэрвэгдэлтийн талаар болон тэдний ариун цэвэр, орчны эрүүл ахуйн гол үндсэн үзүүлэлтүүдийг судалж тусгана.

Төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн харьяалагдах засаг захиргааны нэгж баг, сум дүүрэг, аймгийн хүн ам, нас хүйс болон хөдөлмөрийн нөөц, төсвийн орлого, зарлага, ажил эрхлэлт, дундаж орлого, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, дэд бүтцийн хөгжлийн өнөөгийн түвшин, худалдааны эргэлтийн хэмжээ зэрэг нийгмийн болон эдийн засгийн хөгжлийн түвшинг илтгэх бусад үзүүлэлтүүдийг тодорхойлж, үнэлгээ өгсөн байна.

Мөн тухайн орчинд хэрэгжиж байгаа бусад төслүүдийн талаарх товч мэдээллийг энд оруусан байвал зохино.

15. Төслийн байгаль орчны болзошгүй нөлөөллүүд: Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт нөлөөлж болзошгүй хэлбэрүүд, түүний шинж чанар, нөлөөллийн цар хүрээ эрчмийг урьдчилсан байдлаар үнэлж тусгана. Мөн төслийн төлөвлөлтөд анхаарах байгалийн болон нийгмийн хүчин зүйлсийг тодорхойлж, байгаль орчин, нийгмийн нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор авах арга хэмжээний чиглэлийг тодорхойлно. Мөн цаашид байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийхэд анхаарах асуудлууд, зарим зөвлөмжийг тусгана.

16. Ашигласан мэдээлэл, эх сурвалж: Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний хээрийн болон суурин судалгааны явцад цуглуулан ашигласан бүхий л мэдээ, материал, интернет болон олон нийтийн сүлжээний мэдээллийг тэдгээрийн эх сурвалжуудын хамт жагсаана. Төлөв байдлын үнэлгээний тайлангийн аль хэсэгт түүнийг ашигласан талаар тэмдэглэгээ хийгдсэн байвал зохино.

2-Р ХЭСЭГ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ЕРӨНХИЙ ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

ГАРЧИГ

2.1 Ерөнхий үнэлгээний үндсэн зорилт, гол шаардлага.....	17
2.2 Ерөнхий үнэлгээ хийлгэхээр хүсэлт гаргах.....	17
2.3 Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийх	18
2.4 Ерөнхий үнэлгээний шийдвэрийн төсөл, түүнийг баталгаажуулах	20
2.5 Ерөнхий үнэлгээний түвшинд олон нийтийн оролцоог хангах нь.....	22

2.1 Ерөнхий үнэлгээний үндсэн зорилт, гол шаардлага

Ерөнхий үнэлгээний үндсэн зорилго нь Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага Монгол улсын байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомж, төр засгийн холбогдох бодлого шийдвэр, байгаль орчны стратегийн үнэлгээний зөвлөмж, стандарт, шаардлагууд, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан эсвэл тодорхойлолт, холбогдох бусад мэдээлэлд тулгуурлан аливаа төслийн баримт бичигт байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийж, тухайн төслийг хэрэгжүүлснээс байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилан тогтоон, уг төслийг хэрэгжүүлэх эсэх талаар зохих шийдвэрийг гаргахад оршино.

Ерөнхий үнэлгээг холбогдох төрийн байгууллагын тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн, шинжээч нар хэрхэн хийх, төсөл хэрэгжүүлэгч, төсөл хэрэгжих орон нутгийн иргэд, олон нийт болон бусад оролцогч, сонирхогч талуудын оролцоог хангах талаараргачлалыг энэ хэсэгт тусгав.

Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ нь тухайн төслийг хэрэгжүүлэх эсэх талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагаас гаргаж байгаа эхний бөгөөд чухал үр дагавартай шийдвэр тул шийдвэр гаргагчид болон түүнд оролцогч талууд холбогдох хууль тогтоомжийг ягштал баримталж, хариуцлагатай, нээлттэй байх шаардлага энэ шатанд тавигдана.

2.2 Ерөнхий үнэлгээ хийлгэхээр хүсэлт гаргах

Аливаа төслийг хэрэгжүүлэх иргэн, аж ахуйн нэгж нь байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх болон тухайн төслөө хэрэгжүүлэхээс өмнө төслийн ангилалын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсвэл тухайн төслийг хэрэгжүүлэх аймаг, нийслэлийн байгаль орчны газарт хандан байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийлгэнэ.

Ерөнхий үнэлгээ хийлгэхээр холбогдох төрийн байгууллагад хандаж буй төсөл хэрэгжүүлэгч дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлэх шаардлагатай.

Үүнд:

- Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт /албан бичиг/;
- Холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл;
- Тухайн төсөл нь хэрэгжих орон нутгийн хөгжлийн хөтөлбөртэй хэрхэн уялдах боломжтой талаарх сум, дүүргийн Засаг даргын санал;
- Газрын тос, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, байгалийн хий, аюултай хог хаягдал хадгалах, боловсруулах, устгах, тусгай хамгаалалттай газар нутаг, түүний орчны бүс болон ой, усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд хэрэгжүүлэх төслийн хувьд төсөл

хэрэгжих нутаг дэвсгэрт хийгдсэн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан;

- Дээр дурдсанаас бусад төсөлд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт;
- Төсөл хэрэгжүүлэгчийн аж ахуйн нэгж, байгууллагын гэрчилгээ, газар ашиглах, эзэмших, ашигт малтмал хайх, ашиглах талаарх эрх бүхий байгууллагын шийдвэр, эсвэл тусгай зөвшөөрөл, түүний эрхийг шилжүүлсэн тухай баримтын хуулбар;
- Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан байдлын тодорхойлолт;
- Уул уурхайн төслийн хувьд “Ашигт малтмалын тухай” хуулийн 25.1.7-д заасан шаардлагаар байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ гаргуулах төсөлд тухайн төслийн геологи, хайгуулын ажлын тайлан, ашигт малтмалын ордыг ашиглах техник эдийн засгийн урьдчилсан үнэлгээ, геологийн нөөцийг хэлэлцсэн эрх бүхий байгууллагын шийдвэр;
- Газрын тос, байгалийн хий, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуул хийх төсөлд хайгуулын ажлын батлагдсан төлөвлөгөө, тухайн сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын санал зэрэг болно.

Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний хүрээнд үнэлгээний шинжээч төсөл хэрэгжүүлэгчээс бүрдүүлж ирүүлсэн баримт бичгийн бүрдэл, агуулагдсан мэдээллүүд ерөнхий үнэлгээ хийхэд хангалттай эсэхийг шалгаж хүлээн авах хяналтын загвар хуудас (1-р хавсралтад тусгасан)-ыг бөглөж, хоёр тал (төсөл хэрэгжүүлэгч, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эсвэл аймаг, нийслэлийн байгаль орчны албаны төлөөлөл) гарын үсэг зурж баталгаажуулна. Баримт бичгийн бүрдэл дутуу, шаардлага хангаагүй тохиолдолд хариуцсан шинжээч/мэргэжилтэн ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж, үндэслэлээ бичгээр гарган буцаана. Ерөнхий үнэлгээ хийх явцад төсөл хэрэгжүүлэгчээс хүлээн авсан баримт бичгийг төрөлжүүлэн хаяглаж, зохих журмын дагуу архивт хадгална.

2.3 Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийх

Төсөл хэрэгжүүлэгчээс ерөнхий үнэлгээ хийлгэх хүсэлтийг хүлээн авсан төв болон орон нутгийн үнэлгээний шинжээч, мэргэжилтнүүд тэдгээрээс ирүүлсэн баримт бичгийг судлан үзэж доорх алхмуудын дагуу ерөнхий үнэлгээг хийж гүйцэтгэнэ.

Үүнд:

- Хэрэгжүүлэхээр боловсруулсан төслийн зорилго, цар хүрээ, техник, технологи, үйл ажиллагаа нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжид хэрхэн нийцсэнийг тодорхойлох;

- Төслийн үндсэн зорилт, арга хэмжээ, техник, технологи, үйл ажиллагаа нь тухайн чиглэлээр баримталж буй Төр засгийн бодлого, түүнд хийсэн байгаль орчны стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжид хэрхэн нийцэж буйг тогтоох;
- Төслийн байршлын сонголт нь хууль тогтоомжид нийцсэн эсэх, тодорхой бүс нутагт хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх талаар дүгнэлт хийх;
- Төслийн гол технологи, үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн анхан шатны (урьдчилсан) үнэлгээг хийж дүгнэлт гаргах;
- Төслийн үйл ажиллагаанаас нутгийн оршин суугчдад үзүүлэх нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээг хийж, хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй эрсдлийн талаар урьдчилсан дүгнэлтийг тус тус хийнэ.

Эдгээр алхмуудыг хийхдээ энэ аргачлалын 2-р хавсралтад тусгасан “Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудас”-ыг ашиглах бөгөөд алхам бүрд хийсэн ажлын үр дүнг үндэслэл, тайлбар гэсэн баганад тусгана.

Тухайлбал, эхний хоёр алхмыг гүйцэтгэхдээ төслийн баримт бичигт эрхзүйн энгийн харьцуулалт, дүн шинжилгээний аргыг ашиглах бөгөөд тухайн төслийн байршил, үйл ажиллагааны онцлог, технологи нь эрхзүйн хувьд хүчин төгөлдөр мөрдөж байгаа байгаль орчныг хамгаалах хууль, тогтоомжийг зөрчих эсэх, төрөөс тухайн чиглэлээр баримталж байгаа бодлогын баримт бичгүүдэд заасан зорилт, арга хэмжээтэй нийцэж байгаа эсэхийг хянан үзэж, нийцэхгүй байгаа хэсгүүдийг тодруулан “Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудас”-ны үндэслэл, тайлбар гэсэн баганад тусгана. Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд хууль, тогтоомж, бодлого, байгаль орчны стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжүүдийг нарийвчлан судалж үзэх шаардлагатай гэж үзвэл тухайн хэсэгт тэмдэглэгээ хийнэ.

Төслийн байршилтай холбогдсон дүгнэлтийг гаргахдаа холбогдох хууль тогтоомжийн хориглосон, хязгаарласан бүсүүд, тухайлбал, гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалын бүс, ойн сан бүхий газар, тусгай хамгаалалттай газар нутгийн хязгаарлалтын бүс болон хил хамгааллын бүсийн хил, дэглэм зөрчигдөхөөр байгаа эсэхийг хянах шаардлагатай. Мөн тухайн бүс нутагт төлөвлөж байгаа бусад төслүүд, бодлогын арга хэмжээний талаарх мэдээлэл дээр үндэслэн болзошгүй хуримтлагдах нөлөөлөл бий болох эсэх талаар эхний дүгнэлтийг хийж “Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудас”-ны үндэслэл, тайлбар гэсэн баганад тусгана.

Ерөнхий үнэлгээний шатанд төслийн гол технологи, үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн анхан шатны (урьдчилсан) үнэлгээг хийж дүгнэлт гаргах, төслийн үйл ажиллагаанаас нутгийн оршин суугчдад үзүүлэх нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээг хийж, хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй эрсдлийн талаар урьдчилсан дүгнэлтийг хийхдээ энгийн шалгуурын арга, асуулгын арга, дүн шинжилгээний аргуудыг ашиглан төслийн байгаль орчин, нийгмийн гол сөрөг нөлөөллийг тодорхойлно.

Энгийн шалгуурын арга нь: Төслийн төрөл, цар хүрээ, хэрэгжих хугацаа, төслийг хэрэгжүүлэх газар нутаг, техник технологи, үйл ажиллагааны явцад, тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй гол сөрөг нөлөөллийг тандах энгийн бөгөөд цөөн шалгуурыг төслийн болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн онцлогтой уялдуулан гаргаж, шалгууруудынхаа дагуу үнэлэн, нэгдсэн дүгнэлт гаргах үйл явц юм.

Асуулгын арга нь: Тухайн төслийн байгаль орчин, нийгмийн гол нөлөөллийг тодруулах асуулгыг боловсруулан төсөл хэрэгжүүлэгч иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох албан тушаалтан, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн оршин суугчид, тухайн салбарын эрдэмтэн-судлаачдаас авах замаар нөлөөллийг үнэлэх арга юм.

Дүн шинжилгээний арга нь: Өмнө энэ чиглэлээр хийгдсэн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, судалгааны мэдээлэл, бодлогын болон зөвлөмжийн баримт бичгүүдийг судлан тухайн санал болгож байгаа төслөөс байгаль орчин, нийгэмд үзүүлэх гол сөрөг нөлөөллийг тодорхойлон, түүнийг харьцуулан үнэлж дүгнэх арга юм.

Үүнээс гадна тухайн төсөлд ерөнхий үнэлгээ хийж байгаа мэргэжилтэн шинжээч уул уурхайн төслийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийхдээ геологи, хайгуулын ажлын үе шат, ашигт малтмалын ордын геологийн бодит болон ашиглах боломжит нөөц нь бүрэн тодорхойлогдсон эсэх, төсөлд ашиглахаар сонгосон технологи нь сүүлийн үеийн байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи мөн эсэх талаар анхаарах, дэд бүтцийн төслийн хувьд зам, эрчим хүч, холбоо харилцаа, хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөлттэй хэрхэн уялдаж байгааг, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээний төслүүдийн хувьд байгальд ээлтэй технологи ашиглаж байгаа эсэх, байгалийн нөөц баялгийг хэмнэлттэй, эргүүлэн ашиглах талаар тусгасан байдал, байгалийн үзэмж, экосистемийг үйлчилгээг тогтвортой байлгах талаарх шаардлагуудыг хангасан эсэхийг анхаарч үзвэл зохино.

Ерөнхий үнэлгээг хариуцан гүйцэтгэсэн шинжээч “Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудас”-ны дагуу үнэлгээний ажлын үр дүнг нэгтгэн нэгдсэн дүгнэлт гэсэн хэсэгт тусгаж, төслийг буцаах, хэрэгжүүлэхгүй байх талаар гаргасан дүгнэлтийн гол үндэслэл, нөхцөл болзлын гол шаардлага, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шатанд онцгойлон анхаарч судлах асуудлуудыг тодорхойлон уг хуудасны доод хэсгийн онцгойлон анхаарах зүйлс хэсэгт оруулна.

2.4 Ерөнхий үнэлгээний шийдвэрийн төсөл, түүнийг баталгаажуулах

Төсөлд ерөнхий үнэлгээ хийсэн шинжээч, мэргэжилтэн “Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудас”-ыг үнэн зөв бөглөсөн эсэхээ нягтлан шалгаж, түүнд асуултын дагуу хийсэн тэмдэглэгээ, тодруулсан үндэслэл, тайлбаруудаа нэгтгэн дараах шийдвэрийн төслийн аль нэгийг гаргаж нэгдсэн дүгнэлт гэсэн хэсэгт тусгана.

Үүнд:

1. “Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудас”-д заагдсан ерөнхий шалгууруудын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн нийцэлд зөрчилтэй гэж тэмдэглэгдсэн, эсвэл байршлын шалгууруудад “сөрөг нөлөөтэй” тэмдэглэгээ хийгдэж түүний үндэслэл тайлбар нь бүрэн гарсан, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн анхан шатны буюу урьдчилсан үнэлгээний шалгууруудын 90-ээс дээш хувьд нь “сөрөг нөлөөтэй” гэж тэмдэглэгдсэн төслийг хэрэгжүүлэх боломжгүй гэж дүгнэн, нэгдсэн дүгнэлт хэсэгт бичнэ. Энэ тохиолдолд онцгойлон анхаарах зүйлс гэсэн хэсэгт зөрчигдөж байгаа хууль, тогтоомж, бодлого, шийдвэрийн зүйл заалт, байгаль орчны стратегийн үнэлгээний дүгнэлтийн холбогдох заалтыг зааж өгнө.
2. “Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудас”-д заагдсан ерөнхий шалгууруудын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн нийцэлд зөрчилтэй гэж тэмдэглэгдээгүй, байршлын шалгууруудад нийцээгүй тэмдэглэгээ хийгдээгүй, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн анхан шатны буюу урьдчилсан үнэлгээний шалгууруудын 90-ээс дээш хувьд нь “сөрөг нөлөөгүй”, болзошгүй “сөрөг нөлөөтэй” боловч нарийвчилсан үнэлгээ шаардлагагүй байвал төслийг нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой гэж дүгнэн, нэгдсэн дүгнэлт хэсэгт бичнэ. Болзошгүй сөрөг нөлөөтэй гэж тэмдэглэгдсэн, эсвэл сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгоор төсөл хэрэгжүүлэгчийн зайлшгүй хийж гүйцэтгэх шаардлагатай ажил, түүний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, хэрэгжилтийг тайлагнах хэлбэр, хугацааг онцгойлон анхаарах зүйлс гэсэн хэсэгт тусгах бөгөөд төсөл хэрэгжүүлэгч нь ерөнхий үнэлгээний нөхцөл, болзолд заасан ажлын хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд гаргаж, ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.
3. “Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудас”-д заагдсан ерөнхий шалгууруудын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн нийцэлд зөрчилтэй гэж тэмдэглэгдээгүй, байршлын шалгууруудад “сөрөг нөлөөтэй” тэмдэглэгээ хийгдээгүй, хийгдсэн боловч түүнийг нарийвчилсан үнэлгээний хүрээнд тодруулахаар заасан, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн анхан шатны буюу урьдчилсан үнэлгээний шалгууруудын 40-өөс дээш хувьд нь “сөрөг нөлөөтэй” , нарийвчилсан үнэлгээ шаардлагатай гэж тэмдэглэгдсэн бол уг төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай гэж дүгнэн, нэгдсэн дүгнэлт хэсэгт бичнэ. Энэ тохиолдолд, сөрөг нөлөөтэй бөгөөд нарийвчилсан үнэлгээ шаардлагатай гэж тэмдэглэгдсэн хэсгүүд нь цаашид нарийвчилсан үнэлгээний ажлын нэмэлт чиглэл болно. Онцгойлон анхаарах зүйлс гэсэн хэсэгт дээрх тэмдэглэгдсэн хэсгээс гадна нэмж тусгах, нарийвчилсан үнэлгээний хүрээнд тодруулах зүйлсийг тусгана. Энэхүү хамрах хүрээ, чиглэлүүд нь эрх бүхий аж ахуйн нэгжийн нарийвчилсан үнэлгээ хийж гүйцэтгэх ажлын удирдамж болно.

Ерөнхий үнэлгээг гүйцэтгэсэн шинжээч төслийн баримт бичигт хийсэн байгаль орчны ерөнхий үнэлгээний үр дүнг тусгасан, бүрэн бөглөгдсөн “Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудас”-д өөрийн гарын үсгээ зурж, огноолон төсөл хэрэгжүүлэгчийн эрх бүхий албан тушаалтанд танилцуулна.

Улмаар шийдвэрийн төслийг ерөнхий шинжээчид танилцуулан түүний гол шаардлагуудыг тусгаж албан бичгийн хэлбэрээр боловсруулан ерөнхий шинжээчийн гарын үсгээр албажуулж, төсөл хэрэгжүүлэгчид хүргүүлнэ.

2.5 Ерөнхий үнэлгээний түвшинд олон нийтийн оролцоог хангах нь

Төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлгэхийн өмнө төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн нийгэм, эдийн засгийн талаарх мэдээлэл болон байгаль орчны төлөв байдлын тодорхойлолтыг бүрдүүлж, төслийн баримт бичигт хавсаргах бөгөөд орон нутгийн удирдлага, иргэд, олон нийттэй уулзалт, ярилцлага зохион байгуулж, төслийн талаарх мэдээллийг аль болох нээлттэй байдлаар хүргэнэ.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийлгэх шаардлагатай төслийн хувьд эрх бүхий мэргэжлийн байгууллага болон судалгаа, шинжилгээний байгууллага нь байгаль орчны төлөв байдлын үнэлгээг хийж гүйцэтгэх явцдаа олон нийтийн оролцоог хангах асуудлыг хариуцан гүйцэтгэсний үндсэн дээр үр дүнг нэгтгэн боловсруулж, байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайланд тусгана. БОНУ-ний эхний үе шатанд тухайн төслийн давуу болон сул талыг тодорхойлсноор үүсч болох аливаа асуудлуудын талаар олон нийт тодорхой мэдээлэлтэй болох, түүнд дүгнэлт хийх, өөрсдийн санаа бодлыг томъёолох боломжийг олгодог. Олон нийтэд төслийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл хүргэсэн тохиолдолд тэд төслийн ашигтай болон сул талыг ялгаж ойлгосны үндсэн дээр төслийн үйл ажиллагаанаас учруулах болзошгүй нөлөөллийг тодорхойлоход тус дэм үзүүлэхээс гадна төсөл хэрэгжүүлэгчтэй илүү итгэлцэл, үнэмшлийн үндсэн дээр харьцана.

Төсөл хэрэгжүүлэгч нь ерөнхий үнэлгээ хийлгэхээр бүрдүүлсэн төслийн баримт бичигтээ тухайн төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй хүн амын тоо, нас, хүйсийн ялгаа, суурьшлын бүсийн онцлог, зан заншил, нийгмийн хөгжлийн байдал, тухайн төслийг хэрэгжүүлэх, эсэх асуудлаар олон нийтийн баримталж буй үзэл бодол зэрэг холбогдох мэдээллийг тусгасан байна.

Ерөнхий үнэлгээний дүгнэлт, шийдвэр гаргах явцад олон нийтийн оролцоог хангах асуудлыг чухалчлан үзэж, өөрсдийн оршин суугаа нутаг дэвсгэрт хэрэгжих төслийн талаар олон нийт тодорхой мэдээлэл авч, хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэнд, нийгэмд учруулж болзошгүй нөлөөллийн талаар санал бодлоо илэрхийлэх боломж олгохын тулд аливаа төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар ерөнхий үнэлгээний түвшинд гаргасан дүгнэлт, шийдвэрийг олон нийтэд нээлттэй байлгаж, үнэн зөв мэдээллээр хангахад анхаарвал зохино.

Шинжээч нь ерөнхий үнэлгээний дүгнэлт, шийдвэрийн дагуу БОННУ хийх шаардлагатай, эсэхээс үл хамааран уг дүгнэлт, шийдвэрийг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагын цахим хуудсаар дамжуулж, шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан олон нийтэд мэдээлэх бөгөөд харин төсөл хэрэгжүүлэгч нь ерөнхий үнэлгээний дүгнэлт, шийдвэрийг орон нутгийн засаг захиргаа болон байгаль орчны албанд танилцуулна.

1-р хавсралт. Ерөнхий үнэлгээний хүсэлт, баримт бичиг хүлээн авах маягт

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:

Холбоо барих утас, И-мэйл хаяг:

Төслийн нэр:

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил:

Баримт бичгийн нэр	Шаардлагатай эсэх	Шаардлага хангасан эсэх	Тайлбар
Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт /албан бичиг/			
Эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан ТЭЗҮ, зураг төсөл			
Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан эсэх /газрын зөвшөөрөл, ТХГН-т байрлах бол Хамгаалалтын захиргааны санал/			
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт			
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан			
Төсөл хэрэгжих орчны тойм зураг (топо, сансрын)			
Тухайн сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт			
Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар батлуулсан байх/			
Уул уурхайн төслийн хувьд: а. Дээр дурдсан бүх баримт бичгүүд			
б. Тусгай зөвшөөрлийн хуулбар /нотариатаар батлуулсан байх/			
в. XV лицензтэй бол хайгуулын ажлын батлагдсан тайлан, нөөц баталсан шийдвэр			
г. MV лицензтэй бол эрх бүхий байгууллагаар батлагдсан ТЭЗҮ, нөөц баталсан шийдвэр			
д. БОНУ-ний нэмэлт, тодотгол хийлгэх төслийн хувьд нөөцийн хөдөлгөөний тайлан			
е. Төсөлтэй холбогдох зураг төсөл			
Төсөлд ашиглах түүхий эд бэлтгэн нийлүүлэгчийн талаарх мэдээлэл г.м.			
Тусгай тэмдэглэл:			

Хүлээн авсан материалын хуудасны тоо.....

Хүлээн авсан:
Овог, нэр:
Алба тушаал:
Гарын үсэг:

Хүлээлгэн өгсөн:
Овог, нэр:
Алба тушаал:
Гарын үсэг:

Огноо:

2-р хавсралт. Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудас

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:

Төслийн нэр:

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил:

Холбоо барих утас:

И-мэйл хаяг:

	Ерөнхий үнэлгээний гол шалгуурууд	Нийцсэн	Нийцээгүй	Нарийвчилсан үнэлгээ хийх шаардлагатай	Үндэслэл, тайлбар
Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн нийцэл	Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа байгаль орчныг хамгаалах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн холбогдох заалт				
Төрийн бодлого, шийдвэрийн нийцэл	Төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, Стратегийн үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийн холбогдох заалт				
Төслийн байршил, түүнтэй холбогдох шалгуурууд	Хуулиар хамгаалагдсан газар нутаг байгаа эсэх (урсац бүрэлдэх эх, ойн болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, хилийн хамгаалал-тын бүс, орон нутгийн тусгай хамгаалалттай газар г.м)				

	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь хүний нөлөө, байгаль цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх				
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлө-сөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх				
	Болзошгүй хуримтлагдах нөлөөлөл үүсгэх эсэх				
Төслийн байгаль орчны нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Агаарын чанар				
	Бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгаруулах, эсэх				
	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх, эсэх				
	Усан орчин				
	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх, эсэх				
	Цэнгэг усны нөөцийг ашиглах, эсэх				
	Гадаргын болон газрын доорх усанд бохирдол үүсэх, эсэх				
	Хөрсөн бүрхэвч				
	Хөрсөн бүрхэвч эвдрэх, эсэх				

	Хөрс бохирдуулах эсэх				
	Хөрс доройтох, цөлжих эсэх				
	Ургамлан нөмрөг				
	Ургамалан нөмрөг, ой мод өртөх эсэх				
	Ховор, нэн ховор ургамлын төрөл зүйлс өртөх, эсэх				
	Амьтны аймаг				
	Зэрлэг амьтдын амьдрах орчинг доройтуулах, эсэх				
	Ховор, нэн ховор амьтан өртөх, эсэх				
Нийгмийн нөлөөллийн урьдчилсан үнэлгээ	Нутгийн оршин суугчид				
	газар эзэмших, ашиглах эрх зөрчигдөх, эсэх				
	Нутгийн оршин суугчдын нийгмийн байдалд сөрөг нөлөөлтэй, эсэх				
	Нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа, эсэх				
	Нүүлгэн шилжүүлэх асуудал үүсэх, эсэх				
	Түүх, соёлын биет өв				
	Сөрөг нөлөөлөлд өртөх түүх, соёлын үнэт зүйлс бий эсэх				
	Хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөлөл				
	Нутгийн иргэд, оршин суугчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эсэх				

	Төслийн бүх үе шатанд хүний эрүүл мэнд, амь насанд эрсдэл үүсэх эсэх				
Нэгдсэн дүгнэлт:					
Онцгойлон анхаарах зүйлс:					
Ерөнхий үнэлгээ хийсэн Овог, нэр: Алба тушаал: Гарын үсэг: Огноо:			Ерөнхий үнэлгээний үр дүнг зөвшөөрсөн: Овог, нэр: Алба тушаал: Гарын үсэг: Огноо:		

3-р хавсралт. Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн хэлбэр

Огноо_____

Дугаар____

Ерөнхий үнэлгээний дүгнэлт хүргүүлэх тухай

Танайхаас боловсруулж ирүүлсэн аймгийнсумын нутаг, газарт хэрэгжүүлэх төслийн баримт бичигт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7-р зүйлийн 7.3, түүнийг хэрэгжүүлэх журмын 2-р зүйлийн 2.1-г үндэслэн, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний батлагдсан аргачлалд заасны дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийлээ. Ерөнхий үнэлгээний дүнгээр тус төслийг хэрэгжүүлэх боломжгүй (төслийг нөхцөл болзолтойгоор хэрэгжүүлэх боломжтой эсхүл төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэх шаардлагатай) гэж үзэв.

Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг боловсрууланоныулиралд багтаан БОНХЯ-нд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Жич: Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудсыг хавсаргав.

БОНХЯ-ны Ерөнхий шинжээч _____

(Орон нутагт:

) Аймгийн БОГ-ын шинжээч -----

3-Р ХЭСЭГ
БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭ
ХИЙХ АРГАЧЛАЛ

ГАРЧИГ

3.1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гол зорилт, тавигдах үндсэн шаардлага	32
3.2 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үе шат	33
3.3 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гүйцэтгэл.....	33
3.3.1 Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын удирдамжийг боловсруулах	33
3.3.2 Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлох	34
3.3.3 Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг үнэлэх	36
3.3.4 Төслийн сөрөг нөлөөлөл багатай хувилбарыг тодорхойлох	42
3.3.5 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, үр дагаврыг арилгах арга хэмжээг тодорхойлох	43
3.3.6 Нөхөн сэргээх болон дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тогтоох	44
3.3.7 Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нутгийн оршин суугчдад учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээг хийх.....	51
3.3.8 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох	52
3.4 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нийгмийн нөлөөллийн асуудлыг авч үзэх нь.....	53
3.4.1 Нийгмийн нөлөөллийн үнэлгээний ажлын удирдамж	53
3.4.2 Төслөөс нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлох	53
3.4.3 Төслийн үр дүнд үүсэх нийгмийн сөрөг нөлөөллийг үнэлэх	54
3.4.4 Нийгмийн сөрөг нөлөөлөл багатай хувилбарыг тодорхойлох	54
3.6 Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүний техникийн бус хураангуйг боловсруулах	56
3.7 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн агуулга, хэлбэр	56

3.1 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гол зорилт, тавигдах үндсэн шаардлага

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гол зорилт нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм, оршин суугчдын эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, түүний сөрөг үр дагавар, түүнээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг тогтоох явдал юм.

Аливаа төслийг хэрэгжүүлэхээс өмнө түүний хэрэгжилтийн явцад байгаль орчин, нийгэм, оршин суугчдын эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээг тогтоосноор тухайн төслийг хэрэгжүүлэх эсэх талаар төрийн байгууллагаас, санхүүжүүлэх эсэх талаар банк, санхүүгийн байгууллагаас, төслийн нөлөөлөлд өртөгсдийн талаар орон нутгийн захиргаа, төсөл хэрэгжүүлэгчээс шийдвэр гаргахад шаардлагатай үндсэн мэдээлэл болно. Үүнээс гадна бусад оролцогч, сонирхогч талуудыг бодитой мэдээллээр хангахад чухал ач холбогдолтой.

Төсөл хэрэгжүүлэгч нь хуулийн энэ шаардлагыг хэрэгжүүлэхдээ байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас эрх авсан мэргэжлийн байгууллагуудаас сонгон авч байгаль орчны төлөв байдлын болон нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааны дүнд түшиглэн гүйцэтгүүлэх нь дээр дурдсан үндсэн зорилтыг хангах, байгаль орчны нөлөөллийн чанар үр өгөөжийг дээшлүүлэх, энэ чиглэлээр тавигддаг олон улсын нийтлэг жишигт нийцүүлэхэд онцгой чухал ач холбогдолтой.

Иймд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэх тусгай зөвшөөрөл, эрхийг аж ахуйн нэгж байгууллагад олгохдоо тэдний мэргэжлийн ур чадвар, мэдлэг, мэдээллийн сан, судалгаа, шинжилгээний ажил гүйцэтгэсэн туршлага, мэргэжлийн багийн бүрдэл, чадавхи, тухайн байгууллагын санхүүгийн тогтвортой байдал, хариуцлага хүлээх чадавхийг харгалзаж, ил тодоор сонгон шалгаруулж олгох нь чухал. Төсөл хэрэгжүүлэгч өөрсдийн төслийн онцлог, үнэлгээний мэргэжлийн байгууллагын чадавхийг харгалзан өрсөлдүүлэх зарчмаар шалгаруулж гүйцэтгүүлэхэд анхаарах ёстой. Мэргэжлийн байгууллагууд өөрсдийн мэргэжлийн ур чадвар, чадавхийг байнга дээшлүүлж, энэ чиглэлээр монгол улсын болон олон улсын нийтлэг болон тусгай шалгууруудыг хангасан нөлөөллийн үнэлгээг гүйцэтгэдэг байх шаардлагатай.

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнг харгалзан гаргах аливаа төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, банк санхүүгийн болон холбогдох бусад байгууллагын шийдвэр нь ил тод, нээлттэй, хариуцлагатай байж, олон талын оролцоог хангасан, талуудын хууль ёсны эрх ашгийг хангасан байх ёстой.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэхдээ энэ талаарх Монгол улсын хууль тогтоомжоор хүлээсэн

мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэхдээ энэхүү аргачилсан зааврыг баримталвал зохино.

3.2 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үе шат

Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг доорх үе шатуудаар дамжин гүйцэтгэнэ.

Үүнд:

- Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын удирдамжийг боловсруулах;
- Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлох;
- Болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг үнэлэх;
- Төслийн сөрөг нөлөөлөл багатай хувилбарыг сонгох;
- Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, үр дагаврыг арилгах арга хэмжээг тодорхойлох;
- Нөхөн сэргээх болон дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тогтоох;
- Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нутгийн оршин суугчдад учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээг хийх;
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ шалгуур үзүүлэлтүүд;
- Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүний техникийн бус хураангуйг боловсруулах зэрэг орно.

3.3 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гүйцэтгэл

3.3.1 Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын удирдамжийг боловсруулах

Төсөл хэрэгжүүлэгч тухайн төсөлд хийсэн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний үр дүн, нэгдсэн дүгнэлт, холбогдох хууль тогтоомжийг үндэслэн нарийвчилсан үнэлгээний гол зорилтууд, хийгдэх ажлын хамрах хүрээ, онцгойлон анхаарах асуудлууд, тэдгээрт тавигдах шаардлага, гүйцэтгэх хуваарийг тодорхой тусгасан ажлын удирдамжийг боловсруулна. Мөн ажлын удирдамжид баримталж ажиллах стандарт, норм дүрмийг оруулахаас гадна шаардлагатай бол энэ талаар олон улсад мөрддөг нийтлэг шаардлага, банк, санхүүгийн байгууллагаас тавьдаг шалгууруудыг хангах нөхцөлийг тавьж болно. Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэх хугацаа, үе шат түүнд тавих хяналтын талаар болон төсөл хэрэгжүүлэгчийн талаас тавих нэмэлт нөхцөл, шаардлагыг тодорхойлон тусгаж болно.

Ингэж хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ерөнхий үнэлгээний дүгнэлтэд тавигдсан шаардлагуудыг биелүүлэхэд чиглэгдсэн ажлын удирдамжийг үндэслэн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний эрх бүхий ААН-ийг сонгон шалгаруулна.

3.3.2 Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлох

Төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэхээр шалгарсан эрх бүхий аж ахуйн нэгж түүний мэргэжилтэн, экспертүүд тухайн төслийн баримт бичиг, тодорхойлолт болон техник, эдийн засгийн үндэслэл (Feasibility Study Report), зураг төсөл (Design Parameters and Layouts)-тэй нарийвчлан танилцаж, түүнд хийсэн ерөнхий үнэлгээний дүгнэлт, нарийвчилсан үнэлгээний ажлын удирдамжийг судлан төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг дараах алхмуудаар тодорхойлно.

Үүнд:

- Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр түүний орчмыг оруулсан байрзүйн дэвсгэр зураг, агаар, сансрын зургийг бэлтгэж, тэдгээр дээр төсөл хэрэгжүүлэх байршил, түүний үйл ажиллагаа явагдах газар, объектуудыг тэмдэглэх;
- Төслийн баримт бичигт туссан гол зорилго, техник, технологи, эдийн засгийн хүчин чадал, үндсэн болон туслах үйл ажиллагааны хамрах хүрээ, онцлогийг тодорхойлон түүнд байгаль орчны шинжилгээ хийж, түүний гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тодорхойлох;
- Төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн оршин суугчид, тэдгээрийн нийгмийн байдал, түүх, соёлын өв, экосистемийн бүрэлдэхүүн хэсгийн харилцан үйлчлэлээр нь онцгой чухал ач холбогдол бүхий газар нутаг, биологийн олон янз байдлыг тодорхойлох зэрэг орно.

Төслийн гол зорилго, техник, технологи, эдийн засгийн хүчин чадал, үндсэн болон туслах үйл ажиллагаанд байгаль орчны шинжилгээ хийхдээ дараах асуудлуудад анхаарч нарийвчлан авч үзнэ.

Үүнд: Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжих болон хаалтын үе шатанд тухайн орон нутгийн хувьд физик өөрчлөлт (ландшафт, газар ашиглалт, хөрс, уст давхаргад гарах өөрчлөлт г.м.) гарах, эсэх, төсөл хэрэгжүүлэх зориулалтаар усны нөөцийг ашиглах эсэх, гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх эсэх, үл нөхөн сэргээгдэх болон байгалийн ховор нөөц, баялгийг ашиглах эсэх, тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис, материалыг ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах, үйлдвэрлэх үйл ажиллагаа явагдах эсэх, төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд хатуу хог хаягдал гарах эсэх, төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд шингэн хаягдал /бохир ус/ гарах эсэх, төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аливаа төрлийн бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгарах эсэх, төсөл хэрэгжүүлэх явцад дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх эсэх, гадаргын болон газрын доорх усанд бохирдуулагч бс

бохирдол үүсэх эсэх, төслийн барилга байгууламжийн болон хэрэгжилтийн үе шатанд хүний эрүүл мэнд, амь нас, байгаль орчинд нөлөөлөхүйц осол аваар, эрсдэл гарах эсэх, төслийн хэрэгжилттэй холбоотойгоор нийгэмд тодорхой өөрчлөлт гарах эсэх (тухайлбал, хүн амын амьжиргааны түвшин өөрчлөгдөх, бизнесийн таатай орчин бүрэлдэх, орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх, шинээр ажлын байр бий болох, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, эсвэл уламжлалт амьдралын хэв маяг өөрчлөгдөх, хөдөлмөр эрхлэлтэд өөрчлөлт гарах, тухайн орон нутгийн оршин суугчдын зан үйл, шашин шүтлэг, дасан зохицсон амьдралд сөргөөр нөлөөлөх г.м), хөгжлийн хэтийн төлөвлөгөө, тухайн үед орон нутагт хэрэгжиж байгаа буюу хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл, бусад хүчин зүйлс байгаа эсэх, байгаль орчны бохирдол, доройтол үүсгэж болзошгүй зам, тээврийн үйл ажиллагаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд явагдах эсэх зэрэг орно.

Төслийн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн оршин суугчид, тэдгээрийн нийгмийн байдал, түүх, соёлын өв, экосистемийн үйлчилгээнд нь онцгой чухал ач холбогдол бүхий газар нутаг, биологийн олон янз байдлыг тодорхойлохдоо дараах асуудлуудад анхаарал хандуулж, нарийвчлан авч үзнэ. Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр болон түүний ойр орчинд сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй түүх, соёлын үнэт зүйлс, дурсгалт газар, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутаг байгаа эсэх, төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчинд сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй ус намгархаг газар, онцгой тогтоцтой уулс, ой мод зэрэг экологийн чухал ач холбогдол бүхий эмзэг газар байгаа эсэх, төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний орчинд ховор, нэн ховор амьтан, ургамлын төрөл зүйлс байгаа эсэх, амьтдын үржил, нийллэгт орох, үүрлэж байрлах, идэш тэжээлээ эрж хайх, ус бараадаж ундаалах, өвөлжих, нүүдэл, шилжилт хөдөлгөөн хийх зэрэгт нь нөлөөлөхүйц сөрөг нөлөөлөл үүсэх эсэх, төсөл хэрэгжих нутаг дэвсгэр болон түүний ойр орчинд сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй байгалийн үзэсгэлэнт газар нутаг байгаа эсэх, амралт, зугаалгын газар, бусад зориулалтаар олон нийтийн ашигладаг барилга байгууламж, тэдгээрт хүрэх замын маршрут төслийн нөлөөлөлд өртөх эсэх, өмнө ямар нэг төсөл хэрэгжиж байгаагүй онгон зэлүүд газарт хэрэгжих эсэх, төслийн байршил, түүний ойр орчимд ямар нэг хэлбэрээр ашиглагдаж байгаа, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй эдэлбэр газар (орон сууц, цэцэрлэгт хүрээлэн, хувийн эзэмшлийн газар, аж үйлдвэр, арилжаа худалдаа, амралт сувилал, аялал жуулчлалын зориулалттай газар, олон нийтийн чөлөөтэй зорчих газар, орон нутгийн эзэмшлийн газар, ой бүхий талбай, ХАА-н болон уул уурхайн эдэлбэр газар г.м.) байгаа эсэх, төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд улс, орон нутгийн хэтийн хөгжилд ашиглахаар төлөвлөсөн, сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй газар байгаа эсэх, төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй төв, суурин газар байгаа эсэх, төсөл хэрэгжих нутаг дэвсгэр болон түүний ойр орчимд эмнэлэг, сургууль, шашны мөргөлийн газар, орон нутгийн нийтийн үйлчилгээний барилга байгууламж зэрэг нүүлгэн шилжүүлэхэд хүндрэл учруулах.

өртөж болзошгүй газар нутаг байгаа эсэх, тухайн төслийг хэрэгжүүлэхээс өмнө хүний үйл ажиллагааны улмаас бохирдол, доройтолд орсон, өөрөөр хэлбэл, байгаль орчны стандартын үзүүлэлтүүдээс хэтэрсэн бохирдол, доройтол үүссэн, төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй газар нутаг төслийн байршил, түүний ойр орчимд байгаа эсэх, төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь газар хөдлөл, хөрсний суулт, гулсалт, элэгдэл, эвдрэл, үер ус, температурын огцом өөрчлөлт, манан будан, хүчтэй салхи шуурга зэрэг байгаль, цаг уурын өөрчлөлтөд эмзэг, мэдрэмтгий эсэх зэрэг орно.

3.3.3 Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг үнэлэх

Тухайн төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг үнэлэхдээ өмнөх шатанд тодорхойлогдсон болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд, түүний үйлчлэлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нутгийн оршин суугчид, түүх, соёлын өвд бий болох сөрөг үр дагавар, түүний эрчим, цар хүрээ, шууд болон шууд бус нөлөөллүүд, болзошгүй хуримтлагдах нөлөөллийг Монгол улсын хууль тогтоомжид заасан болон олон улсын нийтлэг аргуудыг ашиглан үнэлнэ. Энэ үнэлгээг доорх алхмуудаар гүйцэтгэнэ.

Үүнд:

- Өмнөх шатанд тодорхойлсон төслийн байгаль орчин, нийгмийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийн цар хүрээ, эрчим, хугацаа, шинж чанарыг тодорхойлж, тоон ба чанарын шинжилгээ хийх;
- Болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг төсөл хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээний (зохих аргачлалын дагуу хийгдсэн) мэдээлэлд буулгансудалж, сөрөг нөлөөллийн тархалт, үр дагаврыг үнэлэх;
- Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд төсөл хэрэгжих болон төслийн нөлөөлөлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн өнөөгийн төлөв байдал, бохирдол, доройтлын түвшнийг тогтоох нэмэлт судалгаа, шаардлагатай туршилт, ажиглалт, хяналт шинжилгээний ажлыг гүйцэтгэх зэрэг орно.

Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг үнэлэхдээ өнөөгийн байдлаар дэлхий нийтэд өргөн ашигладаг аргуудаас тухайн асуудлын онцлогтой холбогдуулан хамгийн оновчтой нэг аргыг эсвэл давуу болон сул талыг нь нөхсөн хоёр буюу түүнээс дээш аргыг хослуулан ашиглаж, үр дүнд анализ, тайлбар хийж тайланд тусгана. Эдгээр аргуудад экспертийн үнэлгээ, газар зүйн мэдээллийн системийн цаг хугацаа болон орон зайн давхцуулан зураглах арга, эрсдэлийн үнэлгээний аргууд, сүлжээний анализын арга, харилцан үйлчлэлийн матриц, олон үйл ажиллагааны харилцан үйлчлэлийн матрицын арга, математик-статистикийн аргууд, эрүүл мэндийн тандалт үнэлгээний арга, нийгэм-байгаль орчны тогтолцооны эзмэг байдлын загварчлал, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний аргууд зэрэг орно.

Эдгээр аргуудын гол тодорхойлолт, зориулалт, ач холбогдлыг тодруулан доорх шигтгээнүүдэд оруулав.

Шигтгээ 1

Зориулалтын арга (Ad hoc)

Тодорхойлолт: Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд оролцож буй туршлага бүхий экспертүүдийн судалгаа, шинжилгээний ажлын үр дүнд тулгуурлан хамтарсан дүгнэлт гаргах, харилцан санал солилцоход үндэслэн хийгддэг бөгөөд албан бус процессод тулгуурладаг.

Үндсэн боловсруулалт: Үндсэн арга зүй нь нөлөөллийн байж болох эх үүсвэрүүдийг аль болох бүрэн хамруулан тодорхойлох, нөлөөлөлд өртөж болзошгүй объектууд, бүх орчинг тодорхойлох зорилт тавьдаг.

Оролтын мэдээ: Судалгаа, шинжилгээний ажлын үр дүн.

Үр дүн: Экспертүүдийн гаргасан дүгнэлтүүдээс хэд хэдэн хувилбарыг боломжтой үзүүлэлт, параметрээр нь харьцуулан үзэж, санал дүгнэлт гаргана.

Эх сурвалж:

2. <http://www.unep.org>

Шигтгээ 2

Удирдамж, гарын авлагын арга (Guidelines)

Тодорхойлолт: Урьдчилан боловсруулсан удирдамж, гарын авлагыг ашиглан тухайн төслөөс хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах нөлөөллийг тогтоох арга юм.

Үндсэн боловсруулалт: Удирдамж, гарын авлагын аргыг ижил төрлийн төслүүд, эсвэл тодорхой салбарууд (хөдөө аж ахуй, усны аж ахуй, газар тариалан, уул уурхай, хүнд болон хөнгөн үйлдвэрүүд, зам тээвэр, эрчим хүч, хөгжлийн төслүүд, нийтийн аж ахуй, аялал жуулчлал, үйлдвэрлэл үйлчилгээ гэх мэт)-аар байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийхэд тохируулан боловсруулдаг.

Оролтын мэдээ: Удирдамж, гарын авлага

Үр дүн: Төслөөс хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах нөлөөллийг тогтооно.

Эх сурвалж:

3. <http://www.unep.org>

Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга (Checklist)

Тодорхойлолт:Магадлан жагсаах буюу хяналтын хуудасны арга нь байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдийн төрлийг жагсаан тэдгээрийг төсөлтэй холбоотойгоор харьцуулан тодорхойлсон хүснэгт бүрдүүлэх арга юм.

Үндсэн боловсруулалт:Аливаа үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах үеийн үйл ажиллагаа нь тухайн орон нутгийн байгаль орчны төлөв байдал болон нийгэм, эдийн засагт хэрхэн нөлөөлөх, нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчимшил зэргийг тодорхойлохын тулд магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргыг өргөн хэрэглэдэг. Энэ арга нь экспертүүдийн гаргасан үнэлэлт, дүгнэлтүүдийг магадлалын онолд тулгуурлан боловсруулах замаар хэрэгждэг.

Оролтын мэдээ:Экспертүүдийн гаргасан үнэлэлт, дүгнэлт

Үр дүн:Төслөөс хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах нөлөөллийг тогтооно.

Эх сурвалж:

4. <http://www.unep.org>

Асуулгын хуудасны арга (Questionnaire)

Тодорхойлолт:Төсөл хэрэгжүүлэгч иргэн болон аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох албан тушаалтан, тэрчилэн тухайн төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэд зэрэг төслийн үйл ажиллагааны сайн, муу үр дагаврыг шууд хүртэх харилцан хамаарал бүхий хүмүүсээс асуулга авах замаар нөлөөллийг үнэлэх арга юм.

Үндсэн боловсруулалт:Төслийн үйл ажиллагааны сайн, муу үр дагаврыг шууд хүртэх харилцан хамаарал бүхий хүмүүсээс асуулга авах замаар нөлөөллийг үнэлнэ.

Оролтын мэдээ:Санал асуулга

Үр дүн:Төслөөс хүний эрүүл мэнд, байгаль орчинд учруулах нөлөөллийг тогтооно.

Эх сурвалж:

5. <http://www.unep.org>

Матрицийн арга(Matrices)

Тодорхойлолт:Тухайн төслийн үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулах эерэг, сөрөг нөлөөллийг уялдуулан авч үзэж, нөлөөллийг бүрэн тодорхойлох боломж өргөнтэй арга юм.

Үндсэн боловсруулалт:Төслийн үйл ажиллагаатай шууд хамааралтай асуудлууд болон байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдтэй холбоотой асуудлыг матрицийн босоо, хэвтээ шугамын дагуу ангилан байрлуулж харилцан үйлчлэлийг нь матрицын талбар дээр тэмдэглэнэ. Матрицыг бүрдүүлэхэд төслийн үйл ажиллагааны жагсаалт болон байгалийн нөхцөл байдлын хүснэгт, картыг ашигладаг.

Оролтын мэдээ:Төслийн үйл ажиллагаатай шууд хамааралтай асуудлууд болон байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдтэй холбоотой асуудлууд

Үр дүн:Мөр болон баганын нийлбэр тоон үзүүлэлт нь цаашид төслийн аль үйл ажиллагаа эсвэл орчны аль хэлбэрт илүү анхаарал тавихыг тогтооход ашиглагдана. Нийлбэр тоон үзүүлэлтийг зарим тохиолдолд “эзлэх жин” гэж нэрлэдэг.

Эх сурвалж:

6. <http://www.unep.org>

Сүлжээ схемийн арга(Netwoks)

Тодорхойлолт:Сүлжээ-схемийн арга нь шууд бус нөлөөллийг тодорхойлох талаараа бусад аргуудаас давуутай. Сүлжээний салаа мөчрийг тодорхойлох замаар хоёрдогч болон гуравдагч нөлөөллийг тодруулж болдог.

Үндсэн боловсруулалт:Төслийн үйл ажиллагаатай уялдуулан шууд нөлөөллийг тодорхойлох бөгөөд энэ зорилгод шалгах хуудас болон матрицийн аргыг ашиглаж болно. Шууд нөлөөллөө хөтлөгч сүлжээгээр дамжуулан шууд бус нөлөөллийг тодорхойлно. Энэ аргыг тооцоолон бодох хэрэгсэл дээр амжилттай хэрэгжүүлж болдог.

Оролтын мэдээ:Шууд нөлөөлөл

Үр дүн:Шууд бус нөлөөллийг тодорхойлно.

Эх сурвалж:<http://www.unep.org>

Давхцуулан зураглах арга(Overlays mapping)

Тодорхойлолт: Төслийн олон талын үйл ажиллагаатай холбогдон тухайн орчинд гарах өөрчлөлтийг зураг дээр тусган харуулж, түүнийг төсөл хэрэгжихээс өмнөх үеийн зурагтай давхцуулан тавьж үзэх замаар гарч буй өөрчлөлтийг судлан дүгнэлт гаргах арга юм.

Үндсэн боловсруулалт:Зургуудыг давхцуулан үзэж, ямар нөлөөлөл чухал болохыг тодорхойлно. Хүн ам суурьшсан байрлалтай дуу чимээний тархалтын чиглэл таарч өндөр хэмжээтэй байвал энэ нь цаашид анхааран авч үзэх нэг чухал нөлөөлөл гэж тодорхойлогдох жишээтэй.

Оролтын мэдээ:

- Хөдөө аж ахуйн эдэлбэр газар;
- Ой, биологийн төрөл зүйлийн чухал нөлөө бүхий орчин;
- Эмзэг мэдрэмтгий орчин /шувуу цуглардаг цөөрөм г.м/;
- Түүх, соёл, археологи, палеонтологийн хувьд ач холбогдол бүхий орчин;
- Хүн ам төвлөрөн оршин суудаг газар нутаг;
- Дэд бүтэц /ус хангамж, эрчим хүчний хангамж, барилга байгууламж, зам, харилцаа холбоо, шугам сүлжээ/;
- Байгалийн үзэсгэлэнт газар;
- Тусгай хамгаалалттай газар нутаг гэх мэт.

Үр дүн:Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийхэд төслийн үйл ажиллагаанд хамааралтай бүх төрлийн зургуудыг давхцуулан харж, цогц байдлаар дүгнэлт гаргавал бодит үр дүнд хүрнэ.

Эх сурвалж:<http://www.unep.org>

Бателлийн систем

Тодорхойлолт:Энэ системийг усны нөөцийг ашиглах төсөлд зориулж анх боловсруулсан боловч, цаашдаа тээврийн болон бусад салбарт хэрэглэж ирсэн.

Үндсэн боловсруулалт:Уг системийг ашиглахдаа нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр тодорхойлж, байгаль орчны үзүүлэлт бүрийг ач холбогдлоор нь жагсаадаг.

Оролтын мэдээ:

Байгаль орчны чанар ба үзүүлэлт хоорондын харилцан хамаарлыг харуулсан мэдээлэл.

Үр дүн:Байгаль орчинд учруулах нөлөөллийг тогтооно.


Эх сурвалж:<http://www.unep.org>

Газар зүйн мэдээллийн системийн зөвлөмж (GIS)

Тодорхойлолт: Газар зүйн мэдээллийн системийг ашиглан өргөн уудам нутаг дэвсгэр дээрх хүний үйл ажиллагаа болон бусад нөлөөллөөр бий болсон өөрчлөлтүүдэд чанарын үнэлгээ өгөх боломжтой.

Үндсэн тэгшитгэл: Судалгааны зорилгоос хамаарч газар зүйн мэдээллийн системд байгаа арга зүйнүүдээс сонгож авч хэрэглэнэ (*Жишээлбэл, газар ашиглалтын өөрчлөлтийг судлахаар болон supervised/unsupervised ангиллын арга, орон зайн дүн шинжилгээнд Spatial analysis арга г.м*).

Оролтын мэдээ: Ямар дүн шинжилгээ хийх гэж байгаагаас хамаарна. Жишээлбэл, нөлөөллүүдийн орон зайн давхцалыг тодруулахад дараах мэдээллийн бааз хэрэглэгдэж болно.



Үр дүн: Энэ загвараар тухайн бүс нутаг, сав газар, нутаг дэвсгэрийн орон зайн зураглалыг хийхэд хэрэглэж болно.

Боловсруулалт: Тус загвар нь Window болон UNIX-ийн орчинд ажиллана

Эх сурвалж: <http://www.esri.com>

Мөн дээр дурдсан аргуудтай хамтатган ашиглаж сөрөг нөлөөллийн тархалт, эрчим, өөрчлөлт, цаг хугацааны үргэлжлэл, сөрөг үр дагаврын цар хүрээ, хам болон хоёрдогч нөлөөллийг нарийвчлан тодорхойлох зорилгоор математик статистикийн болон тодорхой зориулалттай загварчлалын аргуудыг ашиглах шаардлага тавигдана. Ийм зорилгоор ашиглах загварчлал нь өнөөдөр байгаль орчны үнэлгээ, нөлөөллийн шинжилгээнд ашиглаж байгаа доорх хүснэгтэд тусгасан загварчлалууд байж болох бөгөөд сүүлийн үеийн арга технологи, техникийн дэвшилт тулгуурласан бусад аргууд нь эдгээр загварчлалын нарийвчлал, шаардлага, ач холбогдлоос дутуугүй байх шаардлагатай.

Хүснэгт 3.1 Үнэлгээний судалгаанд ашиглах байгаль орчны загварчлалын аргууд

#	Тодорхойлох үзүүлэлт	Загварчлал, аргын нэр
1	Хүний аливаа үйл ажиллагаатай холбоотойгоор үүссэн газрын элэгдэл эвдрэлийн хэмжээг тогтоох	LANDSAT, SPOT, MODIS зэрэг хиймэл дагуулын мэдээг ашиглан орон зай болон цаг хугацааны хувьд гарсан өөрчлөлтийг тогтоох
2	Ус ба хөрсний бохирдлын түвшинг тогтооход лабораторын анализын аргууд	Устөрөгчийн илтгэгч, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, ууссан хүчилтөрөгчийн хэмжээ, хүнд металлын бохирдол гэх мэт
3	Агаарын чанар, бохирдлын тархалтыг тодорхойлоход	AirMod, ISC3 загвар
4	Тухайн экосистемийг шүтэж амьдрах биологийн төрөл зүйлийн амьдрах орчны загварчлалын /Potential Habitat Model/ арга	Тэдгээрт үзүүлэх нөлөөллийг тодорхойлоход Threats, Disturbance/Condition Index орон зайн анализын аргуудыг хэрэглэх
5	Эдэлбэр газрын бэчээрийн даацын өөрчлөлтийн нөлөөллийг тогтооход	VELMA, Century экологийн загваруудыг
6	Урсацын одоогийн болон ирээдүйн өөрчлөлтийн нөлөөллийг тооцоход	HBV, TOPLAST загваруудыг
7	Газрын доорх усны нөлөөллийг тооцоход	MODFLOW загварыг
8	Бүс нутгийн уур амьсгалын өөрчлөлтийн загваруудыг ашиглах, ус ашиглалтын улмаас голын урсацад үзүүлэх нөлөөллийг тооцох	Sobek, RIBASIM загваруудыг

Дээр дурдсан үнэлгээний судалгаа, ажлын үр дүнд тухайн нутаг дэвсгэрийн байгалийн төрх, ландшафтын хэлбэр өөрчлөгдөх, газрын дорх усны нөөцийн хомсдол, чанар, ундны усны чанар, усны шүүрэлт, алдагдал, ургамалан нөмрөг устах, ургамлын төрөл, зүйл, ховор болон нэн ховор ургамлын нөөц хомсдох, бэлчээрийн талбай талхлагдах, тэжээлийн нөөц хорогдох, хөрсний элэгдэл, эвдрэл үүсэх, хөрсний үржил шим алдагдах, хөрсний бохирдол үүсэх, агаар бохирдох, агаарын чанар өөрчлөгдөх, ан амьтдын байршил, тархалт, нүүдэл, шилжилтийн орон зай өөрчлөгдөх, дуу чимээ, шуугианы бохирдол бий болох, байгалийн нөөцийн ашиглалтаас үүдэн ашигт малтмалын нөөцийн болон түүний дагалт баялаг, эрдэс, түүхий эдийн нөөцийн, усны нөөц, ойн нөөцийн хомсдол бий болох эсэх талаар дүгнэлт, тооцооллыг гаргана.

Үүнээс гадна тухайн нутагт оршин суугчдын хүн амын эрүүл мэнд, нийгмийн эрүүл ахуй, халдварт өвчин тархах, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийн эрсдэл бий болох эсэх, хүнс тэжээлийн хомсдол бий болох, орон нутгийн болон хүн амын орлого, ажлын байр нэмэгдэх, ядуурлыг бууруулах, хүн амын тоо өөрчлөгдөх, ажиллах хүчний эх үүсвэр, тоо, ажиллагсдын хөдөлмөр хамгаалал, нийгмийн асуудал, хүн амын шилжилт хөдөлгөөн үүсэх г.м асуудлууд, эрчим хүчний хангамж, ус хангамж, зам тээвэр, шуудан, харилцаа холбоо, үйлдвэрлэлийн барилга байгууламж, ажиллагсдын байр, үйлчилгээний хэсэг /хоолны газар, халуун ус, угаалгын газар бий болох, түүх соёлын дурсгалт зүйл устах, үрэгдэх, археологи, палентологийн олдворт нөлөөлөх, устах, үрэгдэх эсэх асуудлыг тодруулан үр дүнг тусгана.

3.3.4 Төслийн сөрөг нөлөөлөл багатай хувилбарыг тодорхойлох

Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн төслийг боловсруулах явцдаа ихэвчлэн хэд хэдэн хувилбарыг авч үзсэн байдаг. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд тэдгээр хувилбаруудын байгаль орчин, нийгэм, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллөөр нь харьцуулан шинжилж, байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэй хувилбарыг тодорхойлох нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, тэдгээр хувилбаруудын гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, болзошгүй эрсдэлүүд, түүний үр дагавар зэрэгт анализ хийж харьцангуй хамгийн бага сөрөг нөлөөлөл бүхий хувилбарыг тодорхойлно. Төслийн хамгийн бага сөрөг нөлөөлөл бүхий хувилбарыг дараах алхмуудаар тодорхойлно.

Үүнд:

- Тухайн төслийн батлагдсан хувилбараас гадна төслийг боловсруулах явцад хамгийн боломжтойд тооцогдсон өөр нэг болон хэд хэдэн хувилбарыг (ижил төстэй нөхцөлд хэрэгжиж байгаа өөр төсөл байж болно) сонгон авч холбогдох мэдээлэл, технологийн шийдлийг тодруулах;
- Сонгосон хувилбаруудыг байршил, гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн цар хүрээ, техник, технологийн шийдэл, болзошгүй эрсдэлийн үр дагавар зэргээр харьцуулсан шинжилгээ хийх;
- Байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл хамгийн бага хувилбарыг тодорхойлох түүнийг хэрэгжүүлэхээр сонгосон хувилбартай харьцуулах зэрэг орно.

Ингэж төслийн сөрөг нөлөөлөл хамгийн бага хувилбарыг тодорхойлсоноор төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчинд халгүй, нийгмийн сөрөг нөлөө багатай дэвшилтэт технологиор явуулах зөвлөмжийг бодитой тогтоох, төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжүүлэгч цаашдын үйл ажиллагаандаа оновчтой сонголт хийх боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

3.3.5 Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, үр дагаврыг арилгах арга хэмжээг тодорхойлох

Тухайн төслөөс байгаль орчин, нийгэм, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлж үнэлсэн, төслийн оновчтой хувилбарыг тодорхойлсны дараа тэдгээр нөлөөллийн цар хүрээ, эрчим, үргэлжлэл давтагдал, шинж чанарын онцлогт тулгуурлан бууруулах, үр дагаврыг арилгах, нөхөн сэргээх арга хэмжээний зөвлөмж боловсруулах нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын гол үр дүн, чухал хэсэг юм. Тухайн төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, үр дагаврыг арилгах арга хэмжээг дараах алхмуудаар тодорхойлно.

Үүнд:

- Өмнөх шатанд авч үзсэн төслийн хамгийн бага сөрөг нөлөөлөл бүхий хувилбараас төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн хэрэгжүүлж болохуйц хувилбар, сонголтуудыг тогтоох;

- Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл бүрийг авч үзэж, түүний цар хүрээ, эрчим, түүнд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгийн шинж чанарт нь тохирсон бууруулах, болзошгүй сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээг тодорхойлох;
- Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, болзошгүй сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээнүүдэд анализ хийж, эрэмбэлэн хамгийн чухал, зайлшгүй, эхний ээлжид хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг тодорхойлж, тэдгээрийн тодорхойлолтыг боловсруулах зэрэг орно.

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, болзошгүй сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээг тодорхойлохдоо байгаль орчинд халгүй үйл ажиллагаа эрхлэх, дэвшилтэт техник технологийг ашиглах бүх сонголтуудыг харгалзан үзэхээс гадна бүхий л үйл ажиллагаа нь хууль, тогтоомж, стандарт, норм нормативаар тогтоосон хэм хэмжээнээс хэтрэхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх, ажиллагсдын болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндэд эрсдэл учруулахгүй байх, байгалийн нөөцийг зүй зохистой, ариг гамтай ашиглах, хэрэгжих боломжтой байх зэрэг шалгуурыг хангасан байвал зохино.

Үүнээс гадна төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд бохирдол үүсгэж болзошгүй бүх төрлийн хатуу, шингэн, хийн хог хаягдал, ялгарлыг бууруулахад ашиглах байгаль орчинд ээлтэй, боломжит арга технологийн зөвлөмжийг боловсруулах шаардлага энд тавигдана.

Уул уурхай, дэд бүтэц, хөдөө аж ахуй, үйлдвэр үйлчилгээ, аялал жуулчлалын төслүүдийг хэрэгжүүлэх болон химийн хорт бодис, цацраг идэвхт бодисыг ашиглах, хадгалах, тээвэрлэх, зайлуулах, устгах, тэрчилэн хатуу, шингэн хаягдлыг хуримтлуулах, хадгалах, цэвэрлэх, зайлуулах явцад байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг тодорхойлох, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ нь тухайн төслийн онцлог, хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн нөхцөлөөс шалтгаалсан өвөрмөц онцлогуудыг тусгах шаардлагатай.

3.3.6 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тогтоох

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцөлөөс илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн зорилго болно.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нь дараах хэсгээс бүрдэнэ.

Үүнд:

- Биологийн олон янз байдлыг сайжруулах зорилтуу

- Биологийн олон янз байдлын менежментийн арга хэмжээг тодорхойлох;
- Хэрэгжилтийн мониторинг хийх;
- Үйл ажиллагааны төсөв, санхүүжилтийн төлөвлөгөө гаргах зэрэг орно.

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ нь дараах төрлийн байна.

Үүнд:

- Шууд хамгааллын арга хэмжээ;
- Нөхөн сэргээх, сайжруулах;
- Аюул заналыг бууруулах;
- Холбогдох байдлыг сайжруулах гэх мэт.

Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг тодорхойлохдоо биологийн олон янз байдлын суурь нөхцөл байдлыг үнэлсний дараагаар дүйцүүлэн хамгаалах экосистемийн төрөл, амьтан, ургамлын зүйл тус бүрээр тодорхойлно. Эдгээр зорилтуудыг тогтоохдоо биологийн олон янз байдлын амьдрах чадварын үнэлгээг үндэс болгох ба дүйцүүлэн хамгаалж буй биологийн олон янз тус бүрээр амьдрах чадварыг сайжруулахад чиглэсэн зорилтуудыг тодорхойлсон байх ёстой.

Дүйцүүлэн хамгаалах газрыг тогтоохдоо нөлөөлөлд өртсөн газартай ойр байх, экологийн хувьд дүйцэхүйц байх, дүйцүүлэн хамгаалах хугацааг нөлөөлөл үргэлжлэх хугацаатай харьцуулж тогтоох, урт хугацааны хамгааллыг хангах, нэмэлт байх (дүйцүүлэн хамгаалал хийсний улмаас шинээр буй болсон нэмэлт хамгааллын үр дүнгүүдийг нэмэлт байх зарчим гэнэ) зарчмуудыг баримтлах шаардлагатай. Үүнээс гадна дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ нь шинээр хамгаалалт бий болгосон, эсвэл биологийн олон янз байдлын хэвийн нөхцөлд илүү эерэг нөлөөлөл үзүүлсэн байх шалгуур тавигдана. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг тодорхойлохдоо дараах алхам аргачлалыг мөрдлөг болгоно.

Үүнд:

1. Төслийн нөлөөлөлд өртөх газрын хэмжээг тогтоох: Төслийн нөлөөлөлд өртөх газрын хэмжээний талаарх суурь мэдээллийг БОННУ-ний тайлангаас үзэж болно. Хэрэв БОННУ-ний тайланд биологийн олон янз байдалд үзүүлэх орон зайн нөлөөллийн талаар хангалттай мэдээлэл байхгүй бол нэмэлт судалгаа хийх шаардлагатай.

Биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг харьцангуй бодитойгоор тогтоох нь ямар хэмжээний газарт, ямар төрлийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг, ямар хугацаанд хэрэгжүүлэх гэх мэт чухал асуудлуудыг тодорхойлох үндэс болно. Нөлөөлөлд өртөж болзошгүй амьтан, ургамлын зүйл тус бүрт ямар нөлөөлөл үзүүлэх, нөлөөлөлд ямар хариу үйлдэл үзүүлэх зэргийг тэр бүр нарийвчлан тогтоох боломжгүй тохиолдолд нөлөөллийн индексийг ашиглан амьдрах орчинд үзүүлэх нөлөөллийн хэмжээг тогтоож болно.

Тухайлбал, амьдрах орчинд үзүүлэх төслийн нөлөөллийн индексийг тооцоолох ГЗМС дээр тулгуурласан “Нөлөөлөл орон зайд буурах функц”-ийг ашиглан нөлөөлөлд өртөх газрын хэмжээг тогтоож болно. Энэ арга нь шууд ба шууд бус нөлөөллийг орон зайн хувьд хэмжиж болох хялбар арга юм. Энэ нь ялангуяа дүйцүүлэн хамгаалах газар нутгийн хэмжээг нөлөөлөлд өртсөн амьдрах орчинтой харьцангуйгаар тодорхойлоход чухал юм.

Нөлөөлөл буурах функц (*Function*) нь:

$$Function = (1 / (1 + Exp(((Distance / 100) - a) * b))) * Weight$$

Үүнд:

Distance - Нөлөөлөл буурах зай,

Weight - Нөлөөллийн эрчим

a, b - Налуугийн хүчин зүйлс

Нөлөөлөл буурах зай болон нөлөөллийн эрчим зэрэг нь нөлөөллийн төрөл, газар орны нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байх тул дараах хүснэгтэнд үзүүлсэн байдлаар нөлөөлөл буурах зэрэгтэй уялдуулан налуугийн хүчин зүйлсийг сонгож нөлөөлөл буурах функцийг тогтооно (Хүснэгт 3.2, Зураг 3.1).

Хүснэгт 3.2: Нөлөөлөл буурах зэрэгтэй уялдуулсан нөлөөлөл буурах функц


Нөлөөлөл буурах зэрэг	Нөлөөлөл буурах функц
Огцом	$(1 / (1 + Exp(((Distance / 100) - 1) * 5))) * Weight$
Дунд-огцом	$(1 / (1 + Exp(((Distance / 100) - 2.5) * 2))) * Weight$
Дунд	$(1 / (1 + Exp((Distance / 100) - 5))) * Weight$
Алгуур	$(1 / (1 + Exp(((Distance / 100) - 10) * 0.5))) * Weight$

Нөлөөлөл буурах функцийг ашиглахад нөлөөлөл буурах зай, нөлөөлөл буурах зэрэг, нөлөөллийн эрчмийг Монгол орны байгалийн бүс бүслүүрээр ялгаатай тооцох утгуудыг Хавсралт 1-ээс үзнэ үү¹.

Нөлөөлөл буурах функцийг ашиглан газарзүйн мэдээллийн систем (ГЗМС) дээр нөлөөлөлд өртөх газрын хэмжээг (га-гаар) тогтоох ба нөлөөллийн эрчмийг нөлөөлөл их, дунд, бага гэсэн 3 ангид хуваана (Зураг 3.1-г харна уу).

¹Эдгээр утгуудыг Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн судалгаагаар тогтоосон утгуудыг тохируулан хэрэглэв.

Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай амьдрах орчны хэмжээг энэхүү нөлөөллийн эрчмийн ангилал дээр тулгуурлан тогтооно. Нөлөөллийн эрчмийн ангиллыг дүйцүүлэн хамгааллын тооцоололд ялгавартай тусгахын тулд дараах нөлөөллийн итгэлцүүрийг ашиглана (Хүснэгт 3.3).



Зураг 3.1. Нөлөөлөл буурах функцийг ашиглан нөлөөллийн итгэлцүүрийг (их, дунд, бага) тогтооно.

Хүснэгт 3.3. Нөлөөллийн эрчим болон нөлөөллийн итгэлцүүр

Нөлөөллийн эрчим	Нөлөөллийн итгэлцүүр	Тайлбар
Нөлөөлөл их (га)–I1	1.00	Биологийн олон янз байдал үзүүлэх нөлөөлөл их байх тул бүх талбайг тооцоололд 1:1 гэж тооцох ба итгэлцүүр нь 1 байна.
Нөлөөлөл дунд (га)–I2	0.66	Нөлөөлөл дунд бол $1/3 * 2 = 0.66$
Нөлөөлөл бага (га)–I3	0.33	Нөлөөлөл бага бол $1/3 * 1 = 0.33$

Нөлөөлөл буурах функц, тохируулах итгэлцүүрийг ашиглан төслийн нөлөөлөлд өртөх газрын хэмжээг дараах байдлаар тооцоолно.

$$S_i = I_1 + I_2 * 0.66 + I_3 * 0.33$$

Үүнд:

S_i - Нөлөөлөлд өртөх газрын хэмжээ (га),

I1- Нөлөөлөл их,

I2- Нөлөөлөл дунд,

I3 – Нөлөөлөл бага.

2. Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтоох:

Төслийн нөлөөлөлд өртөх газрын хэмжээг тогтоосны дараагаар төслийн нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтооно. Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтооход дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзнэ.

Үүнд:

- Амьдрах орчны төрөл
- Экосистемийн ховор байдал
- Экологийн эрүүл байдал
- Ландшафтын байршил
- Нөлөөллийн хугацаа

Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтоохдоо эдгээр хүчин зүйл тус бүрээр дараах хүснэгтэд харуулсан дүйцүүлэн хамгааллын итгэлцүүрийг ашиглана.

Хүснэгт 3.4 Дүйцүүлэн хамгааллын итгэлцүүр

Ангилал	Тодорхойлолт	Дүйцүүлэн хамгааллын итгэлцүүр
Амьдрах орчны ангилал²		
Чухал	Экологийн бүс нутгийн үнэлгээгээр экологийн хувьд чухал гэж тогтоогдсон газрууд. Марксан програм дээр тогтоогдсон анхны хувилбар болон давхцал үүссэний улмаас дахин боловсруулсан хувилбар орно	3
Хэвийн	Чухал болон өөрчлөгдсөн гэж тогтоогдсон газруудаас бусад.	1.5
Өөрчлөгдсөн	ГЗМС дээр тогтоосон хүний үйл ажиллагааны нөлөөллийн индексийн утга 95% < бүхий газрууд.	0.20
Экосистемийн ховор байдал³		
Маш ховор	Эх газрын экосистемийн ангиллаар тухайн экологийн бүс нутаг ба био-газарзүйн мужлалын хэмжээнд < 5% тархацтай,	3

²Амьдрах орчны байдлын орон зайн мэдээллийг Экологийн бүс нутгийн үнэлгээгээр авч болно.

³Экосистемийн ховор байдлын ангиллыг Экологийн бүс нутгийн үнэлгэ.

Ховор	Эх газрын экосистемийн ангиллаар тухайн экологийн бүс нутаг ба био-газарзүйн мужлалын хэмжээнд 5%<-<10% тархацтай,	1.5
Хэвийн	Эх газрын экосистемийн ангилалаар тухайн экологийн бүс нутаг ба био-газарзүйн мужлалын хэмжээнд 10%<тархацтай,	0.20
Экологийн эрүүл байдал⁴		
Сайн	ГЗМС дээр тогтоосон хүний үйл ажиллагааны нөлөөллийн индексийн утга бага байх 0%-50% бүхий газрууд	3
Дунд	ГЗМС дээр тогтоосон хүний үйл ажиллагааны нөлөөллийн индексийн утга 51%-94 % бүхий газрууд	1.5
Муу	ГЗМС дээр тогтоосон хүний үйл ажиллагааны нөлөөллийн индексийн утга их байх 95% <бүхий газрууд.	0.20
Ландшафтын байршил⁵		
Чухал	- Экологийн хувьд чухал ач холбогдолтой газруудын хилээс 20 км-ээс бага зайтай бол, - Нүүдлийн амьтдын шилжилт хөдөлгөөнд ноцтой саад учруулах,	3
Дунд	- Экологийн хувьд чухал ач холбогдолтой газруудын хилээс 20 км-50 км зайтай бол, - Нүүдлийн амьтдын шилжилт хөдөлгөөнд зарим талаар саад учруулах,	1.5
Чухал бус	- Экологийн хувьд чухал ач холбогдолтой газруудын хилээс 50 км-ээс хол зайтай бол, - Нүүдлийн амьтдын шилжилт хөдөлгөөнд саад учруулахгүй,	0.20
Нөлөөлөл үргэлжлэх хугацаа		
>20 жил	Нөхөн сэргээлт бүрэн хийж дуусах хүртэл хугацааг оруулан тооцоно.	3
5-20 жил		1.5
<5 жил		0.20

⁴Экологийн эрүүл байдлын мэдээллийг Экологийн бүс нутгийн үнэлгээнээс авч болно.

⁵Чухал амьдрах орчноос хамаарах зай, хэмжээ, холбогдох байдлыг зэрэг үзлийг харгалзан үзнэ.

Дээрх итгэлцүүрийг харгалзан дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газар нутгийн хэмжээг дараах томъёогоор тооцоолно.

$$S_o = S_l * f_n$$

$$S_o = (I_1 * f_n) + (0.66 * I_2 * f_n) + (0.33 * I_3 * f_n) = \> \{f_n(I_1 + 0.66 * I_2 + 0.33 * I_3)\}$$

Үүнд:

S_o -Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай талбайн хэмжээ (га),

f_n -Дүйцүүлэн хамгааллын итгэлцүүрийн аль нэг тохирох утга.

3. Дүйцүүлэн хамгааллын зардлыг тодорхойлох

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний санхүүжилтийн төлөвлөгөөг гаргасан байна. Дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэгч талууд дүйцүүлэн хамгааллын жилийн төсвийг тооцоолох, санхүүжилт хийхэд энэхүү 5 жилийн санхүүгийн төлөвлөлтийг үндэслэнэ. Биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээний төсөвт дараах зардлууд орно.

Үүнд:

1. Дүйцүүлэн хамгааллын нэмэлт судалгааны зардал (E_r) нь тухайн төслийн нөлөөллийн эрчим, түүний хэмжээг тогтоох, дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газар, түүний хэмжээг тогтоох зөвлөх үйлчилгээний зардлаас бүрдэнэ. Зөвлөх үйлчилгээний зардлын хэмжээг захиалагч ба гүйцэтгэгч нар харилцан тохирох зарчмаар тогтооно.
2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх зардал (E_p) нь биологийн олон янз байдлын суурь судалгааны зардал ба дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг талуудын оролцоотойгоор төлөвлөх, төлөвлөгөөг холбогдох байгууллагаар батлуулах арга хэмжээний зардлууд орно. Зардлын хэмжээг захиалагч ба гүйцэтгэгч нар харилцан тохирно.
3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зардал (E_o) нь тухайн газар нутагт хэрэгжүүлэх биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан, хэрэгжүүлэх шаардлагатай менежментийн арга хэмжээг санхүүжүүлэх зардлаас бүрдэнэ.

$$E_o = S_o * \{(C * R) * (1 + r)^t\}$$

Үүнд:

E_o —Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний нэг жилийн зардал

S_o -Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай, шууд болон шууд бус нөлөөлөлд өртсөн талбайн хэмжээ (га)

C–Дүйцүүлэн хамгаалах нэг га-д ногдох зардал, $C=(2m.n)6$,

R–Дүйцүүлэн хамгааллын харьцааны итгэлцүүрийн утга. $R=107$,

$(1 + r)^t$ –инфляц.

4. Гүйцэтгэгч байгууллагын менежментийн зардал (E_m) нь дүйцүүлэн хамгааллын нэмэлт судалгаа, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх мэргэжлийн зөвлөх үйлчилгээний зардлаас бүрдэнэ. Энэ нь дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зардлын 20%-аас хэтрэхгүй байна.

Иймд дүйцүүлэн хамгаалах зардлын нийт хэмжээг дараах байдлаар тооцно.

$$E_{total} = E_r + E_b + E_o + E_m$$

Үүнд:

E_{total} –дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний жилийн нийт зардал

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, түүнд шаардагдах зардлын энэ тооцоог үндэслэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд энэ чиглэлийн арга хэмжээг мониторингийн шалгуур үзүүлэлтүүдийн хамт тодорхойлж, нарийвчилсан үнэлгээний тайланд тусгана.

3.3.7 Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нутгийн оршин суугчдад учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээг хийх

Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад байгалийн аюултай үзэгдэл, нөхцөл байдал үүсэх, үйлдвэрлэлийн томоохон осол гарч түүнээс химийн хорт болон цацраг идэвхт бодис алдагдах, аюултай хог хаягдлаас үүдэн гарч болзошгүй эрсдэлийг үнэлэх нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хүрээнд хийгдэх ажлын нэг чухал хэсэг юм.

Эрсдэлийн үнэлгээнд химийн хорт болон аюултай бодисын хор, аюулын шинж чанар, болзошгүй эрсдэлийг судлан тодорхойлох, түүнээс сэргийлэх арга хэмжээ болон хаягдлыг хоргүйжүүлэх, устгах асуудлыг хамруулан хийхээр дээрх хуульд заасан. Эрсдэлийн үнэлгээ нь химийн хорт болон аюултай бодисын менежментийн уян хатан арга хэлбэр бөгөөд эрсдэл үүсгэж болзошгүй бодисуудын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй мэдээлэлд үндэслэн системчилсэн хандлагаар дүн шинжилгээ үйл явц хийх юм.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын хүрээнд байгалийн аюул, осол тохиолдож болзошгүй нутаг дэвсгэрт, тухайлбал, газар

⁶Биологийн олон янз байдлын зохистой менежмент хийхэд нэг га-д шаардагдах зардал.

⁷Нөлөөлөлд өртсөн биологийн олон янз байдлын хувьд дүйцүүлэн хамгаалах замаар нэмэлт эерэг өөрчлөлт бий болгоход хэрэглэх итгэлцүүр. Биологийн олон янз байдалд үзүүлсэн нөлөөллийг хамгааллын зарчмаар дүйцүүлэн хамгаалах бол 1:10 харьцаагаар дүйцүүлэн хамгаалдаг олон улсын туршлага байдаг.

хөдлөлийн эрчим өндөртэй бүс нутаг, байгалийн бусад гамшигт өртөж болзошгүй газарт химийн хорт болон аюултай бодис материал, аюултай хог хаягдалтай харьцаж ажиллах, тэдгээрийг хадгалах, хуримтлуулах, зайлуулах, устгах, мөн томоохон барилга байгууламжийг барьж байгуулах төслүүдэд эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагатай.

Эрсдэлийн үнэлгээг батлагдсан (БОНХ-ийн Сайд, Эрүүл мэндийн Сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын хамтарсан тушаал, 2012 оны 12 сарын 25 өдрийн А\50\378\565 тоот тушаалаар батлагдсан) журам, аргачлалын дагуу хийж, дүнг тусгай хэсэг болгон энд тусгана.

Үүнээс гадна энэ хэсэгт байгалийн аюул, гамшиг түүний тохиолдох магадлал, гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлж тусгана. Гамшгийн эрсдэлийг эрх бүхий байгууллагаас батлан мөрдүүлж байгаа (Засгийн Газрын 2006 оны 178-р тогтоолоор батлагдсан) журам, аргачлалын дагуу хийж, дүнг тайланд тусгана.

3.3.8 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлох

Өмнөх үе шатанд тодорхойлогдсон байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл, эрсдэлүүдийг үнэлж, хамгийн бага сөрөг нөлөөлөл бүхий сонгогдсон хувилбар, түүнийг хэрэгжүүлэх явцад үүсч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, багасгах арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангах нөхцөлийг тодорхойлох, дээрх арга хэмжээний дэс дараалал, уялдаа холбоог хангаж хамгийн үр дүнтэй хэрэгжүүлэх зорилтыг тодорхойлох нь энэ шатны гол зорилт болно.

Энэ үе шатанд тухайн төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг дараах байдлаар ангилж тодруулна.

Үүнд:

1. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ (энд болзошгүй сөрөг нөлөөллийг учрахаас нь өмнө таслан зогсоох, үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн оршин суугчид, олон нийтэд сурталчлах ажлыг өргөнөөр зохион байгуулах, байгаль орчинд халгүй бусад хувилбаруудтай харьцуулалт хийх гэх мэт арга хэмжээг оруулна);
2. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ (байгаль орчны бохирдлыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, бохирдлыг хянах төхөөрөмж багаж хэрэгсэл суурилуулах, хэмжих хэрэгслээр хангах, барилга байгууламжийг батлагдсан зураг төслийн дагуу чанар сайтай барьж байгуулах, бохирдлыг бууруулах техник, технологи, зохион байгуулалтын арга хэмжээ авах, хяналт-шинжилгээг тогтмол хийлгэж, үр дүнг холбогдох байгууллагуудад мэдээлж байх гэх мэт арга хэмжээг оруулах);
3. Нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ (энд үйл ажиллагааны явцад өртөж эвдэрсэн газрыг...

тохижуулах, зайлшгүй үлдэх өөрчлөлт, үр дагаврыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний талаар оруулах);

4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ (энд шууд учирсан хохирлыг барагдуулах, хохиролд өртсөн байгалийг нөхөн сэргээх, хохиролд өртөгсдөд нөхөн олговор олгох, мөнгөн бус хэлбэрээр алдагдал хохирлыг барагдуулах, шинээр газар олгох, санхүүгийн тусламж үзүүлэх зэргээр учирсан хохирлыг барагдуулах гэх мэт арга хэмжээг оруулах) зэрэг орно.

Эдгээр арга хэмжээг ангилж, хоорондын уялдаа холбоо, үр дүнг дээшлүүлэх зорилтот анализийг хийж, тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтууд, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүдийг дээрх ангиллын дагуу тодорхойлно. Энэ нь байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах үндэслэл болно. Энэ хэсэгт шаардлагатай бол арга хэмжээний гол үндэслэл, товч тодорхойлолт, үндсэн шаардлага, хэрэгжүүлэх явцад анхаарах зөвлөмж зэргийг тусгана.

3.4 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нийгмийн нөлөөллийн асуудлыг авч үзэх нь

3.4.1 Нийгмийн нөлөөллийн үнэлгээний ажлын удирдамж

Тухайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хүрээнд нийгмийн нөлөөллийн асуудлыг зайлшгүй авч үзэн ажлын удирдамжид тусгах бөгөөд нийгмийн нөлөөллийг тодорхойлоход олон улсад мөрддөг нийтлэг шаардлага, банк, санхүүгийн байгууллагаас тавьдаг шалгууруудыг хангах зарчмыг баримтлана.

3.4.2 Төслөөс нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлох

БОННУ-ний хүрээнд төслөөс нийгэм-эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тодорхойлоход дараах асуудлуудыг анхааран үзэх шаардлагатай.

Үүнд:

- Тухайн төслийг хэрэгжүүлснээр бүс нутгийн зам тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч болон ус хангамж зэрэг дэд бүтцийн салбарт гарч буй өөрчлөлтүүд, тэдгээрээс үүдэлтэй нөлөөллийг тодорхойлох;
- Тухайн төслийг хэрэгжүүлснээр бүс нутагт нэмэгдэх ажлын байр, хүн ам зүйн бүтэц, соёл, боловсролын түвшинд орж болох өөрчлөлт, орон нутгийн оршин суугчдын төслөөс хүлээх ашиг, сонирхлийг илрүүлэн тодорхойлох;
- Тухайн төслийг хэрэгжүүлснээр газрыг эдийн засгийн эргэлтээр ашиглаж ирсэн нөхцөл байдалд ямар өөрчлөлт орж, улмаар тэр нь нутгийн оршин суугчдын ахуй амьжиргаанд хэрхэн нөлөөлөхийг тогтоох зэрэг орно.

Төслийн гол зорилго, техник, технологи, эдийн засгийн хүчин чадал, үндсэн болон туслах үйл ажиллагааны хүрээнд нийгм

үзэхдээ төслийг хэрэгжүүлэх үүднээс газар талбайг чөлөөлөх шаардлагатай, эсэх, төслийн барилга байгууламжийг хожим иргэний зорилгоор ашиглах боломжтой, эсэх, төслийн хэрэгжилт нь төвлөрөл суурьшлыг үүсгэх, эсэх, түүнийг даган бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг анхааран үзэх шаардлагатай.

3.4.3 Төслийн үр дүнд үүсэх нийгмийн сөрөг нөлөөллийг үнэлэх

Төслийн нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийхэд олон нийтийн оролцоог ханган, оролцогч талуудын зөвлөлдөх уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар орон нутгийн санал хүсэлтэд үндэслэсэн судалгааны өгөгдлийг боловсруулж, матрицын, магадлан жагсаах, дүн шинжилгээ хийх аргууд, Монгол улсын хууль тогтоомжид заасан болон олон улсын нийтлэг аргуудыг ашиглан үнэлнэ. Энэ үнэлгээг доорх алхмуудаар гүйцэтгэнэ.

Үүнд:

- Өмнөх шатанд тодорхойлсон нийгэм, эдийн засгийн төлөв байдалд тоон ба чанарын шинжилгээ, иргэд олон нийт, орон нутгийн удирдлагын саналд дүн шинжилгээ хийх;
- Төслийн хэрэгжилтийн үр дүнд бий болох эдийн засаг, нийгмийн өөрчлөлтүүдийг судалж, сөрөг нөлөөллийн шалтгаан, үр дагаврыг үнэлэх;
- Нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах, төсөл хэрэгжсэн шинэ орчин нөхцөлд дасан зохицох хөтөлбөрийн шаардлагыг тодорхойлж, боломжит хувилбаруудыг дэвшүүлэн үнэлэх зэрэг орно.

Нийгмийн нөлөөллийн үнэлгээнд байгаль орчны нарийвчилсан үнэлгээнд хэрэглэх үнэлгээний бусад олон аргуудыг ашиглаж болох бөгөөд тэдгээр нь хэрэглээний зарчмын хувьд өмнө өгүүлсэнтэй ижил төстэй шаардлагатай байна.

3.4.4 Нийгмийн сөрөг нөлөөлөл багатай хувилбарыг тодорхойлох

Нийгмийн нөлөөллийн үнэлгээний хүрээнд нийгэм, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллөөр нь харьцуулан шинжилж оршин суугчдын ахуй амьжиргааны тухайн үеийн нөхцөл байдал нь дордохгүй байх хувилбарыг тодорхойлох шаардлагатай. Нийгмийн сөрөг нөлөөлөл хамгийн бага байх хувилбарыг дараах алхмуудаар тодорхойлно.

Үүнд:

- Тухайн төслийг боловсруулах явцад төсөл хэрэгжүүлж эхлэхтэй зэрэгцэн үүсэх нийгмийн сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг урьдчилан төлөвлөж хэрэгжүүлэх хэд хэдэн хувилбар (ижил төстэй нөхцөлд хэрэгжиж байгаа өөр төсөл байж болно)-ыг зөвлөх;
- Сонгосон хувилбаруудыг хэрэгжүүлэхэд хамрагдах нийгмийн бүлгүүдийг тодорхойлж, сөрөг нөлөөлөлд өртөж байгаа шалтгаан, үндэслэлийг тайлбарлах;

- Тухайн төслийг хэрэгжүүлэхэд газар чөлөөлөх шаардлага байгаа эсэхийг тодорхойлох, байгаа бол нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын төлөвлөгөө, дасан зохицох хөтөлбөрийг боловсруулах.

Ингэж төслөөс нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бодитой тогтоох, төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжүүлэгч цаашдын үйл ажиллагаандаа оновчтой сонголт хийх боломжийг бүрдүүлнэ.

3.5 Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнг орон нутагт хэлэлцүүлэх

Тухайн төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа аж ахуй нэгж үнэлгээний гол үр дүн, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг тодорхойлж, үнэлгээний тайланг боловсруулсны дараа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна.

Хэлэлцүүлгийг тухайн төслийн онцлог байдалтай уялдуулан холбогдох журмын дагуу олон нийтийн оролцоог хангаж, мэдээлэл түгээх, цуглуулах боломжит арга хэлбэрүүдээс тохиромжтойг нь сонгож, ашиглана.

Ингэхдээ нөлөөлөлд өртөгсөд, нутгийн иргэдээс түүвэр судалгаа, санал асуулгын хуудас, ярилцлага, нөөцийн зураглал, эрэмбэлэх, зэрэглэх, Н-форум, графикаар илэрхийлэх, дүрд тоглох зэрэг аргуудыг ашиглан саналыг нь авах, эсвэл нээлттэй хэлэлцүүлэг, зорилтот бүлгийн ярилцлагыг зохион байгуулж санал хураах зэрэг аргуудыг ашиглан тэдний саналыг тодруулан тайланд тусгана.

Хэлэлцүүлгийг зохион байгуулж, санал асуулга явуулахдаа дараах асуудлуудын талаар тайланд тодорхой тусгана

Үүнд:

- Төслийн нөлөөлөлд өртөгчид, оролцогч талуудтай хийсэн уулзалт ярилцлага, зөвлөлгөөн, авсан санал асуулга, мэдээлэл тараах ажлыг хэзээ, хэрхэн, хаана хийсэн тухай мэдээлэл, түүнд оролцогч талуудын ирцийн мэдээ;
- Хэлэлцүүлгийн гол сэдэв, хэлэлцүүлгийн явцад гол анхаарал хандуулсан асуудлуудын талаарх мэдээлэл;
- Төслийн төлөвлөлт, хэрэгжилт, үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах зохих үндэслэл бүхий саналууд зэрэг байна.

Төсөл нь хэд хэдэн баг, сумын нутаг дэвсгэрийг хамарч хэрэгжих бол эрх бүхий аж ахуйн нэгж нь тухайн сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, багийн иргэдийн нийтийн хуралд тус тусад нь танилцуулж санал авна.

3.6 Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүний техникийн бус хураангуйг боловсруулах

Төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүнд тодорхойлогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчин, оршин суугчдад учирч болзошгүй эрсдэлийн үнэлгээний дүн, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүдийг эмхэтгэн тайлагнах нь энэ үе шатны гол ажил бөгөөд төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан гол үр дүн болно.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан нь төслийн цар хүрээ, үнэлгээний судалгаа болон нарийвчилсан үнэлгээний ажлын хэмжээ, нарийвчлалаас шалтгаалж ихэвчлэн олон хуудас бүхий мэргэжлийн болон техникийн үг хэллэгтэй боловсруулагддаг.

Иймээс нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын гол үр дүн, сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг оруулсан техникийн бус хураангуйг олон нийт, оролцогч талуудад ойлгомжтой байх энгийн үг хэллэгээр тусгайлан боловсруулж тайланд хавсаргана.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн бүтэц, агуулга нь доорх хэлбэртэй байх бөгөөд, түүнд зайлшгүй шаардлагатай мэдээллийн ерөнхий шаардлагуудыг тусгав.

3.7 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн агуулга, хэлбэр

1. Тайлангийн техникийн бус хураангуй: Энэ хэсэгт төсөл хэрэгжих нутгийн байгаль орчны өнөөгийн төлөв байдлын товч мэдээллийг оруулах ба хураангуй нь төсөл, түүний хэрэгжих газрын байгаль орчин, төслийн нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээний талаар бүрэн гүйцэд ойлголт өгч чадахуйц хэмжээнд боловсруулагдана. Хураангуйд төслийн тодорхой бус асуудлууд, тэдгээрийн байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг онцлон тусгана. Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах зохих зөвшөөрлийн талаар зайлшгүй дурдах ба нийтэд ойлгомжтой хэлбэрээр бичигдсэн байна.

Техникийн бус хураангуйг бичихдээ товч тодорхой байх, мэргэжлийн болон техникийн үг хэллэг, нэр томъёоноос аль болох зайлсхийж, энгийн ойлгомжтой байдлаар найруулсан байх шаардлагатай.

2. Оршил: Тухайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гол зорилго, нарийвчилсан үнэлгээний хүрээнд хийсэн ажлууд, үнэлгээний судалгааны ажлуудын гол үр дүн, цаашид төсөл хэрэгжүүлэгч, орон нутаг болон шийдвэр гаргах түвшинд анхаарах асуудлуудыг товч тодорхой тусгасан байна.

3. Үйл ажиллагааны хүрээ: Өнөөгийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төслийн үйл ажиллагаатай холбогдох байгаль орчныг хамгаалах хууль, эрх зүйн орчин, төслийг хэрэгжүүлэх явцад зайлшгүй мөрдөж ажиллах хуулийн хориглосон, хязгаарласан зүйл, заалтууд, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дүрэм, журам, стандарт, Монгол Улсын нэгдэн орсон конвенциудын холбогдох шаардлагуудыг тодорхой тусгана.

4. Төслийн тодорхойлолт: Төслийн техник, эдийн засгийн үндэслэл (Feasibility Study Report), зураг төсөл (Design parameters and Layouts), бусад холбогдох баримт бичгүүдээс тухайн төслийн гол зорилт, цар хүрээ, хэмжээ, төсөл хэрэгжих үе шат, түүхий эд, байгалийн баялгийн ашиглалт, эрчим хүч, ус, дулааны хэрэгцээ, техник, технологийн сонголт, үйлдвэрлэлийн хүчин чадал, үйлдвэрлэлийн эцсийн болон завсрын бүтээгдэхүүн, гарах хаягдал, ялгарал, түүнийг эргүүлэн ашиглах, зайлуулах арга зам зэргийг тодруулна.

Энэ хэсэгт төслийн баримт бичигт хийсэн байгаль орчин, тогтвортой байдлын болон ногоон хөгжлийн анализийн дүнг оруулж болно.

5. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл, үнэлгээ: Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнд өртөх байгаль орчин, тухайлбал, газрын гадарга хэвлий, агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг чиглэл бүрээр гаргаж тусгана. Мөн тэдгээр гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн эрчим, тархалт, хэмжээг тодорхойлж, тоон ба чанарын үнэлгээ өгсөн дүнгүүдийг тусгана. Үнэлгээний судалгаа, гол болон болзошгүй нөлөөллийг тогтоох, түүнд үнэлгээ өгөхөд ашигласан арга, загварчлал, тооцооллын дүнг түүнийг сонгосон үндэслэлийн талаар дэлгэрэнгүй тайлбарлаж тусгасан байна. Үнэлгээний судалгааны явцад цуглуулсан мэдээ, мэдээлэл, хээрийн судалгааны явцад хийсэн хэмжилтийн эх сурвалжийг тодорхой бичихээс гадна, эх хувиар нь тайланд хавсаргаж, фото зураг, бичлэгээр баталгаажуулсан байвал зохино.

Энэхүү аргачлалд тавигдсан шаардлагуудын дагуу системтэй хандаж, тогтоосон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд анализ хийж, түүнээс дам ба хоёрдогч байдлаар үүсэж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тодорхойлон тусгаж, нэгдсэн дүгнэлт гаргаж энд тусгасан байх шаардлагатай.

6. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ: Төслийг хэрэгжүүлэх явцад түүний дээр тодорхойлогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, нөлөөлөлд өртөх гадарга, хэвлий, агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, тусгай хамгаалалттай газар нутаг, түүх, соёлын дурсгал, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийгмийн байдал, эрүүл мэндийн чиглэл бүрээр бууруулах арга хэмжээг тодорхойлсон дүнг тусгана.

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдэд анализ хийж урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах техник, технологи, удирдлага зохион байгуулалт, нөхөн сэргээх (...

хувьд хаалтын үеийн зорилтууд), дүйцүүлэн хамгаалах чиглэлээр ангилж, түүний үр дүнг сайжруулах, уялдаа холбоог хангах, үр дүн, өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой зөвлөмжийг тусгана.

7. Эрсдэлийн үнэлгээ, менежмент: Төслийг хэрэгжүүлэх явцад учирч болзошгүй байгалийн аюул, гамшиг, үйлдвэрлэлийн осол, эрсдэлийн үнэлгээг холбогдох эрх бүхий байгууллагаас батлан мөрдүүлж байгаа аргачлалын дагуу хийж, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тодорхойлон энэ хэсэгт тусгана.

8. Гол үр дүнгүүд ба нэгдсэн дүгнэлт: Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний гол үр дүн буюу тухайн төслийг хэрэгжүүлэх явцад төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм, түүх соёлын үнэт зүйлсүүдэд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөг бууруулах, үр дагаврыг арилгах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ, төслийн хаалтын үеийн зорилтууд, нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговор олгох, хяналт шинжилгээ хийх гол субъектүүд, түүнийг илтгэх үзүүлэлтүүдийг нэгтгэн энэ хэсэгт тусгана.

Мөн төсөл хэрэгжүүлэх явцад байгаль орчныг хамгаалах, нутгийн иргэд оршин суугчдын эрх ашгийг хамгаалах талаар голчлон анхаарах асуудлууд, төслийг хэрхэн хэрэгжүүлбэл илүү үр дүнтэй байх талаар дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж тусгана.

9. Ашигласан материал: Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний хээрийн болон суурин судалгааны явцад цуглуулсан ашигласан бүхий л мэдээ, материал, интернет болон олон нийтийн сүлжээний мэдээллийг тэдгээрийн эх сурвалжуудын хамт жагсаана. БОННУ-ний тайлангийн аль хэсэгт түүнийг ашигласан талаар тэмдэглэгээ хийгдсэн байвал зохино.

4-Р ХЭСЭГ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ
АРГАЧЛАЛ

ГАРЧИГ

4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, шаардлагууд	61
4.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүтэц, агуулга.....	61
4.3 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах нь.....	63
4.4 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах үед олон нийтийн оролцоог хангах нь	67
4.5 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (ТЖБОМТ) боловсруулах нь	68

4.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, шаардлагууд

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (цаашид БОМТ гэх) байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр заасан. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлан төсөл хэрэгжүүлэх зөвшөөрлийг олгох, жил бүрийн хэрэгжилтийн тайланг хянаж дараа жилийн төлөвлөгөөг батлах замаар уг төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хянаж байхаар тус тус зохицуулсан билээ.

Мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд тухайн орон нутгийн байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон байгаль орчны төрийн бус байгууллага хяналт тавих эрхтэй бөгөөд тэдгээрт холбогдох мэдээллээ ил тод болгох, тодорхой хуваарийн дагуу хяналт хийх боломжийг бүрдүүлэх шаардлага мөн тавигдсан.

Дээр дурдсан гол зорилт, шаардлагуудыг хангасан БОМТ-г боловсруулах, хэлэлцүүлэхэд дор дурдсан дараалал, алхам аргуудыг ашиглах, энэ чиглэлээр олон улсын банк, санхүүгийн байгууллагуудад баримталдаг нийтлэг болон тусгай шаардлага, аргачлалуудыг судалж өөрийн орны эрхзүй, эдийн засаг, уламжлал, заншил, онцлогт нийцүүлэн хэрэглэх нь зүйтэй.

4.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүтэц, агуулга

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгасан агуулга бүтэцтэй байх шаардлагатай.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах үйл явц нь нөлөөллийн үнэлгээний судалгаа болон төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, нөлөөллийг бууруулах, нөхөн с:

тодорхойлох шатнаас эхлэх бөгөөд түүнийг оролцогч талуудад танилцуулан, хэлэлцүүлж батлах хүртэл үргэлжилнэ. Менежментийн төлөвлөгөөг боловсруулах явцад нөлөөллийн үнэлгээний судалгаагаар тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөг бууруулах, багасгах, нөхөн сэргээх, хянах, арга хэмжээний талаар төсөл хэрэгжүүлэгч, шийдвэр гаргах, хянах болон бусад оролцогч талуудтай нэгдсэн ойлголтод хүрсний үндсэн дээр төлөвлөх нь цаг хугацаа шаардах боловч төслийг хэрэгжүүлэх явцад үл ойлголцол үүсэх, нэмэлт зардал гарахаас урьдчилан сэргийлэх чухал ач холбогдолтой.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь доорх үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй байна.

Үүнд:

- Төслийн шууд ба шууд бус сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар арилгах, нөхөн сэргээх үйл ажиллагааг тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ);
- Төслийн байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ хэрхэн үр дүнтэй болсон эсэх, шаардлагатай үед нэмэлт арга хэмжээ авах зорилгоор төслийн үргэлжлэх бүх л хугацааны турш хэрэгжүүлэх орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс (ОХШХ) бүрдэнэ.

Байгаль хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө, химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлт, орчны тохижуулалтын (явцын) төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө, түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнах төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүний нөөц, байгаль орчны удирдлагын бүтэц зохион байгуулалтын схем, газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын төслийн хувьд биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, уул уурхайн төслийн хувьд хаалтын зорилт, нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө орно.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийн болон үр дагаврын тархалтын хүрээнд нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн, үзүүлэлтүүдийг тодорхойлж, тухайн орчноос дээж, сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, шинжилгээ хийх давтамж, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгана.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн тодорхой хугацааны үр дүнг төсөл хэрэгжиж эхлэхээс өмнөх байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэлтэй харьцуулан төсөл

өөрчлөлтийг тодорхой давтамжтайгаар гарган сонирхогч талуудад мэдээлэх хугацааг оруулна. Мөн зарим сөрөг нөлөөллийг багасгах, сөрөг үр дагаврыг арилгах, нөхөн сэргээх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг тодорхойлох тоон ба чанарын үзүүлэлтүүд, төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах хууль тогтоомж болон стандартын үзүүлэлтүүдийг нэмж тусгаж болно.

4.3 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах нь

Энэ үе шатанд тухайн төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, үр дагаврыг арилгах арга хэмжээг сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах, газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын төслийн хувьд биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах, уул уурхайн төслийн хувьд хаалтын зорилт, нөхөн сэргээх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг ангилж, гол зорилт, шалгуурыг тогтоосон нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажлын дүнд тулгуурлан боловсруулна. Үнэлгээний тайланд тусгасан байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, арга хэмжээ, хамрах хүрээ, шалгуур үзүүлэлтүүдийг орон нутгийн болон олон нийтийн хэлэлцүүлгийн явцад гарсан саналын дагуу дахин хянаж нарийвчилна. Арга хэмжээний техникийн болон эдийн засгийн гол үндэслэл, шаардагдах баримжаат зардлыг тодорхойлж, хэрэгжүүлэх явцад мөрдөх стандарт, хэм хэмжээг тодруулж менежментийн төлөвлөгөөний төслийг боловсруулна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг дараах үе шатны дагуу боловсруулна.

Үүнд:

- Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үе шатанд тодорхойлсон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, үр дагаврыг арилгах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах, газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын төслийн хувьд биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний ажлын хэмжээ, цар хүрээг нарийвчлан тодорхойлох;
- Дээрх арга хэмжээний өртөг зардлыг зах зээлийн бодит ханшид тулгуурлан тодорхойлох;
- Арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, давтамжийг тодруулах;
- Хэрэгжүүлэх явцад мөрдөх эрхзүйн хэм хэмжээ, стандартын шаардлагуудыг заах;
- Уг арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, оролцох, хянах байгууллага, хариуцлагатныг тогтоох;
- Төслийн сөрөг нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны төлөв байдал, нийгэм, иргэдийн эрүүл мэндийн үзүүлэлтийн

өөрчлөлтийг хэмжих шалгуур үзүүлэлтүүд, тайлагнах хэлбэр, хугацааг тодорхойлох;

- Орчны хяналт шинжилгээний ажлуудыг гүйцэтгэх баримжаат зардлын хэмжээг тодорхойлох зэрэг орно.

Дээрх арга хэмжээ, түүнийг хэмжих нэгж, нийт ажлын хэмжээ, өртөг, хариуцах этгээд, баримтлах стандартыг нэгтгэн төлөвлөлтийн хүснэгтэд оруулах зэрэг болно. Үүнээс гадна тухайн төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хариуцах хүний нөөц, байгаль орчны менежментийн бүтэц зохион байгуулалт, удирдлагын бүтцийн схемийг гаргах, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох байгууллага, талууд, олон нийтэд тайлагнах, түгээх хуваарийг хамтатган боловсруулна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол бүрэлдэхүүн хэсгүүдболон агуулгыг тодруулан дор үзүүлэв.

Үүнд:

*1.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ:*Энэ хэсэгт төсөл хэрэгжих орчны байгаль орчин, нийгмийн төлөв байдал, онцлог, төслийн гол зорилт, хүчин чадал, технологи, түүхий эд материалын ашиглалт, хаягдал, ялгарлын төрөл, хэмжээ, тухайн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон хамгийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, түүнийг бууруулах арга хэмжээний талаар товч дурдана. Улмаар байгаль орчны менежментийн үйл ажиллагааны гол анхаарал татах хэсэг, үндсэн зорилт, хамрах хүрээ, түүнийг гүйцэтгэхдээ баримтлах зарчмын талаар тодорхой тусгана.

Мөн менежментийн төлөвлөгөөний арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал, байгаль орчин, нийгмийн нөлөөллийг хянах хөтөлбөрийн хэрэгжилтийн зардлуудыг нэгтгэн, түүний эх үүсвэрийг зааж оруулах нь зүйтэй.

2.Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө: Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг тодорхойлон нэгтгэж тусгана. Төлөвлөгөөний эх доорх загвартай байна.

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
------------------------------	---	----------------------------	---------------	-----------------------	--------------------------------	------------------------------

3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө: Тухайн төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад төслийн талбай орчмын газрын хэвлий, газрын гадарга, хөрс, гадаргын усан сүлжээ, ургамлан нөмрөгт үүсэх эвдрэлийг техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн арга хэмжээ авч, нөхөн сэргээх ажлын хэмжээ, холбогдох зардлыг төрийн захиргааны төв байгууллагаас баталсан журам, аргачлал, стандарт шаардлагын дагуу нарийвчлан тооцож, тусгана. Ашигт малтмал эрж хайх, олборлох төслийн төлөвлөгөө боловсруулах явцад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох стандартууд тухайлбал, “Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт.Нэр томъёо, тодорхойлолт.” MNS 5914-2008; ”Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал” /MNS 5915-2008/; ”Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт /MNS 5916-2008/; ”Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5917-2008/; ”Эвдэрсэн газрыг ургамалжуулах, Техникийн ерөнхий шаардлага” /MNS 5918-2008/;Газрын тостой холбогдох үйл ажиллагааны үеийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт хийх стандарт зэрэг орно. Төлөвлөгөөний эх доорх загвартай байна.

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
--------------------------	---------------------------	----------------------------	---------------	-----------------------	--------------------------------	------------------------------

4.Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө:Газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртөн нөхөн сэргэхгүй газарт биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргана. Төлөвлөгөөний эх доорх загвартай байна.

Дүйцүүлэх хамгаалах зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
----------------------------	------------------------	----------------------------	---------------	-----------------------	--------------------------------	------------------------------

5.Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө: Тухайн төслийн үйлдвэрлэлийн болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллагыг зайлшгүй нүүлгэх шаардлагатай болсон тохиолдолд тэднийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулна. Ингэхдээ тэдэнд өгөх нөхөн олговрыг хэдийд өгөх, шинэ газарт нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг тэдний саналыг харгалзан хэдийд зохион байгуулахыг тодруулан тусгана. Төлөвлөгөөний эх доорх загвартай байна.

Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
-----------------------	-------------------------------	----------------------------	---------------	-----------------------	--------------------------------	------------------------------

6. *Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө*: Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд хийсэн археологийн судалгаа, түүх соёлын өвийн судалгааны дүн, түүх, соёлын өв дурсгалуудын талаарх нутгийн иргэд, холбогдох байгууллагын мэдээлэлд үндэслэн түүх, соёлын өв дурсгалуудыг хамгаалах төлөвлөгөө боловсруулна. Энэ төлөвлөгөөнд үйлдвэрлэл дэд бүтцийн байгууламжийг барьж байгуулах, ашиглах болон үйл ажиллагааны явцад илэрсэн түүх, соёлын өвийг хэрхэн хамгаалах арга хэмжээ авах талаар тусгана. Төлөвлөгөөний эх доорх загвартай байна.

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
-----------------------------------	-----------------------	----------------------------	---------------	-----------------------	--------------------------------	------------------------------

7. *Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө*: Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, химийн бодисын эрсдэлийн үнэлгээний дүнд тогтоосон аюултай болон хортой химийн бодис алдагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгана. Төлөвлөгөөний эх доорх загвартай байна

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
----------------------------------	--	----------------------------	---------------	-----------------------	--------------------------------	------------------------------

8. *Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)*: Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамжийг тодорхойлон оруулна. Мөн уг ажлын хэмжээг хэмжих нэгж, нэгжийн үнэ, нийт зардал, баримтлах стандарт, аргачлалыг тусгана. Төлөвлөгөөний эх доорх загв:

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа ба давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгжийн өртөг, мян\төг	Нийт зардал, сая.төг/жил	Баримтлах стандарт ба арга, аргачлал	Дээд доод хязгаар
-----------------------------------	-------------	---------	--------------------	----------------------------------	------------------------	--------------------------	--------------------------------------	-------------------

9. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцоогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь: Төсөл хэрэгжүүлэгч жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хагас жил тутамд хүргүүлнэ. Мөн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн сум, багийн иргэдийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх хуваарийг доорх хүснэгтийн дагуу гаргана.

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
--	-------------------------------	--------------------	---------------	---------------------------------	------------------------

4.4 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах үед олон нийтийн оролцоог хангах нь

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоог тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог хууль тогтоомжид заасан хүрээнд аль болох өргөн хангах, тэдэнд ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт болно.

Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран төсөл хэрэгжих орчны байгаль орчин, нийгэм-эдийн засаг, болзошгүй нөлөөллийн бүс дэх оршин суугчдын эрүүл мэндийн байдлын талаарх мэдээлэл, хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төслийн техникийн болон эдийн засгийн гол үзүүлэлтүүд, төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, нөлөөллийн цар хүрээ, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээний талаар болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар үнэн зөв, бодит мэдээлэл бүхий цуврал илтгэл, танилцуулах хуудас,

материалыг бэлтгэн тараана. Мөн тайлангийн эх хувийг тэдэнд танилцах боломжоор нь хангана.

Үүний дараа төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх соёлын өвийг хамгаалах, орчны хяналт шинжилгээ хийх хөтөлбөрүүдийн төсөл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх мэдээллийг тэдэнд хүргэх урьдчилсан хуваарийг тэдэнд биечлэн танилцуулна.

Ингэж тэдэнд төслийн талаар болон түүний гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн талаар, түүнээс урьдчилан сэргийлэх, бууруулах, багасгах, сөрөг үр дагаврыг арилгахад чиглэсэн арга хэмжээний талаар хангалттай мэдээлэл өгсний дараа дээрх арга хэмжээний талаар болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах тэдний саналыг авах тусгайлан бэлтгэсэн асуулгын дагуу авна.

Асуулгын дүнг нэгтгэн, тавигдсан асуудлыг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг боловсруулахдаа нэг бүрчлэн авч үзэж, шаардлагатай арга хэмжээг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгаж тэдэнд энэ талаар танилцуулна.

Олон нийтийн оролцоог хангах талаар хийсэн ажил, санал асуулгын үйл явцыг баримтжуулж нөлөөллийн үнэлгээний тайланд хавсаргана.

4.5 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (ТЖБОМТ) боловсруулах нь

Төсөлд нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний (ТЖБОМТ) төслийг боловсруулах шаардлага тавигдана. Энэ нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоогдсон төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, сөрөг үр дагаврыг арилгах, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалал хийх, хяналт шинжилгээ хийх арга хэмжээнээс төслийн төлөвлөлт, тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө (уул уурхайн төсөл бол тухайн жилийн хайгуулын болон уулын ажлын төлөвлөгөө)-нд үндэслэн энэ жилд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж төлөвлөх үйл явц юм.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа энэхүү аргачлалын 4.3-т тусгасан үе шатыг баримтлан боловсруулах бөгөөд түүнд доорх зүйлсийг нарийвчлан тусгана.

Үүнд:

4.5.1 Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, Техник, технологийн нэмэлт арга хэмжээнүүд тухайлбал, шүүх, тунгаах, цэвэрлэх, саармагжуулах, төмөргүйжүүлэх, хоргүйжүүлэх, цэнгэгжүүлэх, дарж булаах, шатаах, ялгаруулах, нэрэх, нэмэлт тоног төхөөрөмж бэ

4.5.2 Удирдлага, зохион байгуулалт, дотоод дэг журмын талаар авах арга хэмжээ, сургалт, сурталчилгаа хийх, мэдээ, тайлан гаргах, мэдээлэх, мэдлэг чадвар олгохтой холбоотой ажлууд;

4.5.3 “Байгаль орчны удирдлагын тогтолцоо-MNS ISO 14001:2005” стандартын шаардлагыг хангахтай холбогдсон ажлууд: ажиллагсаддаа байгаль орчны талаар мэдлэг, мэдээлэл олгох, үүсч болох эрсдэлийг тооцож, болзошгүй аюул ослын үед авах хариу арга хэмжээнүүдэд дадлагажуулах гэх мэт;

4.5.4 Нөлөөллийг бууруулах, арилгах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах зардлууд, тухайлбал, явцын нөхөн сэргээх арга хэмжээ, түүнд шаардагдах зардал, хатуу, шингэн хаягдлын нэр төрөл, хэмжээ, эх үүсвэр, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, цэвэрлэх, дахин ашиглах, эргүүлэн ашиглах, зайлуулах, устгах, булшлах арга технологид шаардагдах зардал, аюултай хог хаягдлын талаар авах техник технологи, удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах зардал, гал түймрээс сэргийлэх арга хэмжээ, түүнд шаардагдах зардал, болзошгүй аюул, ослоос сэргийлэх арга хэмжээ, түүнд шаардагдах зардал, химийн аюултай, хортой бодисоос сэргийлэх, түүнээс үүдэн гарсан осолд анхны тусламж үзүүлэхэд шаардагдах хөрөнгө зардал, ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, хөдөлмөр хамгааллын талаар авах арга хэмжээ, түүнд шаардагдах зардал;

4.5.5 Төсөл хэрэгжих орчны хүн амыг сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ, түүнд шаардагдах зардал, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах арга хэмжээ, түүнд шаардагдах зардал;

4.5.6 Төслийн хэрэгжилтийн явцад ус, хөрс, агаарт үүсэх бохирдол, байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг бүрт үүсч болзошгүй аливаа өөрчлөлтийг хянах шинжлэх арга, аргачлалууд; хяналт-шинжилгээ хийх хугацаа, сорьц болон хэмжилт хийх цэгийн байршил; шинжилгээний үр дүнг нэгтгэх, тайлагнах, хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцах этгээд, хэрэгжилтийг хангах зардал зэрэг орно.

Үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж буюу төсөл хэрэгжүүлэгчжил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад ирүүлнэ.

Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланд доорх зүйлсийг нэмж тусгасан байх шаардлагатай.

Үүнд:

- Төсөл хэрэгжүүлэгчийн талаарх мэдээлэл, товч танилцуулга, төсөл хэрэгжүүлж буй газрын засаг, захиргааны хангаалал лал бүтэц

зам харилцааны нөхцөл, хэдэн оноос үйл ажиллагаа эхэлсэн, хэд дэх жилдээ ажиллаж байгаа, төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь үр ашигтай байгаа эсэх, цаашид хэдэн жил үйл ажиллагаа явуулах боломжтой тухай, ашиглаж байгаа техник, тоног төхөөрөмжийн болон ажиллах хүчний тухай мэдээллүүд;

- Үйлдвэр, уурхайн үйл ажиллагааны тухай мэдээллүүд тухайлбал, үйлдвэрийн үйл ажиллагаа, технологийн дарааллыг харуулсан схем зураг, товч тайлбар, тайлант жилийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар байгаль орчинд үзүүлсэн сөрөг нөлөөллийн тухай мэдээлэл, шинээр олборлолтод өртсөн газрын хэмжээ, агаар, хөрс, ургамал, усан орчинд үзүүлсэн сөрөг нөлөөлөл, хатуу хог хаягдал, аюултай болон хортой хаягдлын талаарх мэдээлэл, аюул гамшиг, осол, эрсдэлийн тухай тэмдэглэл;
- Төсөл хэрэгжиж буй үйлдвэр, уурхайн орчмын байгаль орчны төлөв байдлын товч мэдээллүүд тухайлбал, газарзүйн бүсчлэлд хамаарах байдал, геологийн тогтоц, цаг уур, уур амьсгалын нөхцөл, гадаргын усан сүлжээ, газрын доорх ус, хөрс, ургамал, амьтны талаарх товч мэдээлэл, тэдгээрт гарсан өөрчлөлтийн талаарх мэдээллүүд орно.

Үүнээс гадна төсөл хэрэгжүүлэгчээс санаачлан төсөл хэрэгжих талбай түүний орчимд хийсэн байгаль орчны талаарх судалгааны мэдээлэл, тайлангууд, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн мэдээлэлд анализ шинжилгээ хийсэн тайлан, дүгнэлт зэргийг хавсаргасан байвал зохино.

5-Р ХЭСЭГ

БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

ГАРЧИГ	
5.1 Зорилго.....	73
5.2 Материал хүлээн авах.....	73
5.3 Үнэлгээний шинжилгээ	73
5.4 Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шийдвэр.....	74
5.5 Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хэрэгжилтэд хяналт тавих	75

5.1 Зорилго

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж үнэлгээний ажлыг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэсэн эсэх, үнэлгээний тайлан үндэслэлтэй, үнэн зөв эсэх, байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь бодит эсэхэд мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах хамгийн хариуцлагатай үйл ажиллагааг үнэлгээний шинжилгээ гэнэ.

Энэхүү аргачилсан заавар нь төсөл хэрэгжүүлэгч, тухайн төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийсэн аж ахуйн нэгж, шийдвэр гаргагч нар үнэлгээний шинжилгээний талаар нэгдсэн ойлголттой байж, үнэлгээний шинжилгээг хуульд заасан хугацаанд хийж, төслийг хэрэгжүүлэх эсэх талаар шийдвэр гаргах явцад ил тод байдлыг хангахад оршино.

5.2 Материал хүлээн авах

Нарийвчилсан үнэлгээ хийсэн аж ахуйн нэгж нь үнэлгээний шинжилгээ хийлгүүлэх хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгчийн зөвшөөрсний дагуу дараах бичиг баримтыг ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.

Үүнд:

- Үнэлгээний шинжилгээ хийлгүүлэх хүсэлт;
- Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн гүйцэтгэлийн тайлан;
- Нарийвчилсан үнэлгээний тайлан;
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (5 жилээр);
- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө зэрэг болно.

Ирүүлэх баримт бичиг нь хэвлэмэл болон цахим хэлбэрээр байх бөгөөд хоёул яг адилхан байх ёстой. Цахим хувь нь дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Баримт бичиг нь PDF формат руу хөрвүүлсэн, файлын хэмжээ нь 50 MB-аас хэтрээгүй байх;
- Дагалдах зургийн файл нь PDF формат руу хөрвүүлсэн байх;
- Файлын нэр нь 15 тэмдэгтээс(үсэг) хэтрээгүй байх зэрэг болно.

Материал хүлээн авч буй шинжээч нь Хавсралт 1-д өгөгдсөн шалгах хуудсыг бөглөж, цахим болон хэвлэмэл хоёр хувийн адил эсэхийг нягтлан шалгаж, хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулна.

5.3 Үнэлгээний шинжилгээ

Үнэлгээний шинжилгээ хэрхэн хийх талаар олон улсад олон төрлийн гарын авлага боловсруулсан бөгөөд бүгд адилхан ямар нэгэн хэлбэрийн магадлан шалгах (shecklists) асуулгыг хэрэглэсэн байдаг. Магадлан шалгах арга нь

нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь хууль тогтоомжийн хүрээнд үнэн зөв хийгдсэн эсэхэд дүгнэлт гаргахад шинжээч болон Мэргэжлийн зөвлөлд туслах зорилготой. Ялангуяа дор дурдсан 3 зорилгыг хангасан байх шаардлагатай.

Үүнд:

- Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бүрэн тодорхойлж, тоон ба чанарын үзүүлэлтийг үнэн зөв үнэлсэн эсэх;
- Төслийн боломжит хувилбарыг (газарзүйн зохимжтой байршил, техник, технологийн зөв шийдэл) зөв сонгосон эсэх;
- Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээг бодитоор төдөвлөсөн эсэх, тэдгээрийн үр дүнд хэрхэн хяналт тавьж чадах эсэх зэрэг болно.

Магадлан шалгах арга нь шинжлэх ухаан, техникийн нарийн ойлголтууд, үнэлгээний явцад хийгдсэн судалгааны ажлын үнэн зөв эсэхэд хариулт өгөх боломжгүй бөгөөд шинжээч нь тодорхой асуудлаар үнэлгээний үнэн зөв эсэхэд эргэлзэж буй бол нарийн мэргэжлийн хөндлөнгийн шинжээчийг томилуулж, туслалцаа авах нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар бүрэн нээлттэй байгаа.

Магадлан шалгах арга нь үнэлгээний тайлангийн дараах бүрэлдэхүүн хэсэгт тавих асуулгаас бүрдэнэ.

Үүнд:

- Төслийн тодорхойлолт;
- Хувилбаруудын сонголт;
- Төслийн зүгээс нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчны тодорхойлолт;
- Төслийн зүгээс үзүүлэх гол болон болзошгүй нөлөөллийн тодорхойлолт;
- Нөлөөллийг бууруулах арга хэмжээний тодорхойлолт;
- Техникийн бус хураангуй зэрэг болно.

5.4 Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шийдвэр

Үнэлгээний шинжилгээ хийхээр томилогдсон шинжээч нь үнэлгээний тайлан, байгаль байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй нарийвчлан танилцаж, магадлан шалгах асуулгыг бөглөнө. Магадлан шалгах асуулгын 80-аас дээш хувь нь хангалттай гэж үнэлсэн тохиолдолд үнэлгээний шинжээч дүгнэлт гарган мэргэжлийн зөвлөлийн ээлжит хуралдаанд оруулж хэлэлцүүлнэ.

Мэргэжлийн зөвлөл нь үнэлгээний тайлан, шинжээчийн бөглөсөн хянан магадлах асуулга, дүгнэлттэй танилцаж, зохих дүгнэлт, шийдвэрийн төслийг гаргана. Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, шийдвэрийн төслийг Ерөнхий шинжээч гарын үсэг зурж баталгаажуулна.

Шийдвэр нь нь дараах хэлбэртэй байна:

Үүнд

- Тодорхой нөхцөл, болзолтойгоор үнэлгээний тайланг баталж, төсөл хэрэгжүүлэхийг зөвшөөрөх. Энэхүү нөхцөл болзол нь эрх зүйн хүчинтэй баримт бичиг болно;
- Төслийг нэмэлт судалгаа, мэдээлэл хэрэгтэй гэж үзээд төсөл хэрэгжүүлэгчид буцаах;
- Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт нь төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн чанар муу байна гэж үзсэн тохиолдолд батлахаас татгалзаж нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжид буцаах;
- Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтээр төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал үндэслэлгүй, эсвэл төсөл нь байгаль орчинд нэн халтай, нөхөх боломжгүй хохирол учруулна гэж үзсэн тохиолдолд батлахаас татгалзаж төсөл хэрэгжүүлэгчид нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжид буцаах зэрэг орно.

5.5 Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хэрэгжилтэд хяналт тавих

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний хэрэгжилтэд тухайн төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, арилгах талаар гаргасан ерөнхий ба нарийвчилсан үнэлгээний шийдвэрт тусгасан тодорхой нөхцөл болзол, байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлж байгаа байдалд төр, захиргааны болон олон нийтийн байгууллага, иргэдийн зүгээс хяналт тавина.

Нөлөөллийн үнэлгээний хэрэгжилтэд олон нийтийн оролцоо, иргэдийн хяналтыг дараах хэлбэрээр хэрэгжүүлнэ.

Үүнд:

- Төсөл хэрэгжиж буй нутгийн иргэд, төрийн бус байгууллага өөрийн хүсэлтээр байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилттэй танилцах хүсэлт тавих. Төсөл хэрэгжүүлэгч нь нөлөөллийн үнэлгээтэй холбоотой бичиг баримтын хүчин төгөлдөр хувийг төслийн үйл ажиллагаа явагдаж буй газар нутгийн салбар нэгж дээр хадгалж байх ба иргэдийг мэдээлэл авах боломжоор хангана.
- Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн талаар төсөл хэрэгжиж буй орон нутгийн иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулна.
- Төслийг хэрэгжүүлэх явцад тухайн нутаг дэвсгэрт оршин суугаа иргэдийн амьдрах нөхцөл болон байгаль орчинд үзүүлж байгаа сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах, арилгах талаарх саналаа харъяалах нутаг дэвсгэрийн мэргэжлийн хяналтын газарт тавьж шийдвэрлүүлнэ.

Төр, захиргааны байгууллагын зүгээс тавих хяналт нь дараах хэлбэртэй

байна.

Үүнд:

- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.13.-д заасан хөндлөнгийн хяналт;
- Иргэдийн мэдээллийн мөрөөр хийгдэх харъяалах нутаг дэвсгэрийн мэргэжлийн хяналтын байгууллагын шалгалт;
- Хэрэв төсөл хэрэгжүүлэгч нь байгалийн нөөц баялгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа бол Байгаль хамгаалах тухай хуулийн 10.1.-д заасан байгаль орчны аудит;
- Төрийн аудитын байгууллагаас байгууллагын санхүүгийн болон гүйцэтгэлийн аудит зэрэг болно.

Төрийн байгууллагын зүгээс хийсэн хяналт шалгалтын дүнгийн хувийг байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн төрийн байгууллагад ирүүлэх ба түүнийг нөлөөллийн үнэлгээний мэдээллийн нэгдсэн санд тавина.

4-р Хавсралт. Үнэлгээний шинжилгээний магадлан шалгах хуудас

Төслийн нэр:

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, байршил:

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг:

Холбоо барих утас, И-мэйл хаяг:

Төсөлд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэсэн компаний нэр, хаяг:

Холбоо барих утас, И-мэйл хаяг:

	Гол шалгуурууд	Чухал эсэх	Хангалттай эсэх	Үндэслэл, тайлбар
Үнэлгээний хууль, тогтоомж, журмын мөрдөлт	Төслийн хэрэгжүүлэгч, байршил, талбайн ерөнхий төлөвлөлт, дэд бүтцийн байгууламжуудын шийдэл, техник, технологи, ашиглагдах химийн хорт болон аюултай бодисуудын жилд хэрэглэх хэмжээ, зориулалт, хүчин чадал, төслийн үе шатуудын үргэлжлэх хугацаа, эдийн засгийн гол үзүүлэлтүүд, хаалт, нөхөн сэргээлтийн талаар тодорхой тусгасан эсэх			
	Төслийн баримт бичигт нөлөөллийн шинжилгээ хийж, түүнийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн төлөв байдалд сөргөөр нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлсон эсэх			
	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тодорхой аргазүй, аргачлалаар үнэлж сөрөг нөлөөллийн цар хүрээ, эрчим, түвшинг тооцож, сөрөг нөлөө хамгийн багатай хувилбарыг тогтоосон эсэх			
	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, боломжит бага хэмжээнд хүртэл бууруулах, сөрөг нөлөөллийн үр дагаврыг арилгах, нөхөн сэргээх арга хэмжээг тодорхойлсон эсэх			
	Биологийн олон янз байдлын үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тодорхойлсон эсэх			
	Эрсдэлийн үнэлгээ хийж, учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, үнэлсэн эсэх			
	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөг боловсруулсан эсэх			
Ерөнхий үнэлгээний дүгнэлт, үнэлгээний	Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудаст заасан нарийвчилсан үнэлгээний явцад тодруулах асуудлууд, онцгойлон анхаарах			

	Гол шалгуурууд	Чухал эсэх	Хангалттай эсэх	Үндэслэл, тайлбар
аргачлалын хүрээнд боловсруулсан эсэх	чиглэлийг харгалзан байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг боловсруулсан эсэх			
	Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг хууль, журамд заасан бодлогын баримт бичиг, төслийн анхан шатны баримт бичгийг боловсруулах үе шатанд төлөвлөж буй төслийн цар хүрээ, үйл ажиллагааны онцлогтой уялдуулан нөлөөлөлд өртөж болзошгүй нутаг дэвсгэрийг бүрэн хамруулсан эсэх			
	Байгаль орчны төлөв байдлын үнэлгээг тухайн салбарын шинжлэх ухааны судалгааны хамгийн сүүлийн үеийн аргазүйг баримтлан, үнэн зөв мэдээлэлд тулгуурлан гүйцэтгэсэн эсэх			
	Үнэлгээний явцад хэмжилт дээжлэлтийг зохих аргачлал, стандартын дагуу хийсэн эсэх			
	Холбогдох мэдээллийг боловсруулсан аргазүй, мэдээлийн эх сурвалжийг тайлан мэдээндээ тодорхой тусгасан эсэх			
	Олон улсын банк, санхүүгийн байгууллагаас (дэлхийн банк, олон улсын санхүүгийн корпораци, Европын сэргээн босголт, хөгжлийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг) тавьдаг нийтлэг шаардлагуудыг хангасан эсэх			
Үнэлгээний үр дүн тайланд бүрэн туссан эсэх талаар	Хэмжилт, дээжлэлтийн үр дүнд тайлал хийсэн эсэх			
	Агаар, гадаргын болон газар доорх усны загварчлал ажиллуулж, үр дүнд тайлал хийсэн эсэх			
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, тайланд тусгасан эсэх			
Үнэлгээний ажилд ашигласан материалын эх сурвалж,	Хээрийн судалгааны үед хэмжилт, дээжлэлт, судалгаа, уулзалт, ярилцлага хийж буйг фото зураг, дүрс бичлэгээр баталгаажуулсан эсэх			

	Гол шалгуурууд	Чухал эсэх	Хангалттай эсэх	Үндэслэл, тайлбар
	Хээрийн хэмжилт, дээжлэлтийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн багаж, төхөөрөмжийг ашиглан хэмжилт, дээжлэлт хийж буйг фото зураг, дүрс бичлэгээр баталгаажуулсан эсэх			
	Хээрийн хэмжилт, дээжлэлтэд ашигласан багаж, төхөөрөмжийн танилцуулга, баталгаажилт хийлгэх шаардлагатай багаж бол баталгаажилт хийсэн байгууллагаас олгосон гэрчилгээний хуулбарыг хавсаргасан эсэх			
	Дээжний лабораторийн албан ёсны үр дүнг хавсаргасан эсэх			
	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулсан үр дүнг фото зураг, видео бичлэг, протоколдсон эсэх, албан бичгээр санал авсан эсэх			
Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүний техникийн бус хураангуйг боловсруулсан эсэх	Үнэлгээний ажлын гол үр дүн, сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, арилгах арга хэмжээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилтуудыг тусгасан техникийн бус хураангуйг олон нийт, оролцогч талуудад ойлгомжтой байх энгийн үг хэллэгээр тусгайлан боловсруулж тайланд хавсаргасан эсэх			
Дүн				
Ерөнхий дүгнэлт				

Нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд шинжилгээ хийсэн:

Шинжээч\ Мэргэжилтний овог, нэр:

Албан тушаал:

Гарын үсэг:

Огноо:

Хянасан:

БОУАХ-ийн дарга\ахлах мэргэжилтний овог, нэр:

Гарын үсэг:

Огноо:

1.1 Үйлчилгээний салбарын онцлог, түүнийг нөлөөллийн үнэлгээнд авч үзэх нь

Үйлчилгээний байгууллагын үйл ажиллагаа нь хүний нийгмийн хэрэгцээг хангахад чиглэсэн, бизнесийн тодорхой зорилготой байх тул ямарваа үйлчилгээ эрэлтэд тулгуурлан, зах зээл үүсгэн зохион байгуулагдана.

Үйлчилгээ нь улс орны бие даасан салбар болон хөгжиж байгаа бөгөөд “үйлчилгээ” гэдэг ойлголтод ажүйлдвэр, хөдөөажухуйнбүтээгдэхүүнийүйлдвэрлэл болон ашигтмалтмалын олборлолтоос бусад бүх үйл ажиллагааг хамруулан авч үздэг. Өөрөөр хэлбэл, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэгдсэн, тодорхой өртөг агуулсан цогц үйл ажиллагааг үйлчилгээ гэнэ.

Үйлчилгээг хэрэглээний, нийгмийн, үйлдвэрлэлийн, хуваарилалтын гэсэн 4 хэсэгт хуваан үздэг. Үйлчилгээ нь үл мэдрэгдэх, үл хуваагдах, холимогижбүрдэл, үл саринах буюу үлхадгалагдах гэсэн онцлог шинжүүдээрээ биет бараа бүтээгдэхүүнээс ялгаатай.

Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийг уул уурхай, дэд бүтэц, хөдөө аж ахуй үйлдвэрлэл, үйлчилгээ гэсэн 4 чиглэлээр олгодог. Иймээс дээрх чиглэлтэй нягт уялдуулах шаардлагатай тул үйлчилгээний салбарын БОННУ-ний аргачлалыг сонгон авч үзэв.

Үйлчилгээний байгууллагуудаас байгаль орчинд хамгийн их асуудал үүсгэх төрөл нь аялал жуулчлалын үйлчилгээ бөгөөд зорилго, үзүүлэх үйлчилгээ, хамрах цар хүрээ, байршил зэрэг олон зүйлээрээ хотжисон үйлчилгээний салбараас ялгаатай.

Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь улирлын онцлогоос ихээхэн хамааралтай бөгөөд ТХГН болон байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн явагддаг тул байгаль орчинд тодорхой хэмжээний сөрөг нөлөө үзүүлнэ. Иймд БОННУ-ний хүрээнд үүсч болзошгүй сөрөг нөлөөллийг нарийвчлан тогтоож, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээг оновчтой төлөвлөн хэрэгжүүлэх нь чухал юм.

Аялал жуулчлалын төслийн БОННУ-нд гол анхаарч үзэх асуудал нь төслийн байршил, барилга байгууламж, хүчин чадал, тухайн газар нутгийн даац, аяллын маршрут зэрэг юм. Мөн аялал жуулчлал нь ТХГН, түүний орчны бүсэд амьдардаг иргэдийн хувьд эдийн засгийн нэмэлт ашиг орлого олох үндсэн эх үүсвэр нь болдог. Иймээс БОННУ-ний үр дүнд тулгуурлан аялал жуулчлалыг хөгжүүлэхэд нутгийн иргэдийн оролцоо, байгалийн нөөц боломж, ялангуяа ТХГН-ийн даацыг бодитойгоор үнэлж тогтоох нь нэн чухал. Мөн

аяллын хөтөлбөр, маршрут нь байгаль хамгааллын зорилго, байгалийн үнэ цэнэт зүйлсийг хамгаалах үндсэн чиглэлтэй хэрхэн уялдаж байгаад үнэлэлт, дүгнэлт өгөх шаардлагатай.

1.2 Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ

Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг төслийн төлөвлөлтийн эхний үе шатанд хууль тогтоомж, судалгааны материал, техник технологи, стандарт, норм норматив, анхдагч мэдээ, тоо баримтад тулгуурлан хийх бөгөөд тухайн төслийн байгаль орчинд учруулах сөрөг үр дагаварыг урьдчилсан байдлаар тогтоож, цаашид БОННУ хийх шаардлагатай, эсэхийг тодорхойлох үйл ажиллагаа юм.

1.2.1 Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хариуцан гүйцэтгэгч

Ерөнхий үнэлгээг төслийн цар хүрээнээс хамааруулан “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хуулийн хавсралтад заасан ангиллын дагуу байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын шинжээч хариуцан гүйцэтгэнэ.

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хуулийн хавсралтад заасан ангиллаар улсын тусгай хамгаалалттай газрын хилийн цэсэд хэрэгжих төслийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шинжээчид хийж гүйцэтгэнэ. Харин орон нутагт ажиллаж буй шинжээчид аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын орон нутгийн хамгаалалтад авсан газруудын нутаг дэвсгэрт хэрэгжих төслийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийнэ.

1.2.2 Үйлчилгээний төсөлд ерөнхий үнэлгээ хийлгэхээр хүсэлт гаргах

Иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь дараах материалыг бүрдүүлэн ерөнхий үнэлгээ хийлгэхээр байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хандана. Үүнд:

- Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий үнэлгээ хийлгэх тухай хүсэлт /албан бичиг/;
- Холбогдох эрх бүхий байгууллагаар баталгаажсан техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл;
- Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хөтөлбөрт тусгагдсан эсэх /газрын зөвшөөрөл, ТХГН-т байрлах бол Хамгаалалтын захиргааны санал/;
- Төслийн товч тодорхойлолт;

- Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт, /ТХГН-т байрлах бол байгаль орчны төлөв байдлын үнэлгээний тайлан/;
- Тухайн сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт;
- Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар батлуулсан байх/;

Ерөнхий үнэлгээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр томилогдсон шинжээч хийнэ.

1.2.3 Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийхэд анхаарах асуудал

Тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжих төслийн байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийх явцад шинжээч дараах асуудлыг анхааран үзэх шаардлагатай. Үүнд:

1. Тухайн төсөл нь “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” болон “Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай” Монгол Улсын хууль, бусад хууль тогтоомжийн шаардлагад нийцэж байгаа эсэх;
2. Тусгай хамгаалалттай газраас тодорхой зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглах гэж буй Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын баримт бичиг нь хүчин төгөлдөр мөрдөж буй хууль, эрх зүйн шаардлагад хэр нийцэж байгаа эсэх;
3. Тухайн төслөөс тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль орчны төлөв байдал, биологийн олон янз байдалд үзүүлэх сөрөг нөлөөлөл, тусгай хамгаалалттай газар нутгийн байгалийн төрх байдлыг хэрхэн өөрчлөх;
4. Дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүс, байгалийн нөөц болон дурсгалт газрын нутаг дэвсгэрт оршиж буй байгалийн өвөрмөц тогтоц, геологийн хурдас, нэн ховор, ховор ан амьтан, ургамлын зүйл, булш бунхан, хадны сүг зураг, эртний хүмүүсийн бууц, чулуун зэвсгийн үйлдвэрлэлийн ул мөр, бичээс, буган ба хүн чулуун хөшөө, эртний хот, суурингийн туурь зэрэг түүх соёлын дурсгалт зүйлст тухайн төслийн үйл ажиллагаа хэрхэн нөлөөлөх.

Дээрхээс гадна аялалын маршрутыг тогтоох, ус хангамжийн найдвартай эх үүсвэрийг сонгох, хатуу хог хаягдал болон ахуйн бохир усыг байгаль орчинд халгүйгээр зайлуулах, бохир усны цооног, хог хаягдлын цэг, бие засах газрын байршлыг зөв тогтоох, түүнчлэн барилга байгууламж, шугам сүлжээ, зам, бохир усны цооног, бие засах газар, автомашины зогсоол байгуулахад өртөж эвдэрсэн газрыг засаж тэгшлэх, нөхөн сэргээх зэрэг асуудлуудыг харгалзаж үзэх шаардлагатай.

Манай улсад хэрэгжиж буй аялал жуулчлалын төслийн олонх нь тусгай хамгаалалттай газар нутагт оршдог. Тухайлбал, Богдхан уулын дархан цаазат газар, Хөвсгөл болон Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газруудад аялал жуулчлалын баазууд төвлөрсөн байдаг. Тиймээс аялал жуулчлалын төслийн

байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийхэд тусгай хамгаалалттай газар нутгийн онцлог шаардлагууд, хамгаалалтын горим, байгаль орчны өвөрмөц байдлыг нь харгалзан үзэхээс гадна дээрх газруудад бүс нутгийн шинжтэйхуримтлагдах нөлөөлөл үүссэн эсэхийг тодруулж, хэрэв үүссэн бол хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийлгэнэ.

Ерөнхий үнэлгээг хариуцан гүйцэтгэсэн шинжээч дээрх асуудлуудыг харгалзан үзэж, байгаль орчны нөлөөллийн үнэлгээний ерөнхий аргачлалын 2-р хавсралтад тусгасан “Ерөнхий үнэлгээний гүйцэтгэлийн хуудас”-ын дагуу үнэлгээний ажлын үр дүнг нэгтгэн дүгнэлт гарна.

1.3 Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ нь тухайн төслийг хэрэгжүүлснээс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлох, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ, төслийн оновчтой хувилбарыг тогтоох үйл ажиллагаа юм.

1.3.1 Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний судалгаа

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний судалгааны үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Төслийн техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төслийн байршил, хэрэгжих орчны тойм зураг, газрын зөвшөөрөл, төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлын тодорхойлолт, ТХГН-т байрлах бол Хамгаалалтын захиргааны санал зэрэг холбогдох баримт бичигтэй танилцах;
- Төсөлтэй холбогдох бодлого, хууль, эрх зүйн зохицуулалтыг судлах;
- Төсөл хэрэгжих орчны талбайд байгаль орчны төлөв байдлын судалгаа хийх, судалгааны явцад нийгэм, хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтийн суурь мэдээллийг нарийвчлан тодруулах, мөн цуглуулсан мэдээлэл нь хээрийн хэмжилт, тооллого, ажиглалт, судалгаа, фото зураг, газарзүйн солбицол, лабораторийн шинжилгээний үр дүнгээр баталгаажсан, байр зүйн болон газарзүйн мэдээллийн системийн зураглалд тулгуурласан байх;
- ТХГН-т байрлах бол судалгаа, шинжилгээний үр дүнд тулгуурлан байгаль орчны төлөв байдлын тайлан боловсруулах;
- Төслөөс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учруулж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлж, үнэлэх;
- Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн холбогдох байгууллагууд, төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, олон нийтийн саналыг авах зэрэг болно.

Аялал жуулчлалын төслийн хувьд байгаль орчны төлөв байдлын үнэлгээг БОННУ-ий хүрээнд хийх бөгөөд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны суурь нөхцөл, тухайлбал, газарзүй, геологийн тогтоц, уур амьсгал, хөрс, ус, агаарын чанар, гадаргын болон газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, мөн түүнчлэн нутгийн иргэд, оршин суугчид, тэдний нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшин, эрүүл мэнд, байгаль, түүх соёлын өвийн өнөөгийн төлөв байдлыг судалгаа, шинжилгээ хийсний үндсэн дээр тогтоож, цаашид анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлно.

Нарийвчилсан үнэлгээний судалгааны ажлыг байгаль орчны нөлөөллийн үнэлгээний ерөнхий аргачлалын дагуу явуулна.

Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний явцад төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн засаг захиргаа, төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдтэй уулзалт ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулах, олон нийтээс санал асуулга авах, төслийн талаарх мэдээллийг төслийн төлөвлөлтийн эхний үе шатанд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн соёл, зан заншилд нийцүүлэн аль болох хүртээмжтэй, нээлттэй байдлаар хүргэнэ.

БОННУ-ий эхний үе шатанд тухайн төслийн давуу болон сул талыг олон нийтэд ил тод мэдээлснээр төсөл хэрэгжих явцад үүсэж болзошгүй аливаа асуудлуудыг олон нийт тунгаан хэлэлцэж, дүгнэлт хийх, өөрсдийн санал бодлыг нээлттэй илэрхийлэх боломжийг бүрдүүлнэ.

1.3.2 Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлох

Аялал жуулчлалын төсөл нь үйлчилгээний салбарын олон талт байдал, төрлүүдийг өөртөө багтааж, ТХГН болон ус, ургамал тэгширсэн байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн хэрэгждэг бөгөөд аялал жуулчлалын салбарын хурдацтай хөгжил, хэт төвлөрөл нь ТХГН-ийн экосистем, байгаль орчны төлөв байдлыг өөрчилж, даацыг хэтрүүлснээс тухайн газар нутгийн унаган байдлыг алдагдуулдаг. Түүнчлэн хот хоорондын болон орон нутгийн автозамын дагуу нийтийн бие засах газар байхгүй, эсвэл байгаа цөөн хэд нь цоожтой байдгаас ил задгай бие засах, мөн хогийн савыг хүрэлцэхүйц тоогоор байрлуулаагүйгээс хог хаягдал хаях зэргээр маршрутын аялал зохион байгуулах үед орчны бохирдол үүсгэдэг. Иймээс байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэх эрх бүхий аж ахуйн нэгжийн мэргэжилтүүд болон экспертүүд тухайн төслийн баримт бичиг, тодорхойлолт, техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, аяллын маршрут, ажлын удирдамжтай нарийвчлан танилцаж, төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлно.

Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тодорхойлохдоо төсөл хэрэгжих нутаг дэвсгэр болон түүний ойр орчимд сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй түүх, соёлын үнэт зүйлс, дурсгалт газар, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутаг, байгалийн үзэсгэлэнт газар байгаа эсэхийг тодруулна.

1.3.3 Төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг үнэлэх

Тухайн төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг үнэлэхдээ нөлөөлөлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нутгийн оршин суугчид, түүх, соёлын өвд бий болох сөрөг үр дагавар, түүний эрчим, цар хүрээ, шууд болон шууд бус нөлөөллүүд, болзошгүй хуримтлагдах нөлөөллийг Монгол улсын хууль тогтоомжид заасан болон олон улсын нийтлэг аргуудыг ашиглан үнэлнэ.

Эдгээрт зориулалтын буюу экспертийн үнэлгээний арга, удирдамж-гарын авлагын арга, магадлан жагсаах арга, матрицын арга, газар зүйн мэдээллийн системийн цаг хугацаа, орон зайн давхцуулан зураглах арга, сүлжээ, схемийн арга, эрсдэлийн үнэлгээний аргууд, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний аргууд, зардал/үр ашгийг үнэлэх арга, математик загварчлал зэрэг аргууд орох бөгөөд аргууд нь өөр өөрийн давуу болон дутагдалтай талуудыг агуулдаг тул тэдгээрийг тухайн нөхцөлд тохируулан сонгож хэрэглэнэ.

Дээрх аргуудын гол тодорхойлолт, зориулалт, эх сурвалж, үр дүнгийн талаар Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний ерөнхий аргачлалд тодорхой тусгасан тул тэндээс харж болно.

1.3.4 Сөрөг нөлөөллийг бууруулах,арилгах арга хэмжээг тодорхойлох

Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, сөрөг үр дагаврыг арилгах арга хэмжээг тодорхойлохдоо байгаль орчинд халгүй, дэвшилтэт техник технологийг ашиглах, төслийн үйл ажиллагаа нь хууль тогтоомж, журам, стандарт, норм нормативаар тогтоосон хэм хэмжээнээс хэтрэхгүй байх, ажиллагсдын болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндэд эрсдэл учруулахгүй байх шалгуурыг хангасан байвал зохино.

Байгалийн нөөц баялгийн үнэ цэнийг бууруулах, байгаль орчинд бохирдол, элэгдэл, эвдрэл, хохиролучруулах тохиолдолд үүссэн хохирлыг нөхөн төлөх арга хэмжээ нь нөлөөллийг бууруулах болон арилгах арга хэмжээнд нэгэн адил хамаарна.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд төслийн үйл ажиллагаанаас учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрээр нарийвчлан тодорхойлж, зөвлөмж боловсруулахын зэрэгцээ түүнд шаардагдах зардлыг бодитойгоор тооцож төлөвлөн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгана.

1.3.4 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах

Манай улсын хувьд дүйцүүлэн хамгаалах тухай ойлголт нь шинэлэгзүйл бөгөөд “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11 болон 9.6-д дүйцүүлэн хамгаалал хийх тухай заалтууд шинээр орсон.

Дүйцүүлэн хамгаалах аргын гол зорилго нь биологийн төрөл зүйл, олон янз байдлыг хамгаалан авч үлдэхэд, тэдгээрийн амьдран орших нөхцөл байдлыг төсөл хэрэгжих талбайгаас өөр газар, орон зайд бүрэлдүүлэх замаар дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг судалгаа, төлөвлөлт, зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх явдал юм.

Дүйцүүлэн хамгаалахын тулд юуны түрүүнд тухайн төслийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлох, хаана, ямар ховор амьтан, ургамал болон хамгаалах шаардлагатай амьдрах орчин, гол ус, бэлчээр нутаг байгааг шинжлэх ухааны үндэслэлтэй судалгааны үндсэн дээр гаргаж ирнэ. Байгаль хамгааллын хувьд чухал ач холбогдолтой газрууд, амьтан, ургамлыг зураглалд оруулж, тухайн төсөл хэрэгжих талбайд болон түүний нөлөөллийн бүсэд хамгаалах шаардлагатай амьтан, ургамал, тэдгээрийн амьдрах орчин автаж байна уу гэдгийг тогтоож, тэдгээрийг яаж, хаана, хэрхэн дүйцүүлэн хамгаалж болох вэ гэдгийг тооцож гаргана.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд байгаль хамгааллын талаар дараах 3 зарчмыг баримтална:

1. Экологийн хувьд үнэ цэнтэй газруудад зөвшөөрөл олгохоос аль болох зайлсхийх;
2. Нөлөөллийг бууруулж, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх;
3. Нөхөн сэргээх боломжгүй үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах (Энэ нь нөлөөлөлд өртсөн тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд байгаа өөр газрыг нөхөн хамгаалах гэсэн үг).

1.3.5 Нарийвчилсан үнэлгээний явц дахь олон нийтийн оролцоо

БОННУ-ний тайланд тусгасан олон нийтийн оролцоотой хийж гүйцэтгэх ажлууд нь тэдний санал, шүүмжид үндэслэх бөгөөд төлөвлөсөн арга хэмжээ нь хэр бодитой болох, мөн дэвшүүлсэн асуудлыг бүрэн хэмжээнд зохистойгоор шийдвэрлэхэд хангалттай байж чадах эсэхийг тодорхойлно.

Олон нийтийн оролцоог хангахын тулд төсөлтэй холбогдох мэдээллийг урьдчилан тараах, зар мэдээ хүргэх, төслийн нөлөөлөлд өртөгчид/оролцогч Талуудтай уулзалт ярилцлага, хурал зөвлөлгөөн зохион байгуулж, санал асуулгыг хэзээ, хаана, хэрхэн авсан талаарх мэдээлэл (хурлын тэмдэглэл, протокол г.м), оролцогч Талуудын ирцийн мэдээ зэргийг тайланд хавсаргана.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах явцад төсөлхэрэгжихнутагдэвсгэрийн засаг захиргаа, төслийннөлөөлөлдөртөж болзошгүй иргэд, олон нийтээс авсан саналыг нэгтгэн боловсруулж төлөвлөгөөнд тусгаж, түүний хэрэгжилтийн шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой болгоно.

БОННУ-ний тайланг боловсруулж дууссаны дараа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх, мөн төсөл хэрэгжих нутаг дэсгэрийн засаг захиргаа, эсвэл ИТХ-ын саналыг авч, тайланд хавсаргана.

1.3.6 Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор БОННУ хийсэн байгууллага боловсруулна.

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” Монгол Улсын хуульд заасны дагуу ерөнхий үнэлгээ хийсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталснаар төслийг хэрэгжүүлэх зөвшөөрөл олгогдоно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд түүнийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан аргачлалын дагуу боловсруулна.

1.4 Төсөл хэрэгжүүлэгчид тавигдах шалгуур үзүүлэлтүүд

Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүд нь байгаль орчныг хамгаалах шаардлагын үүднээс тодорхой шалгууруудыг хангасан байх шаардлагатай тул байгаль орчны нөлөөллийн үнэлгээний явцад харгалзан үзэх болон тэдний зайлшгүй хангасан байвал зохих шалгуур үзүүлэлтүүдийг дараах хүснэгтэд тоймлон үзүүлэв.

БОНУ-ний явцад төсөл хэрэгжүүлэгчид тавигдах шалгуур үзүүлэлтүүд

Хамрах хүрээ	Харгалзах зүйлс	Шалгуур үзүүлэлтүүд
Хууль, эрх зүйн орчин	<i>Аялал жуулчлал эрхлэх зөвшөөрөл</i>	“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн дагуу аялал жуулчлалынүйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байх;

	<i>Аялал жуулчлалын төрөл</i>	Аялал жуулчлалын тодорхой төрлийг сонгосон байх;
	<i>Төсөл хэрэгжүүлэх газар нутгийн сонголт</i>	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь ТХГН, түүний орчны бүсэд хамрагдаж буй эсэх;
		Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр нь тухайн үед ТХГН-т хамаарахгүй байгаа боловч засгийн газрын холбогдох агентлаг, бусад сонирхогч талуудын зүгээс тухайн газрын төрөл зүйлийг эн тэргүүнд хамгаалалтад авах шаардлагатай гэж үзэж байгаа эсэх;
		“Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай” болон “Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай” хуулиудтай нийцсэнэсэх;
		Төсөл хэрэгжих ТХГН-ийн даацыг тодорхойлсон эсэх;
	<i>ТЭЗҮ буюу төсөл, менежментийн төлөвлөгөө</i>	Аялал жуулчлалын үйл ажиллагаа эхлэхийн өмнө ТЭЗҮ буюу төсөл боловсруулах, менежментийн төлөвлөгөөтэй байх;
Байгаль орчин	<i>Газар ашиглалт, газрын менежментийн зохистой байдал</i>	Зөвшөөрөгдсөн газарт үйл ажиллагаа явуулах;
		Газар ашиглалтын зориулалтыг өөрчлөхгүй байх;
		Тухайн төслөөс байгаль орчны төлөв байдал, биологийн олон янз байдалд учруулах сөрөг нөлөөлөл;
		ТХГН-т үйл ажиллагаа явуулж буй жуулчны баазуудын нягтшил;
		Аялал жуулчлалын зориултаар ашиглах газрын зохистой менежмент;
	<i>Тээврийн хэрэгсэл</i>	Ашиглах тээврийн хэрэгслийн төрөл;
		Аялал жуулчлалын гол үзмэр, сайтуудад тээврийн хэрэгслээр хүрэх боломж;
		Тээврийн хэрэгслээс үүдэн бий болох сөрөг нөлөөлөл;
	<i>Эрчим хүчний хэрэглээ, сэргээгдэх эрчим хүч</i>	Эрчим хүчний эх үүсвэр;
		Сэргээгдэх эрчим хүчний ашиглалт;
	<i>Усны хэрэглээ, усны нөөц, чанар</i>	Ус хангамжийн эх үүсвэр, ус хэрэглээ;
		Усны нөөц, чанар
		Бохир ус зайлуулах, цэвэрлэх технологи
	<i>Хог хаягдлын менежмент</i>	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөтэй эсэх;
Хог хаягдлын цэгийн байршил (зочны гэр болон барилга байгууламжаас 60 м-ээс багагүй зайд, зонхилох салхины доод зүгт байрлуулах);		
Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг ангилан ялгаж хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт нийлүүлэхээр төлөвлөсөн эсэх;		

	Биологийн олон янз байдал	Аялагч, жуулчдын үйл ажиллагаанаас үүдэлтэй биологийн олон янз байдлын хомсдол;
		Биологийн олон янз байдалд учруулах нөлөөлөл;
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчинд нэн ховор болон устаж буй биологийн төрөл зүйлүүд байгаа эсэх;		
	Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны менежмент	Байр сууц, барилга байгууламж барьж байгуулах болон аялал жуулчлал эрхлэх үйл ажиллагааг байгаль орчинд ээлтэй байдлаар төлөвлөсөн эсэх;
		Аялагч, жуулчдын зорин очих газрууд, голлох үзмэрүүдэд хүрэх зам маршрутын тэмдэг, тэмдэглэгээ;
		Аялал жуулчлалын эко бүтээгдэхүүн (жуулчдад үзүүлэх аялал жуулчлалын төлбөрт үйлчилгээ)-ийг хэрэгжүүлэх эсэх;
		Байгаль орчин, түүх соёлын өв, уламжлалт ёс заншлыг хамгаалах талаар төлөвлөсөн эсэх;
		Байгалийн гамшгаас сэргийлэх төлөвлөгөөтэй эсэх;
Эдийн засаг	Орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр	Орон нутгийн эдийн засагт оруулах хувь нэмэр;
		Жижиг, дунд бизнесийг хөгжүүлэхэд оруулах хувь нэмэр;
		Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэхэд оруулах хувь нэмэр;
	Төслийн хөрөнгө оруулалт, эдийн засгийн чадамж	Аялагч, жуулчдын төлж буй төлбөр, татвараас ТХГН-ийг хамгаалах, хөгжүүлэхэд оруулах хувь нэмэр;
		Байгаль орчныг хамгаалах, бохирдол, эрсдэлийг бууруулах, арилгах зардлыг санхүүжүүлэх хөрөнгийн баталгаа;
Нийгэм, хүний эрүүл мэнд	Нийгмийн аюулгүй байдал, эрүүл мэнд	Хүн амын хэт төвлөрөлүүсэх эсэх;
		ТХГН-ын талаарх хууль тогтоомж, дүрэм журам болон өөрийн үйл ажиллагааны талаар мэдээлэл, сурталчилгаа хийхээр төлөвлөсөн эсэх;
	Нийгмийн аюулгүй байдал, хүний эрүүл мэндийг хамгаалах талаар төлөвлөсөн эсэх;	
Түүх, соёл	Түүх соёл, ёс заншил	Нүүдэлчний соёл, уламжлалт ёс заншлыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон ашиглах асуудлыг оновчтой төлөвлөсөн эсэх;

		Түүх, соёлын дурсгалт эд өлгийн зүйлсийг байршлаас нь шилжүүлэх эсэх;
		Уламжлалт соёл, ёс заншил алдагдах, гадны соёлыг хэт даган дуурайхаас сэргийлэх талаар төлөвлөсөн эсэх

ТӨГСӨВ